

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВЭРЛЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧДЫН ТЕХНОЛОГИЙН НЭГДСЭН ГОРИМД АШИГЛАСАН НЭР ТОМЬЁО

“Төмөр замын тээврийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгийн нэр томьёоны тодорхойлолт

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

4.1 Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурьдсан утгаар ойлгоно:

4.1.1 “Төмөр замын тээвэр” гэж иргэн, хуулийн этгээдэд төмөр замын тээврийн үйлчилгээ үзүүлэх, тээвэрлүүлэгчийн эрэлт хэрэгцээг хангахад зориулагдсан дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн, бусад байгууламж, тоног төхөөрөмж бүхий тээврийн үйлдвэрлэл, угсралт, засвар, үйлчилгээний технологийн иж бүрдлийг;

4.1.2. “төмөр замын тээвэрлэлт” гэж ачаа, зорчигчийг явуулах өртөөнөөс хүрэх өртөө хүртэл тээвэрлэх технологит үйл ажиллагааг;

4.1.3. “төмөр замын өртөө” гэж галт тэрэг хүлээн авах, явуулах, зөрүүлэх, зорчигчдод үйлчлэх, ачаа, тээш, ачаан тээшийг хүлээн авах, олгох болон сэлгээний ажлыг тасралтгүй. хэвийн гүйцэтгэх зам, төхөөрөмж, байгууламж бүхий төмөр замын дэд бүтцийн хэсгийг;

4.1.4. “хөдөлгөөний нэгдсэн зурмаг” гэж Монгол Улсын төмөр замын нийт дэд бүтцийн хэмжээнд галт тэрэгний хөдөлгөөнийг удирдан, зохицуулах төлөвлөлтийн баримт бичгийг;

4.1.5. “дэд бүтэц дэх хөдөлгөөний зурмаг” гэж дэд бүтцийн хүрээнд галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнийг цагийн сүлжээгээр илэрхийлэх төлөвлөлтийн баримт бичгийг;

4.1.6. “галт тэрэг” гэж тээвэрлэлт гүйцэтгэх, сүүлийн дохио бүхий зүтгүүртэй хөдлөх бүрэлдэхүүнийг;

4.1.7. “ачаа” гэж төмөр замын тээвэрт хүлээн авч, бүртгэн түүний хүргэлт, бүрэн бүтэн, аюулгүй байдлыг төмөр замын байгууллага энэ хуулийн хүрээнд хариуцан тээвэрлэх эдлэхүүн, бүтээгдэхүүн, эд зүйлсийг

4.1.8 “ачаан тээш” гэж ачаа илгээгч тээвэрлэлтийн гэрээний дагуу шуудан, тээшийн вагоноор тээвэрлүүлэх ачааг

4.1.9. “тээш” гэж вагоноор зорчигчтой хамт тээвэрлэх ачааг

4.1.10. “аюултай ачаа” гэж тээвэрлэлт, ачилт, буулгалт, хадгалалтын явцад хүний эрүүл мэнд, мал, амьтанд хор хөнөөл учруулах, хүрээлэн буй орчин, тээврийн хэрэгсэл, техник, тоног төхөөрөмж, барилга байгууламжид эвдрэл, гэмтэл үүсгэх, улмаар тэсэрч, дэлбэрэх, шатах шинж чанартай, үхэл, хордлого, түлэгдэлт, өвчин, ослыг үүсгэж болзошгүй химийн бодис, бүтээгдэхүүн, эд зүйлс түүний хаягдлыг;

4.1.11. “төмөр замын дэд бүтэц” гэж төмөр замын шугамын дээд, доод бүтэц болон гүүр, хоолой, инженерийн байгууламж, өртөө, зөрлөг, салбар зам, галт тэрэгний хөдөлгөөний хэвийн, найдвартай үйл ажиллагааг хангах эрчим хүч, усан хангамж, дохиолол, холбоо, мэдээлэл, сүлжээний барилга байгууламж, техник, технологийн иж бүрдлийг;

4.1.12. “төмөр замын чиг” гэж техник, эдийн засгийн үндэслэлээр тогтоосон чиглэлийн дагуух төмөр замын шугамыг;

4.1.13. “төмөр замын шугам” гэж төмөр замын өртөө хоорондын зам болон өртөөн дэх түүний шууд үргэлжлэлийг;

4.1.14. “төмөр замын чиглэл” гэж төмөр замын эхлэх, дайран өнгөрөх, төгсөх цэгийн шугамыг ерөнхийлөн заасныг.

4.1.15. “төмөр замын цариг” гэж төмөр замын хоёр төмрийн доторх ажлын ирмэг хоорондын зайг;

4.1.16. “нийтийн хэрэглээний зам” гэж галт тэрэг хүлээж авах, явуулах, ялгах болон сэлгээний ажил гүйцэтгэх, зорчигч болон ачаа, ачаан тээш ачих, буулгах, хүлээн авах, олгох, зориулалттай нийтэд үйлчлэх замыг;

4.1.17 “нийтийн бус хэрэглээний зам” гэж эзэмшигчийн өөрийн хэрэгцээг хангах, эсхүл гэрээний үндсэн дээр тодорхой хэрэглэгчид үйлчилгээ үзүүлэх, ачилт, буулгалт хийхэд зориулагдсан замыг;

4.1.18. “нийтийн хэрэглээний талбай” гэж ачаа, ачаан тээшийг ачих, буулгах, ялгах, хадгалах, ашиглахад зориулагдсан техник, тоног төхөөрөмжөөр тоноглогдсон, тусгайлан бэлтгэсэн талбайг;

4.1.19. “нийтийн бус хэрэглээний талбай” гэж эзэмшигчийн өөрийн, эсхүл гэрээний үндсэн дээр тодорхой хэрэглэгчид үйлчилгээ үзүүлэх агуулах, талбайг;

4.1.20. “төмөр замын дэд бүтэц өмчлөгч” гэж төмөр замын дэд бүтцийг захиран зарцуулах эрх бүхий хуулийн этгээдийг;

4.1.21. “төмөр замын дэд бүтэц эзэмшигч” гэж төмөр замын дэд бүтцийг тодорхой хугацаанд гэрээний дагуу эзэмшиж, тусгай зөвшөөрлийн үндсэн дээр ажил, үйлчилгээ эрхлэх эрх бүхий хуулийн этгээдийг;

4.1.22. “төмөр замын дэд бүтэц ашиглагч” гэж төмөр замын дэд бүтцийг ашиглан тээврийн үйл ажиллагаа, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй, хуулийн этгээдийг;

4.1.23. “төмөр замын дэд бүтцийн үйлчилгээ үзүүлэгч” гэж төмөр замын дэд бүтцээр ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийг;

4.1.24 “салбар зам” гэж өртөөний замаас салбарласан, ачаа илгээгч болон хүлээн авагчид үйлчлэх зориулалт бүхий замыг;

4.1.25 “салбар зам эзэмшигч” гэж салбар зам, төхөөрөмж, байгууламжийг тодорхой хугацаанд гэрээний үндсэн дээр өөрийн мэдэлд байлгаж, түүний аюулгүй байдлыг бүрэн хангаж байгаа этгээдийг;

4.1.26 “төмөр замын гарам” гэж нэг түвшинд огтлолцсон авто зам, төмөр замын уулзварыг;

4.1.27 “төмөр замын аюултай бүс” гэж галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөн, ачих, буулгах ажил гүйцэтгэдэг дэвсгэр газрыг;

4.1.28. “төмөр замын аюулгүйн бүс” гэж төмөр зам дээр тохиолдож болох осол, сүйрлээс хуулийн этгээд, иргэнд хохирол учруулахаас урьдчилан сэргийлж, аюулгүй байдлыг хангасан зурвас газрыг;

4.1.29. “төмөр замын тээврийн байгууллага” гэж төмөр замын дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг өмчлөх, эзэмших, ашиглах, үйлдвэрлэх, угсрах, засварлах, техникийн үзлэг хийх тээврийн ажил, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй хуулийн этгээдийг;

4.1.30. “тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч” гэж төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангаж, төмөр замын тээврийн тухай хууль тогтоомж, дүрэм, журамд заасны дагуу тээвэрлэлтийг зохион байгуулах үүрэг бүхий төмөр замын дэд бүтэц эзэмшигч, тээвэрлэгч, хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийн оператор, тээвэр зуучлагч, ачаа тээвэрлүүлэгч, нийтийн болон нийтийн бус хэрэглээний зам, талбай эзэмшигч, иргэн, хуулийн этгээдийг;

4.1.31. “тээвэр зуучлагч” гэж ачаа илгээгч, хүлээн авагч, тээвэрлэгч хоорондын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд үйлчилгээ үзүүлэх эрх бүхий хуулийн этгээдийг;

4.1.32. “хөдлөх бүрэлдэхүүн” гэж тээвэрлэлтэд ашиглаж байгаа зүтгүүр, ачааны болон зорчигчийн вагон, төмөр замаар явдаг тусгай зориулалтын техникийг;

4.1.33. “хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийн оператор” гэж хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийг өмчлөгчөөс хууль, гэрээний дагуу эзэмшүүлэх, ашиглуулах, төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцуулах үйлчилгээ үзүүлэгчийг;

4.1.34. “төмөр замын зураг төсөл” гэж төмөр замын дэд бүтцийг шинээр болон шинэчлэн барьж байгуулах, засварлахад шаардагдах техник, эдийн засгийн үндэслэл, хайгуул, геологийн дүгнэлт, геодезийн хэмжилтийн тайлан, байгаль орчны судалгаа, нарийвчилсан зураг, өртөг зардлын тооцооны нэгдсэн баримт бичгийг;

4.1.35 “төмөр замын зураг төслийн магадлал” гэж төмөр зам, төмөр замын дэд бүтэц, барилга байгууламжийн зураг төслийн хийц, инженерийн шийдэл, тооцоо нь байгаль, цаг уур, газар

орны нөхцөлд зохицож байгаа эсэх, галт тэрэгний хөдөлгөөний удирдлага, зохион байгуулалт, тээврийн болон техникийн аюулгүй байдал нь техникийн зохицуулалт, стандарт, норм, нормативын баримт бичгийн шаардлага хангасан эсэхэд мэргэжлийн дүгнэлт гаргах үйл ажиллагааг;

4.1.36. “овор” гэж галт тэрэгний хөдөлгөөн, хөдөлмөрийн, техникийн аюулгүй байдлыг хангах, ачааг бүрэн бүтэн тээвэрлэх нөхцөлийг бүрдүүлэх, төмөр замын дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн, төмөр замын ойролцоох барилга байгууламж, ачааны байршлын зайн хязгаарыг тогтоосон хэмжээг;

4.1.37 “хатуу тооцоот багаж, хэрэгсэл” гэж хяналт, бүртгэлгүйгээр ашиглахад төмөр замын тээврийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх багаж, хэрэгслийг;

4.1.38. “төмөр замын тээврийн сүйрэл” гэж галт тэрэг өөр галт тэрэг, хөдлөх бүрэлдэхүүн, бусад техник хэрэгсэл, гадны биетэй мөргөлдөх болон хөдлөх бүрэлдэхүүн замаас гарсны улмаас хүний амь нас эрсэдсэн, хөдлөх бүрэлдэхүүн дахин засварлах боломжгүй болсон байгалийн, гэнэтийн давагдашгүй хүчин зүйлийн улмаас төмөр замд их хэмжээний хохирол учирсан тохиолдлыг;

4.1.39. “төмөр замын тээврийн осол” гэж галт тэрэг нь өөр галт тэрэг, бүрэлдэхүүнтэй мөргөлдсөн, замын байгууламж эвдэрсэн, хөдлөх бүрэлдэхүүн замаас гарсаны улмаас их засварт орохоор эвдэрсэн, хүний эрүүл мэнд хохирсон тохиолдлыг;

4.1.40 “аюулгүй байдал алдагдсан” гэж төмөр замын тээврийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлсөн нөхцөл байдлыг;

**ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВЭРЛЭЛТИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧДЫН ТЕХНОЛОГИЙН
НЭГДСЭН ГОРИМ**

| | |
|--|----|
| 1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ | 4 |
| 1.1. Үндсэн зорилго: | 4 |
| 1.2. Технологийн нэгдсэн горимын зорилт: | 4 |
| 1.3. Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч төмөр замын тээврийн байгуулагуудын үүрэг: | 5 |
| 1.4. Технологийн нэгдсэн горимоор зохицуулах үйл ажиллагааны төрөл: | 5 |
| 1.5. Технологийн нэгдсэн горимын хамрах хүрээ: | 5 |
| 2. ТЭЭВЭРЛЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧДЫН ҮҮРЭГ: | 7 |
| 2.1. Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчдын үндсэн үүрэг: | 7 |
| 2.2. Тээвэрлүүлэгч: | 7 |
| 2.3. Нийтийн бус хэрэглээний зам, талбай эзэмшигч: | 7 |
| 2.4. Хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэгийн оператор: | 8 |
| 2.5. Дэд бүтэц эзэмшигч ба тээвэрлэгч: | 8 |
| 2.6. Төмөр замын тээврийн байгууллагын нэгжүүдийн хамтын ажиллагаа: | 9 |
| 3. ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ЗУРМАГ | 11 |
| 3.1. Зурмагт тавигдах шаардлага: | 11 |
| 3.2. Зурмаг зохиох үндсэн өгөгдөл ба үзүүлэлтүүд: | 12 |
| 3.3. Тусгай хуваарийн галт тэрэгний зурмаг зохиох, зөвшилцөх журам | 13 |
| 4. АЧААТАЙ БА ХООСОН ВАГОН УРСГАЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ | 14 |
| 4.1. Вагон урсгалыг зохион байгуулах үндсэн чиглэл: | 14 |
| 4.2. Улс хоорондын харилцаанд вагон урсгалыг зохион байгуулах: | 14 |
| 4.3. Төмөр замын сүлжээнд вагон урсгалыг зохион байгуулах: | 14 |
| 4.4. Галт тэрэг найруулах төлөвлөгөө: | 15 |
| 4.5. Вагон урсгалын замналжуулалт: | 17 |
| 5. АЧАА ТЭЭВЭРЛЭЛТИЙН САРЫН ТӨЛӨВЛӨГӨӨ | 20 |
| 6. АШИГЛАЛТЫН АЖЛЫН ТЕХНИКИЙН НОРМЧЛОЛ | 23 |
| 6.1. Ерөнхий байдал: | 23 |
| 6.2. Техникийн төлөвлөгөө боловсруулах | 25 |
| 6.3. Техникийн төлөвлөгөөний нормыг тооцоолох журам. | 26 |
| 7. ГАЛТ ТЭРЭГНИЙ УДИРДЛАГЫН ТЕХНОЛОГИ | 26 |
| 7.2. Галт тэрэгний ажлыг шуурхай төлөвлөх: | 29 |
| 8. ОРОН НУТГИЙН АЖЛЫГ УДИРДАХ | 31 |
| 8.1. Ерөнхий байдал | 31 |
| 8.2. Орон нутгийн ажлыг төлөвлөх | 33 |
| 8.3. Буулгалтыг төлөвлөх | 34 |
| 8.4. Ачилтын төлөвлөлт | 35 |
| 8.5. Ачаа хүргэх хугацааны биелэлтэд хийх шуурхай удирдлага, хяналт, шинжилгээ | 38 |

| | |
|---|----|
| 9. ТӨМӨР ЗАМЫН ДЭД БҮТЦЭЭР ТЭЭВЭРЛЭЛТИЙГ ХАНГАХ | 39 |
| 9.1. Ерөнхий байдал | 39 |
| 9.2. Дэд бүтцийн урсгал засвар, арчлалтын ажлыг төлөвлөх үеийн нэгжүүдийн хамтын ажиллагаа | 37 |
| 9.3 Дэд бүтцээр үйлчлэх үеийн нэгжүүдийн хамтран ажиллагаа | 41 |
| 9.4 Вагоны техникийн байдалд хяналт тавих асуудлаар хамтран ажиллах | 42 |
| 9.5 Гэмтэлтэй вагонуудыг засварын замд тавих, засварын газартай өртөөдөд шилжүүлэх талаар хамтран ажиллах | 45 |
| 10. ЗҮТГҮҮР, ЗҮТГҮҮРИЙН БРИГАДЫН АЖЛЫГ УДИРДАХ | 45 |
| 10.2 Зүтгүүр, зүтгүүрийн бригадын эргэх мөрийн бүдүүвч, ачааны галт тэрэгний жин, уртын хэмжээг тогтоох | 46 |
| 10.3 Ачааны галт тэргэнд үйлчлэх зүтгүүр ба зүтгүүрийн бригадын нормчлол | 47 |
| 10.4. Зүтгүүр ба зүтгүүрийн бригадын ажлын шуурхай удирдлага | 52 |
| 11. МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ | 61 |
| 12. ТЭЭВЭРЛЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ШИНЖИЛГЭЭ ХИЙХ | 62 |

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Үндсэн зорилго:

Энэхүү горимийн зорилго нь төмөр замын тээврийн тухай хууль, Олон улсын төмөр замын ачааны харилцааны хэлэлцээр, холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчдын төмөр замын тээврээр ачаа тээвэрлэх үйл ажиллагааг технологийн норм, дүрэм журам, стандартад нийцсэн нэгдсэн зохион байгуулалт, удирдлагаар хангах, хоорондын харилцан уялдааг нэгдмэл системтэй болгох, тээвэрлэлтийн үйл ажиллагааны нөөцийг бүх шатанд үр бүтээлтэй ашиглах нөхцөлийг хангаж, Монгол улсын төмөр замын нэгдсэн сүлжээний /Цаашид “Төмөр замын сүлжээ” гэх/ хэмжээнд галт тэрэгний хөдөлгөөнийг хэвийн явуулах нөхцлийг бүрдүүлэхэд оршино.

Технологийн нэгдсэн горим нь тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчдын дараах үндсэн зарчмуудыг тодорхойлно.

- а. Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчдын ачаа тээврийн сарын төлөвлөгөө, техникийн нормыг уялдуулан зохицуулах;
- б. Ачаа илгээгчийг хоосон вагоноор хангах, ачаатай ба хоосон вагон урсгалын төлөвлөлтийг үндэслэн дэд бүтцийг үр бүтээлтэй ашиглах;
- в. Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчдын хооронд гэрээ байгуулах мөн түүнчлэн төмөр замын тээврийн байгууллагуудын хамтын ажиллагааг зохицуулах;
- г. Төмөр замын тээврийн байгууллага болон тэдгээрийн аж ахуйн нэгжүүдийн ажлын технологийн горимыг боловсруулах;
- д. Төмөр замын тээврийн байгууллагуудын хамтын ажиллагааг үнэлэх үзүүлэлтийн (ашиглалтын ба эдийн засгийн) систем боловсруулах;
- е. Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчдын нөөцийг ашигтайгаар удирдах;
- ё. Зах зээлийн эрэлтэд тохируулан төмөр замын салбарын эрх зүйн баримт бичиг, хэм хэмжээний журам, дүрмийг шинэчлэх;

Нэгдсэн технологийн горим нь тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчдын ажлын технологийг үр ашигтай зохион байгуулах үндсэн суурь зарчмыг агуулна.

1.2. Технологийн нэгдсэн горимын зорилт:

- а. Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчдын хамтын ажиллагааны уялдааг технологийн нэгдсэн зарчимд тулгуурлан хангах;
- б. Ачилтын төлөвлөгөөний дагуу илгээгчийг хоосон вагоноор хангах, вагон урсгалын төлөвлөлтийг үндэслэн дэд бүтэц, нийтийн болон нийтийн бус хэрэглээний зам, талбай, хөдлөх бүрэлдэхүүнийг үр бүтээлтэй ашиглах;
- в. Ачаа илгээгч, хүлээн авагч, хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэгийн оператор, нийтийн бус хэрэглээний зам талбай эзэмшигчийн тээвэрлэлтийн төлөвлөгөө, орон нутгийн сэлгээний ажлын нормчлолыг төмөр замын тээврийн байгууллагын ажилтай уялдуулах;
- г. Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчдын (техник, технологи, ажиллах хүчин, тээх нэвтрүүлэх, ачаа тээвэрлэлт, хөдлөх бүрэлдэхүүн гэх мэт) нөөцийг ашигтайгаар удирдах;

1.3. Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч төмөр замын тээврийн байгуулагуудын үүрэг:

“Төмөр замын тээврийн тухай хууль” -ийн 63.1 -д заасны дагуу Төмөр замын тээврийн байгууллага нь өмчийн төрөл, хэлбэрээс үл хамааран хэрэглэгчийн эрх ашигт нийцсэн, чанартай, аюулгүй үйлчилгээг шуурхай үзүүлэх, төмөр замын зурвас газрын дагуух хүрээлэн байгаа орчиныг бохирдлоос хамгаалах үүрэгтэй.

1.4. Технологийн нэгдсэн горимоор зохицуулах үйл ажиллагааны төрөл:

Олон улсын болон орон нутгийн харилцаанд:

- а. Зорчигч болон ачаа тээвэр,
- б. Дэд бүтцийн үйлчилгээ,
- в. Зүтгүүрийн үйлчилгээ,
- г. Хөдлөх бүрэлдэхүүнд техникийн үзлэг, оношлогоо, магадлагаа хийх,
- д. Дэд бүтэц барьж байгуулах,
- е. Монгол улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль, тогтоомж, Монгол улсын нэгдэн орсон Олон улсын гэрээ, конвенц, дээрхтэй нийцүүлэн гаргасан эрх зүйн баримт бичигт тохирсон бусад төрлийн үйлчилгээ үзүүлэх


1.5. Технологийн нэгдсэн горимын хамрах хүрээ – Төмөр замын сүлжээгээр тээвэрлэлтийн үйл ажиллагааг зохион байгуулах, удирдах

Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчид:

- а. Тээвэрлүүлэгч,
- б. Нийтийн бус хэрэглээний зам, талбай эзэмшигч,
- в. Хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэгийн оператор,
- г. Дэд бүтэц эзэмшигч
- д. Дэд бүтэц ашиглагч (цаашид “Тээвэрлэгч” гэх)

Энэхүү горимд хэрэглэгдсэн нэр томъёо, тодорхойлолтыг төмөр замын тээврийн тухай хууль, MNS 6387-1,2,3,4:2013 болон “Төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэм”-д заасан утгаар ойлгож хэрэглэнэ.

ТӨМӨР ЗАМЫН АЧАА ТЭЭВЭРЛЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ДАРААЛЛАЛ



Зураг 1. Нэгдсэн технологийн горимын бүтэц, хоорондын холбоо

Тайлбар:

- Ачаатай вагон урсгал
- Хоосон вагон урсгал
- Галт тэрэг, вагон урсгал
- Мэдээллийн урсгал

ХОЁР. ТЭЭВЭРЛЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧДЫН ҮҮРЭГ:

2.1. Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчдын үндсэн үүрэг.

- а. Тээвэрлэхээр төлөвлөж байгаа ачаа, вагоны тээвэрлэлтийн нөхцөл, үзүүлэлтийг:
 - нийтийн бус хэрэглээний зам, талбайгаас ачих бол тээвэрлэгч болон зам талбай, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигчтэй,
 - нийтийн хэрэглээний замаас ачаа ачих бол тээвэрлэгчтэй тохиролцох;
- б. Ачаа тээвэрлэлтийн захиалгыг дэд бүтэц эзэмшигч, хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийн оператортой зөвшилцөх;
- в. Дэд бүтэц эзэмшигч болон тээвэрлэгчтэй тохиролцсон захиалгын үзүүлэлтэнд заагдсан ачааг бэлтгэх;
- г. Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч нь аль болох нэг төрлийн вагонд ачилт буулгалтын хоёрлосон ажиллагаа гүйцэтгэх;
- д. Бөөнөөр ачих ачааг замналаар тээвэрлэх;
- е. Гэрээний үндсэн дээр галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмагт тусгай хуваарийн галт тэрэг явуулахаар тусгах захиалгыг Галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн удирдлага, зохицуулалтын асуудал хариуцсан байгууллага /цаашид “Хөдөлгөөний нэгдсэн удирдлага, зохицуулалт хариуцсан байгууллага” гэх/ -д өгөх;

2.2. Тээвэрлүүлэгч

2.2.1. Ачаа илгээгч

- а. техникийн нөхцлийн дагуу хөдлөх бүрэлдэхүүний талбай, даацыг хэтрүүлэлгүйгээр эзлэхүүнийг дээд зэргээр ашиглах;
- б. ачилтын ажил гүйцэтгэх тогтоосон хугацааг баримтлах;
- в. төлбөр тооцоог заасан хугацаанд нь буюу галт тэрэг, вагон аялалд гарахаас өмнө хийх;
- г. хөдөлгөөний болон техникийн аюулгүй байдлыг хангах;
- д. хөдлөх бүрэлдэхүүний бүрэн бүтэн байдлыг хангах;
- е. оворын шаардлагыг хангах;
- ё. ачилт, буулгалтын ажиллагаанд техник, технологи, инновацийг ашиглах.

2.2.2. Ачаа хүлээн авагч

- а. ачаатай ба хоосон вагонд хийгдэх технологи ажиллагаа ба ачилт, буулгалтын ажил гүйцэтгэх тогтоосон хугацааг баримтлах;
- б. хөдлөх бүрэлдэхүүний болон хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахаар буулгасан эсвэл ачихаар бэлтгэсэн ачааны оворын шаардлагыг хангах;

2.3. Нийтийн бус хэрэглээний зам, талбай эзэмшигч

- а. Үйлдвэрийн өртөөнд нийлсэн технологийн замуудад ачааны ажиллагаанд вагон тавих, татах, сэлгээний ажил гүйцэтгэх;
- б. Ачаа илгээгчтэй хамтран илгээгчийн болон илгээгчийн шатласан замнал зохион байгуулах;
 - в. Хөдөлгөөний нэгдсэн зурмагт тусгагдсан галт тэргийг хугацаанд нь найруулж явуулахад бэлэн болгох;
 - г. Явуулах болон өртөөнөөс ирсэн бүрэлдэхүүнд техник, коммерийн үзлэг, засвар хийх;

2.4. Хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэгийн оператор

а. Тээвэрлэх ачааны захиалгын дагуу эсвэл тээвэрлэлт зохион байгуулах урт хугацааны гэрээний дагуу вагоны нөхцлийг ачаа илгээгчтэй зөвшилцөх;

б. Ачаа илгээгчтэй урьдчилан зөвшилцсөн тээвэрлэлтийн захиалгын дагуу хоосон вагон нийлүүлэх;

в. Ачаа илгээгчийн захиалгаар хоосон вагоныг хүргэх өртөөг тодорхойлох;

г. Төлөвлөж байгаа сард тээвэрлэх ачааны хэмжээгээр вагон урсгалыг төлөвлөх;

д. Хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийг гэрээний үндсэн дээр тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчдод ашиглуулах,

е. Тээвэрлэлтийн гэрээтэй холбоогүй хоосон вагоныг, хаана ямар хугацаагаар зогсоох боломж, нөхцлийг дэд бүтэц эзэмшигчтэй тохирох;

2.5. Дэд бүтэц эзэмшигч ба тээвэрлэгч

а. Дэд бүтэц эзэмшигч нь галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмаг, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч төмөр замын тээврийн байгууллагуудын технологийн нэгдсэн горимд нийцүүлэн галт тэрэгний хөдөлгөөнийг зохион байгуулах;

б. Дэд бүтэц эзэмшигч нь тээвэрлэгч болон бусад дэд бүтэц эзэмшигч нартай зөвшилцөн “Төмөр замын дэд бүтэц ашиглуулах журам”-д заасны дагуу хамтын ажиллагааны гэрээ байгуулан тээвэрлэлтийг тасралтгүй явуулах нөхцөлийг бүрдүүлэх.

в. Гэрээг төмөр замын тээврийн тухай хуулийн 11.2.5-д заасны дагуу Хөдөлгөөний нэгдсэн удирдлага, зохицуулалт хариуцсан байгууллагад бүртгүүнэ.

г. Дэд бүтэц эзэмшигч нь өмчийн төрөл, хэлбэр харгалзахгүйгээр төмөр замын тээвэрлэлтийн бүх төрлийн үйл ажиллагааг “Төмөр замын дэд бүтэц ашиглуулах журам” -д заасны дагуу зурмагийн нэгдмэл зохицуулалттай, үйлчилгээний хүртээмж, чанар, аюулгүй байдлыг хангаж, тасралтгүй явуулна.

д. Дэд бүтэц эзэмшигч нь зам талбай эзэмшигч, ачаа илгээгч нартай байгуулсан гэрээний үндсэн дээр нийтийн болон нийтийн бус хэрэглээний зам талбайд вагон тавьж өгөх, татаж авах ажлыг өөрийн эзэмшлийн сэлгээний илчит тэргээр гүйцэтгэх үүрэгтэй.

е. Хоногийн дундаж ачаа эргэлт нь 100 хүртэлх вагон бол түүнтэй байгуулсан “вагоны тавилт, таталтын гэрээ”-ний дагуу.

ё. Хоногийн дундаж ачаа эргэлт нь 100 ба түүнээс дээш вагон бол түүнтэй хамтран боловсруулсан технологийн нэгдсэн горимийн дагуу ажиллана.

2.5.1. Төмөр замын тээврийн байгууллагын ачаа тээврийн нэгж

а. Ачаа илгээгчээс тээвэрлэх ачааны захиалгыг авах;

б. Сарын ачаа тээвэрлэлтийг хангахад шаардагдах хоосон вагоны талаар хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийн оператортой зөвшилцөх;

в. Хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэгийн оператортой хоосон вагоноор хангах гэрээ байгуулах;

г. Ачаа тээвэрлэлтийн болон хоосон вагон хангалтын хоногийн төлөвлөгөөг дэд бүтцийн болон ачаа илгээгч, ачаа хүлээн авагчийн техник технологийн боломжид тулгуурлан зөвшилцөж төлөвлөх;

д. Тээвэрлэлтэд оролцогчидтой гэрээ байгуулах;

е. Ачаа илгээгчтэй ачаа тээвэрлэлтийн ажлыг зохион байгуулах;

ё. Ачаа илгээгч ба хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэгийн оператортой илгээгчийн замнал ба тусгай хөдлөх бүрэлдэхүүнээр, тусгай хувиараар тээвэрлэх ачааны нөхцлийг зөвшилцөх.

ж. Тээврийн иж бүрэн үйлчилгээ үзүүлэх;

2.5.2. Төмөр замын тээврийн байгууллагын тээвэр зохион байгуулалтын нэгж

а. Ашиглалтын ажлын техникийн үзүүлэлт, галт тэрэг найруулах төлөвлөгөө, галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмагтай уялдуулан дэд бүтцийн боломжийг тооцон вагон урсгалыг зохион байгуулах төлөвлөгөө ба галт тэрэгний аялах чиглэлийг тодорхойлох;

б. Галт тэрэгний хөдөлгөөний болон сэлгээний ажлыг диспетчерийн төвлөрсөн удирдлагаар хангах;

в. Орон нутгийн болон сэлгээний ажлыг оролцуулан галт тэрэг, вагон урсгалыг төлөвлөх, удирдах, зохион байгуулах;

г. Тээвэрлэлтийг зохион байгуулах арга зүй болон үйл ажиллагааны баримт бичгийг боловсруулах

д. Дэд бүтцийн тээх, нэвтрүүлэх, боловсруулах чадварыг тодорхойлох

е. Өртөөдөд ачааны вагонд комерийн үзлэг хийх;

ё. Вагоныг пүүлэх.

2.5.3. Төмөр замын тээврийн байгууллагын зүтгүүрийн аж ахуйн нэгж

а. Зүтгүүрийг ашиглалтын стандарт, технологээр хангах

б. Ачаа тээвэрлэлтийн төлөвлөгөөг биелүүлэхэд шаардлагатай хүчин чадал бүхий ачааны, сэлгээний болон аж ахуйн зүтгүүрээр тээвэрлэгчийг хангах;

в. Тээвэрлэгчийг ачааны, сэлгээний болон дэд бүтцийн аж ахуйн ажлыг гүйцэтгэх зүтгүүрийн бригадаар хангах;

г. Ашиглалтын явцад засвар хоорондын гүйлтийг баримтлан техникийн гэмтэлгүй, холбооны болон хөдөлгөөний аюулгүй байдлын хэрэгслээр тоноглогдсон зүтгүүрээр хангах ажлыг зохион байгуулах;

д. Зүтгүүрийн техникийн байдалд хийх оношлогоо, шинжилгээ хяналтыг төлөвлөгөөтэйгээр тогтмол хийж зүтгүүрт гарах гэмтлийг урьдчилан илрүүлэх ажлыг зохион байгуулах .

2.5.4. Төмөр замын тээврийн байгууллагын тооцоолон бодох нэгж

а. Тээвэрлэлтийн үйл ажилгааг удирдах, зохион байгуулах ажилагаанд оролцогч бүх шатны байгуулагуудыг мэдээллээр хангах;

б. Тээвэрлэлтийн үйл ажилагааг зохион байгуулахад шаардлагатай мэдээллийг төмөр замын тээврийн байгуулагуудын болон ачаа илгээгч, хүлээн авагч, хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийн оператор хооронд солилцох боломжийг бүрдүүлэх;

в. Хөдлөх бүрэлдэхүүний ашиглалтын тоон болон чанарын үзүүлэлтийн биелэлтийн шуурхай статистик тайлангаар хэрэглэгчийг хангах;

г. Хөдлөх бүрэлдэхүүний ашиглалтын үзүүлэлтийг тооцоолон бодоход шаардлагатай техник хэрэгслэл, технологээр хангах.

2.6. Төмөр замын тээврийн байгууллагын нэгжүүдийн хамтын ажиллагаа

2.6.1. Тээвэр зохион байгуулалтын болон зүтгүүрийн аж ахуйн нэгжүүдийн хамтын ажиллагаа

Тээвэр зохион байгуулалтын болон зүтгүүрийн аж ахуйн нэгж, тэдгээрийн шугам замын аж ахуйн нэгжүүдийн хамтын ажиллагааны үүрэг бол тээвэрлэлтийн жилийн төлөвлөгөө ба галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмагын биелэлтийг хангах явдал юм.

Хамтын ажиллагааны үндсэн зарчим:

а. Тээвэрлэлтийн төлөвлөгөөг биелүүлэхэд шаардагдах зүтгүүр болон зүтгүүрийн бригадыг төлөвлөх, ашиглах;

- б. Зүтгүүр ба зүтгүүрийн бригадын хоногийн ажлын төлөвлөгөөнд тохируулга хийх;
- в. Төлөвлөсөн тээвэрлэлтийн ажлын хэмжээ өөрчлөгдсөн ба шуурхай байдлаар зүтгүүр, зүтгүүрийн бригадыг хуваарилах ажлыг зөвшилцөх;
- г. Тогтоосон төсвийн хүрээнд зүтгүүр ашиглахыг зөвшилцөх;
- д. Хоногийн ажлын төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавих
- е. Зүтгүүрийн бригадын ажил амралтын тогтоосон хугацааг баримтлах

2.6.2. Дэд бүтэц эзэмшигч болон тээвэр зохион байгуулалтын нэгжийн хамтын ажиллагаа

Дэд бүтэц эзэмшигч болон тээвэр зохион байгуулалтын нэгж, тэдгээрийн шугам замын аж ахуйн нэгжүүдийн хамтын ажиллагааны үндэс бол жилийн тээвэрлэлтийн төлөвлөгөөг биелүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэх, арчлах ажил болно.

Хамтын ажиллагааны үндсэн зарчим:

- а. Хөдөлгөөний нэгдсэн зурмагт тусгагдсан тогтоосон жин, хурдтай галт тэргийг өнгөрүүлэх нөхцөлийг хангах;
- б. Дэд бүтцийг хөгжүүлэх, шинэчлэх, өөрчлөх, жилийн ба хэтийн төлөвлөгөөг боловсруулах явцад хамтран ажиллах;
- в. Дэд бүтцийн обектуудын их засвар, урсгал засварын төлөвлөгөөний дагуу галт тэрэгний ээлжийн болон хоногийн ажлын төлөвлөгөөт зурмагт “Цонх” гарган хамтран ажиллах;
- г. Өртөөдийн өвөлжилтийн бэлтгэл ажил, цастай тэмцэх төлөвлөгөө боловсруулахад хамтран ажиллах;
- д. Дэд бүтцийн засвар, үйлчилгээний ажлыг хамтран төлөвлөх
- е. Ачааны галт тэрэг найруулах төлөвлөгөө, зүтгүүр үйлчлэх мөрийн өөрчлөлтөөс хамааруулан ачааны галт тэргийг аюулгүй өнгөрүүлэх уртасгасан хэсгийг хамтран төлөвлөх;
- ё. Өртөөний ажлын мөрдөгдөж байгаа технологийн горимоор тогтоосон хэмжээнд тохируулан ялгалтын, хэсгийн, ачааны өртөөдөд галт тэргэнд техникийн үйлчилгээ хийх ажилчдын орон тоог галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмагийг үндэслэн төлөвлөх;
- ж. Төлөвлөгөөт ба төлөвлөгөөт бус засвар хийх шаардлагатай гэмтэлтэй вагонуудыг хувиарлах ажлыг зохион байгуулахад хамтран ажиллах;
- з. Дэд бүтцийн төхөөрөмжийн хэвийн ажиллагаа алдагдахад түүний гэмтлийг тодорхойлох, засахад хамтран ажиллах;
- и. Өртөөний нийтийн хэрэглээний замд гэмтэлтэй вагон зогсоох хугацааг баримтлах.

2.6.3. Дэд бүтэц эзэмшигч болон хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэгийн операторын хамтын ажиллагаа

Хамтын ажиллагааны үндсэн зорилт нь дэд бүтэц эзэмшигч болон хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэгийн оператор нь ачаа тээвэрлэлтийн тасралтгүй үйл ажиллагааг хангах зорилгоор гэрээний үндсэн дээр ачааны вагоныг худалдах, түрээслэх болон харилцан дэмжлэг үзүүлэхэд оршино.

Дэд бүтэц эзэмшигч нь дараах ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

- а. Тээвэрлэлтийн гэрээтэй холбоотой хөдлөх бүрэлдэхүүн мөн түүнчлэн өөрийн замд хамааралгүй ажлын бус паркийн болон салгалттай засвар хийх вагоныг зогсооход зориулагдсан нийтийн хэрэглээний замаар үйлчлэх;
- б. Нийтийн хэрэглээний замд вагон тавих, татах, сэлгээний ажил хийх боломжийг хангах;
- в. Шаардлагатай тохиолдолд ачааны вагонд засвар хийх;
- г. Урсгал засварын замд болон тусгай зориулалтын засварын газарт вагоныг ачилтанд бэлтгэх;

д. Нийтийн бус хэрэглээний замд гэмтсэн вагонд салгалттай засвар хийх;
е. Төлөвлөгөөт засварын хугацаа дууссан вагоныг ажлын бус паркад шилжүүлэх;
ё. Гэрээнд заагдсан вагоныг ачаа тээвэрлэлтэд ашиглах;
ж. Хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийн оператор нь сард тээвэрлэх ачааны хэмжээ ба замналаар тээвэрлэхэд шаардагдах хоосон вагоны тооцоог гаргаж дэд бүтэц эзэмшигчийн тээвэр зохион байгуулалтын нэгжид өгнө. Тээвэр зохион байгуулалтын нэгж нь ачааны галт тэрэг найруулах төлөвлөгөөнд зохих өөрчлөлт оруулж дэд бүтцийн хэмжээнд ачилтанд шаардлагатай хоосон вагоны хэрэгцээг өртөөдөөр тодорхойлно.

2.6.4. Төмөр замын тээврийн байгууллагууд өөрийн өртөөдөд нийлэх нийтийн бус хэрэглээний зам, талбай эзэмшигчидтэй хамтран ажиллах

Төмөр замын тээврийн байгууллага болон нийтийн бус хэрэглээний зам, талбай эзэмшигч нарын хооронд вагон, хөдлөх бүрэлдэхүүн дамжуулах, солилцох ажиллагааг нийлэх өртөөтэй байгуулсан салбар зам ашиглах, вагон тавих, татах гэрээ болон технологийн нэгдсэн горимоор тогтоосон хэм хэмжээний дагуу гүйцэтгэнэ.

Нийтийн бус хэрэглээний зам, нийлэх өртөө хоорондын ажлыг жигд хэвийн явуулах нөхцөлийг хангахын тулд:

а. Нийлэх өртөө ба нийтийн бус хэрэглээний замд вагон, бүрэлдэхүүнд хийгдэх технологит ажиллагааны үргэлжлэх хугацааг галт тэрэгний зурмагтай уялдуулах;

б. Нийлэх өртөө ба нийтийн бус хэрэглээний замд вагон, бүрэлдэхүүнд хийгдэх технологит ажиллагааг зэрэгцүүлж, тасралтгүй гүйцэтгэх;

в. Нийтийн бус хэрэглээний зам, нийлэх өртөөний техник хангамж, замын хөгжлийг үр бүтээлтэй ашиглахын тулд бүрэлдэхүүн, вагонд хийх техник, коммерийн үзлэгийг галт тэрэгний болон ялгалтын ажлын хооронд ашигтайгаар хувиарлах;

г. Нийлэх өртөө, нийтийн бус хэрэглээний замын ажлын шуурхай төлөвлөлтийг зохицуулах;

д. Нийтийн бус хэрэглээний замд байгаа вагоныг ачилт, буулгалтын фронтод тавих, ачсан, буулгасан вагоны тухай болон түүнчлэн ачааг тээвэрлэлтэнд бэлэн болгосон тухай харилцан мэдээлэл солилцох;

е. Тээвэрлэлтийн техникийн болон коммерийн ажлыг төлөвлөх, тооцох, бичиг баримт бүрдүүлэх;

ё. Үйлдвэрлэлийн сул зогсолт гаргахгүйгээр ачилтын вагоноор хангах;

ж. Нийтийн бус хэрэглээний замд найруулж, явуулахад бэлэн болгосон бүрэлдэхүүнийг хугацаанд нь татаж авах.

ГУРАВ. ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ЗУРМАГ

3.1. Зурмагт тавигдах шаардлага

3.1.1. Галт тэрэгний хөдөлгөөний зурмаг нь төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчид, дэд бүтэц эзэмшигчдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үндсэн баримт бичиг болно.

3.1.2. Галт тэрэгний хөдөлгөөний зурмаг нь “Төмөр замын техник ашиглалтын дүрэм”-д заасны дагуу дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

а. Зорчигч, ачаа, ачаан тээш тээвэрлэлтийн хэрэгцээг хангах;

б. Галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдал болон ажиллагааг хангах;

в. Өртөөний боловсруулах болон хэсгийн тээх, нэвтрүүлэх чадварыг үр дүнтэй ашиглах;

- е. Хөдлөх бүрэлдэхүүн болон ачих буулгах техник хэрэгслэлийг үр бүтээлтэй ашиглах;
- д. Зүтгүүрийн бригадын тасралтгүй ажиллах, амрах цагийг нарийн мөрдөх;
- е. Зам, сум, хиймэл төхөөрөмж, дохиолол төвлөрүүлэлт хориглол, холбооны болон цахилгаан эрчим хүчний байгууламжинд засвар үйлчилгээ хийх боломжийг олгох;
- ё. Нийтийн болон нийтийн бус хэрэглээний замын тээвэрлэлтийн ажлыг уялдуулах;

3.1.3. Галт тэрэгний хөдөлгөөний зурмагийг зорчигчийн галт тэрэгний зурмаг, галт тэрэг найруулах төлөвлөгөөний хамт жил бүр зохион Төмөр замын тээврийн байгууллагууд нэгэн зэрэг мөрдөнө. Галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмагийг Монгол Улсын хүчин төгөлдөр хэрэгжиж буй хууль, Төрийн захиргааны төв байгууллагаас баталсан галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмаг зохицуулалтын дүрэм болон бусад холбогдох дүрэм, журмын дагуу боловсруулна.

3.1.4. Галт тэрэгний хөдөлгөөний зурмаг зохиохдоо зорчигчдын болон ачаа илгээгч бусад үйлчлүүлэгчдийн сонирхлыг татсан ачааны болон зорчигчийн өндөр хурдны, тусгай хуваарийн, төлбөрт галт тэрэг зурмагт байршуулах боломжийг тусгасан байвал зохино.

3.1.5. Галт тэрэгний хөдөлгөөний зурмаг зохиохын өмнө баримт бичиг бүрдүүлэх явцад тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчдын хамтын ажиллагааны гэрээг үндэслэн “Төмөр замын техник ашиглалтын дүрэм”-д зааснаар галт тэрэгний дарааллыг тогтоосон байна.

3.1.6. Галт тэрэгний хөдөлгөөний зурмагийн үндэс нь өртөөний хоногийн ажлын төлөвлөгөө зурмаг, өртөөдөөр дамжин өнгөрөх болон орон нутгийн ачаатай, хоосон вагон урсгалыг өнгөрүүлэх үйл ажиллагааны технологи болно.

3.1.7. Галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмаг нь дараах үйл ажиллагааны үндэс болно.

- а. Төмөр замын тээврийн байгууллагуудын болон тэдгээрийн аж ахуйн нэгжүүдийн ашиглалтын ажлын техникийн нормчлол;
- б. Зурмагийг биелүүлэхэд шаардагдах хүний нөөц, санхүү, материал болон түлш, эрчим хүч;
- в. Ачаа ба зорчигч тээвэрлэлтэнд дэд бүтцийн үзүүлсэн үйлчилгээ, техник, технологийн боломжид үнэлэлт өгөх;
- г. Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчдын хамтын ажиллагаанд үнэлэлт өгөх;

3.2. Зурмаг зохиох үндсэн өгөгдөл ба үзүүлэлтүүд

3.2.1. Үндсэн өгөгдөл:

- а. Галт тэрэгний хоорондын замуудаар явах цэвэр хугацаа;
- б. Хүч авалт, удаашралтанд зарцуулах хугацааны норм;
- в. Завсрын өртөөдөд техник, коммерийн үйлчилгээ хийхээр зогсоох хугацааны норм;
- г. Зүтгүүрт техникийн үйлчилгээ хийхээр эргэлтийн ба үндсэн депод зогсоох хугацааны норм;
- д. Галт тэрэг хүлээн авах, явуулах, зөрүүлэх, өнгөрүүлэх үеийн галт тэрэг хоорондын хамгийн бага интервал (өртөөний интервал) болон багц галт тэрэг хоорондын интервал.

3.2.2. Галт тэрэгний хөдөлгөөний зурмагын үндсэн үзүүлэлт:

А. Тоон үзүүлэлт

- а. Ачилт, буулгалтын хэмжээ;
- б. Ачааны болон зорчигчийн галт тэрэгний тоо, хэмжээ;

- в. Ачааны галт тэрэгний гүйлт (галт тэрэг/км, галт тэрэг/цаг);
- з. Зүтгүүрийн гүйлт (зүтгүүр/км, зүтгүүр/цаг);
- д. Галт тэрэгний ажил (цэвэр.тн/км, бохир.тн/км);
- е. Уулзварын өртөөдөөр солилцох галт тэрэг, вагоны тоо.

Б. Чанарын үзүүлэлт

- а. Техникийн, хэсгийн болон замналын хурд;
- б. Хурдны коэффициент;
- в. Зүтгүүрийн хоногийн дундаж гүйлт;
- з. Галт тэрэгний цэвэр, бохир жин;
- д. Ялгалтын, хэсгийн өртөөдөд ачааны галт тэрэгний (дамжин өнгөрөх) дундаж зогсолт;
- е. Эргэлтийн өртөөнд зүтгүүрийн зогсох дундаж хугацаа;
- ё. Зүтгүүрийн ашиглалт болон эргэлтийн хугацаа.

3.3. Тусгай хуваарийн галт тэрэгний зурмаг зохиох, зөвшилцөх журам

3.3.1. Тусгай хуваарийн галт тэрэг томилуулах сонирхолтой ачаа илгээгч хувь хүн, хуулийн этгээд хүсэлтээ Хөдөлгөөний нэгдсэн удирдлага, зохицуулалт хариуцсан байгууллагад ирүүлнэ.

3.3.2. Хөдөлгөөний нэгдсэн удирдлага, зохицуулалт хариуцсан байгууллага нь хүсэлтийг бүртгэн авч, төмөр замын тээврийн байгууллагатай хэлэлцэж шийдвэрлэнэ.

3.3.3. Хөдөлгөөний нэгдсэн удирдлага, зохицуулалт хариуцсан байгууллага нь төмөр замын тээврийн байгууллагатай хүсэлтийг хэлэлцэн, дүнг дараах байдлаар гаргана.

а. Зөвшөөрсөн эсвэл хэсэгчлэн татгалзсан (хүсэлтийг бүхэлд нь эсвэл зарим хэсгийг өөрчилсөн нөхцөлд тусгай хуваарийн галт тэргийг томилж болох тухай) шийдвэрийг хүсэлт гаргагчид мэдээлнэ.

б. Хүсэлтийг бүрэн зөвшөөрсөн тохиолдолд тусгай хуваарийн галт тэргийг тогтоосон журмаар аялуулах хуваарь боловсруулах гэрээ байгуулах тухай шийдвэрийг хүсэлт гаргагчид хүргүүлнэ.

в. Төмөр замын тээврийн байгууллага нь өөрсдийн тээврийн төлөвлөгөөнд тохирсон галт тэрэгний хөдөлгөөний хэмжээг тодорхойлон дэд бүтэц дэх хөдөлгөөний зурмагийн төслийг зохиож Хөдөлгөөний нэгдсэн удирдлага, зохицуулалт хариуцсан байгууллагад ирүүлнэ.

з. Хөдөлгөөний нэгдсэн удирдлага, зохицуулалт хариуцсан байгууллага нь төмөр замын тээврийн байгууллагаас хүсэлт гаргагчийн саналыг тусган ирүүлсэн зурмагийн төслийг үндэслэн Монгол Улсын эрх ашигт нийцүүлж, зах зээлийн өрсөлдөөнийг хязгаарлахгүй, аливаа этгээдэд давуу эрх олгохгүй байх зарчмыг баримтлан галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмагийг зохиож батлана.

3.3.4. Нэгдсэн зурмаг нь дараах шаардлагыг хангасан байна.

а. Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээр, өрсөлдөөний тухай болон төмөр замын тээврийн тухай Монгол улсын хууль, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчдын технологийн нэгдсэн горим, дэд бүтэц эзэмшигч, тээвэрлэгчийн хооронд байгуулсан тээврийн гэрээнд нийцсэн байх;

б. Дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг үр бүтээмжтэй ашиглах;

в. Төмөр замын тээврийг бусад төрлийн тээврийн болон хил гаалийн үйл ажиллагаатай уялдуулах;

з. Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчдын санал хүсэлтийг судлан, харгалзан үзэх;

д. Галт тэрэгний хөдөлгөөний зурмаг болон галт тэрэг найруулах төлөвлөгөөг шинээр боловсруулан мөрдөхийн өмнө өртөөдийн ажлын технологийн горимд зохих өөрчлөлт, нэмэлтийг оруулах.

ДӨРӨВ. АЧААТАЙ БА ХООСОН ВАГОН УРСГАЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ

4.1. Вагон урсгалыг зохион байгуулах үндсэн чиглэл:

- а. Төмөр замын тээврийг шинэчлэх нөхцөлд түүнийг тогтвортой хөгжүүлэх;
- б. Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч нартай хамтран ажиллах, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах;
- в. Ачаа тээвэрлэлтийн төлөвлөгөө, гэрээний үүргийг биелүүлэх;
- г. Ачаатай ба хоосон вагон урсгалтай холбоотой үргүй зардлыг багасгах;
- д. Өртөөдөд ачааны болон техникийн ажиллагаанд зогсох, мөн түүнчлэн тэдгээрийг боловсруулах ажиллагаанд зарцуулах хугацааг багасгах;
- е. Ачааг хүлээн авагчид, хоосон вагоныг ачаа илгээгчид хугацаанд нь хүргэх;
- ё. Галт тэрэгний болон сэлгээний зүтгүүрийн ашиглалтыг сайжруулах;
- ж. Овор хэтэрсэн болон аюултай ачаа тээвэрлэх үеийн аюулгүй байдлыг хангах;
- з. Вагон урсгалыг галт тэрэг болгон зохион байгуулах ажлыг техникийн (ялгалтын ба хэсгийн) ачааны өртөөдөд гүйцэтгэх;

4.2. Улс хоорондын харилцаанд вагон урсгалыг зохион байгуулах

Улс хоорондын харилцаанд вагон урсгалыг зохион байгуулах систем нь жил бүрийн хилийн хэлэлцээрээр дамжин өнгөрөх өртөө тус бүрээр хэлэлцэн тохиролцож баталсан галт тэрэгний тоо (үүнээс хатуу зурмагийн галт тэрэг), ачааны галт тэрэгний жин, томъёолсон урт, чингэлэгийн галт тэрэг, илгээгчийн замналын тодорхой чиглэл болно.

Төмөр замын тээврийн тээвэрлэлтийн үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтын мэдээллийн системд төмөр замын хамтын нөхөрлөлийн гишүүн улс орнуудын төмөр замын тээврийн байгууллагын сүлжээний өртөө, ачаа илгээгч, ачаа хүлээн авагч, ачааны нэр, хөдлөх бүрэлдэхүүний талаарх өгөгдлийг коджуулсан болно.

Хамтын нөхөрлөлийн гишүүн улс хоорондын вагон ба чингэлэг урсгалыг зохион байгуулах үйл ажиллагааны мэдээлэл, технологийн чанарыг хангах, вагон урсгалын системийг хялбаршуулахын тулд төмөр замын тээврийн байгууллагуудын цахим системд вагон ба чингэлэгээр олон улсын суудлын болон ачааны галт тэрэг найруулах төлөвлөгөөний өгөгдлийн бааз байгуулна.

4.3. Төмөр замын сүлжээнд вагон урсгалыг зохион байгуулах

Улсын хэмжээнд вагон урсгалыг зохион байгуулах системд дараах ажлууд хамаарна.

- а. Галт тэрэг найруулах төлөвлөгөөг боловсруулан хэлэлцэж, зөвшилцөн батлах, түүнд өөрчлөлт оруулах;
- б. Галт тэрэг найруулах төлөвлөгөөний өгөгдлийн баазыг бүрдүүлж ашиглах;
- в. Дэд бүтэц эзэмшигчийн эсвэл хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэгийн операторын вагоноор ачилтын цэгээс илгээгчийн замнал зохион байгуулах;
- г. Дэд бүтэц эзэмшигчийн болон хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэгийн операторын вагоноор галт тэрэг зохион байгуулах;
- д. Вагон урсгалын аялах чиглэл ба галт тэрэг найруулах төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах;

е. Ачааны галт тэрэгний бүрэлдэхүүнд бусад дэд бүтэц эзэмшигч ба хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэгийн операторын вагоныг холбох журам;

ё. Өртөөний замаас ачаа илгээгч ба хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэгийн операторын вагоноор замналын галт тэрэг найруулах боломжийг тодорхойлох;

ж. Орон нутгийн ачаатай болон хоосон вагонтай галт тэрэгний хөдөлгөөнийг зохион байгуулах;

з. Өртөөний замд хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэгийн операторын болон бусад дэд бүтэц эзэмшигчийн тээвэрлэлтэд шаардлагагүй хоосон вагоныг түр хугацаагаар зогсоох, зогсоох өртөөнд хүргэх, татаж авах;

и. Төмөр замын тээврийн байгууллага нь тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчидтой байгуулсан гэрээний дагуу техникийн өртөөдөөс тэдгээрийн ачаатай болон хоосон вагоноор галт тэрэг найруулах;

й. Тээвэрлэлтийн тусгай нөхцөл шаардагдах, тухайлбал аюултай, овор хэтэрсэн ачаатай вагоноор замналын галт тэрэг найруулах, өнгөрүүлэх;

к. Осол сүйрэл, цаг агаарын аюултай үзэгдэл зэрэг онцгой нөхцөлд вагон урсгалыг зохион байгуулах;

л. Чингэлэгийн ба тогтмол дулаант вагоноор ачаа тээвэрлэх.

4.4. Галт тэрэг найруулах төлөвлөгөө

Хэсгийн (техникийн) өртөөд хоорондын вагон урсгалд хийгдэх ажиллагааны тоо, зогсох болон ялгалтын, сэлгээний ажилд зарцуулах хугацаа хамгийн бага байхаар ажлыг үр ашигтайгаар хуваарилахыг вагон урсгалыг зохион байгуулах систем гэнэ.

4.4.1. Галт тэрэг найруулах төлөвлөгөө дараах нөхцлийг хангасан байна.

а. Вагон урсгалыг эдийн засгийн шалгуур үзүүлэлт, логистик зарчимд үндэслэн ялгалтын ажлыг өртөөд хооронд ашигтайгаар хуваарилах, вагоны зогсолтыг хамгийн бага байлгах, аялалын явцад вагонд хийх ажиллагааг цөөн байхаар замналыг тодорхойлох;

б. Илгээгчийн болон техникийн замналын бүрэн бүтэн байдлыг түүний аялах чиглэлийн дагуу хангах;

в. Ялгалтын өртөөдийн техник хангамж, ашиглалтын онцлогт тохируулан вагон урсгалыг боловсруулах ажиллагааг төвлөрүүлэх;

г. Өртөөдийн замын хөгжил, ялгах хэрэгслэл, сэлгээний зүтгүүрийг үр бүтээлтэй ашиглах;

д. Галт тэрэгний зүтгүүрийн бүтээмж, зүтгүүрийн бригадын ажлын дэглэм мөн түүнчлэн зүтгүүрийн мөрийн турш салгалтгүй аялах галт тэрэгний тоог нэмэгдүүлэх;

е. Галт тэрэг найруулах төлөвлөгөөг хөдөлгөөний зурмаг, уулзварын болон нийлэх өртөөний ажилтай харилцан уялдуулсны үндсэн дээр ашиглалтын ажлыг хэвийн явуулах;

ё. Томоохон ачаа илгээгчийн вагон урсгалд ажиллагаа хийх, хэсгээр өнгөрүүлэх нөхцлийг тогтвортой байлгах;

ж. Ачаа урсгалыг удирдах, тээврийн үйлчилгээнд тавигдах шаардлагыг орчин үеийн түвшинд хүргэх;

з. Вагон урсгалыг галт тэрэг урсгал болгон зохион байгуулах ажлыг ялгалтын, хэсгийн болон ачааны өртөөдөд гүйцэтгэх бөгөөд тийм өртөөдийн нэрсийн жагсаалтыг төмөр замын тээврийн байгууллага батлана.

Мөрдөгдөж байгаа галт тэрэг найруулах төлөвлөгөөтэй ачаа тээвэрлэлтийн төлөвлөгөөг харьцуулахад зарим чиглэлийн вагон урсгалын хэмжээ өөрчлөгдсөн тохиолдолд галт тэрэг найруулах төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж тогтмол хяналт тавьбал зохино.


4.4.2. Галт тэрэг найруулах жилийн төлөвлөгөөг зохиох үндсэн өгөгдөл.

- а. Техникийн өртөө бүрээр өнгөрүүлэх вагоны тоо, чиглэлийг тооцоолж тогтоох;
- б. Ачааны галт тэрэг найруулах болон түүнд ажиллагаа хийх өртөөдийн жагсаалт;
- в. Хэсгүүдээр тогтоосон галт тэрэгний жин, томъёолсон урт;
- г. Ачаатай, хоосон вагоныг мөн түүнчлэн дан зүтгүүрийг хэсгүүдээр өнгөрүүлэхэд гарах ашиглалтын зардал, түлшний зарцуулалт ба зүтгүүрийн бригадын ажиллах мөр;
- д. Ачааны галт тэрэгний хэсгүүдээр явах “цэвэр” хугацаа;
- е. Өртөөд болон уулзварын өртөөдийн ажлын технологийн горим;
- ё. Техник үйлчилгээний газрын болон вагонд коммерийн үзлэг хийх газрын ажлын технологийн горим;
- ж. Өртөөдийн техник хангамжийн болон тэдгээрийн боловсруулах, нэвтрүүлэх чадварын тухай өгөгдөл;
- з. Түүвэр, зөөврийн, дамжуулах галт тэрэгний ажиллах бүдүүвч;
- и. Төмөр замын чиглэл, өртөөдийн бодит ажил ба мөрдөгдөж байгаа галт тэрэг найруулах төлөвлөгөөний биелэлтэд хийсэн шинжилгээ;

4.4.3. Галт тэрэг найруулах төлөвлөгөө боловсруулах дараалал.

- а. Галт тэрэг найруулах төлөвлөгөөг боловсруулахад шаардагдах үндсэн өгөгдлийг тодотгох;
- б. Галт тэрэг найруулах өртөөд хооронд үүссэн ачаатай вагон урсгалыг тооцоолж дэд бүтэц хоорондын уулзварын өртөөдөөр солилцох вагон урсгал, илгээгчийн замналтай уялдуулах;
- в. Хоосон вагон цагийн тооцоог томоохон хүлээн авагч, вагоны төрлөөр тооцоолж чиглэлийн бүдүүвч зохиох;
- г. Галт тэрэг найруулах төлөвлөгөөг тооцоолоход шаардагдах бүх норм, өгөгдлийг судлах;
- д. Ачааны хурдавчилсан ба бусад тусгай галт тэрэг найруулах төлөвлөгөөг зохион галт тэрэгний хөдөлгөөний зурмагтай уялдуулах;
- е. Галт тэрэг найруулах хялбаршуулсан төлөвлөгөөг вагон урсгалын аялах чиглэлийн дагуу төмөр замын хэсэг, өртөөдийн ачаалал, техник хангамж, хөгжлийг тооцон сонгож төлөвлөх;
- ё. Галт тэрэг найруулах төлөвлөгөөг галт тэрэгний хөдөлгөөний зурмагийн хүрээнд биелүүлэх боломж байгаа эсэхийг тооцооны дүнгээр шалгах (түүвэр, зөөврийн, дамжуулах галт тэргийг тооцон);
- ж. Галт тэрэг найруулах төлөвлөгөөг галт тэрэгний хөдөлгөөний зурмагтай харилцан уялдуулах;
- з. Галт тэрэг найруулах төлөвлөгөөний үзүүлэлтийг тооцоолж мөрдөгдөж байгаа төлөвлөгөөний үзүүлэлттэй харьцуулж шинээр мөрдөх, найруулах төлөвлөгөөний талаар тайлбар бичих;
- и. Шинээр мөрдөх галт тэрэг найруулах төлөвлөгөөг төмөр замын тээврийн байгууллага батлана;

4.4.4. Хөдөлгөөний бодит хэмжээ төлөвлөснөөс мэдэгдэхүйц өөрчлөгдсөн мөн зарим чиглэл, өртөөний нэвтрүүлэх чадварт хүндрэл гарсан эсвэл вагон урсгал нь ачаа илгээгч, хүлээн авагчийн боловсруулах чадвараас хэтэрсэн тохиолдолд ачаатай ба хоосон вагон урсгалын тогтоосон чиглэлийг өөрчилж болно.



Зураг 2. Вагон урсгалыг зохион байгуулах бүдүүвч.

4.5. Вагон урсгалын замналжуулалт

4.5.1. Ачаатай ба хоосон вагон урсгалыг хүрэх өртөөдөд хүргэх технологи ажиллагааг боловсронгуй болгох зорилгоор галт тэрэг найруулах төлөвлөгөөнд илгээгчийн замналын галт тэрэгний чиглэлийг тусгасан байвал зохино.

Илгээгчийн замналын галт тэргийг нийтийн бус хэрэглээний замаас төмөр замын тээврийн байгууллагатай байгуулсан гэрээний дагуу найруулна.

Ачаа тээвэрлэлтийг замналаар зохион байгуулах ажлын технологи:

- а. Замналын галт тэрэгний жин ба томьёолсон уртыг тогтоох;
- б. Замналын галт тэрэгний бүрэлдэхүүнийг ачих, найруулах, хүргэх, буулгах ажиллагааны журмыг тодорхойлох;
- в. Гогцоо¹ замналын эргэх бүдүүвчийг зохиох;
- г. Илгээгчийн болон техникийн замналын төлөвлөгөө зохиож үр ашгийг тооцоолох;
- д. Илгээгчийн болон техникийн замналын хөдөлгөөний зурмаг зохиох;
- е. Ачаа тээвэрлэлтийн захиалгыг үндэслэж ачаа илгээгчтэй хамтран илгээгчийн галт тэрэгний бүрэлдэхүүнийг ачих хуанлийн төлөвлөгөө зохиох;
- ё. Гогцоо замналын хуанлийн төлөвлөгөө зохиох;
- ж. Хоосон вагоноос бүрдсэн илгээгчийн замнал (зам зуурт нэмж вагон залгахаар эсвэл бүрэлдэхүүнийг хэсгээр өнгөрүүлэх уртын нормоор) найруулах;

4.5.2. Буулгалтын өртөөнөөс хоосон вагоноос бүрдсэн илгээгчийн замнал найруулахдаа ачаатай ирсэн байдлаар бүрэлдэхүүнийг найруулж болно.

¹ Буулгалтаас суларсан вагонуудыг ачигдсан өртөөний нийтийн бус хэрэглээний замаас дахин ачихаар хоосноор буцааж явуулахыг байнгын бүрэлдэхүүнтэй гогцоо замнал гэнэ.

Вагон илгээлт эсвэл бүлэглэсэн илгээлтээр ачаатай ирж суларсан хоосон вагон, мөн түүнчлэн өртөөний замд хоосноор зогсож байгаа вагоноор илгээгчийн болон техникийн шууд замналыг галт тэрэгний хөдөлгөөний зурмагаар тогтоосон уртаар найруулна.

Замналын бүрэн байдлыг бүх замын турш хадгалахын тулд техник эдийн засгийн тооцоог үндэслэн жин ба уртын нормоор тогтоож болно.

4.5.3. Тээвэрлэгч нь хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэгийн оператор болон ачаа илгээгчтэй тохиролцсон нөхцөлд хоосноор буцах гогцоо замналын вагоныг буцах замын дагуух нэг өртөөнд буух ачаатайгаар явуулж болно.

Аялах бүдүүвчээс хамааруулан гогцоо замналыг 4 төрөлд хуваана.

- а. Ачих ба буулгах өртөөдийн хооронд эргэх;
- б. Ачилтын нэг өртөө ба буулгах хэд хэдэн өртөөний хооронд эргэх;
- в. Ачилтын хэд хэдэн өртөөд ба буулгах нэг өртөө хооронд эргэх;
- г. Ачилт буулгалтын 3 ба түүнээс дээш өртөөдийн хооронд эргэх;

Гогцоо замналыг нэг дэд бүтэцийн хүрээнд хэд хэдэн өртөөд хооронд ашиглах бол тээвэрлэгч, хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэгийн оператор, ачаа илгээгч, хүлээн авагч нар харилцан зөвшилцсөн байвал зохино.

4.5.4. Дэд бүтцийн ачааллыг оновчтой болгох, ялгалтын ажлыг багасгах зорилгоор илгээгчийн замналд хамаардаггүй их хэмжээний ачаатай ба хоосон вагон урсгалтай үед дэд бүтцийн техник технологийн боломж техник эдийн засгийн тооцоог үндэслэж ачааг төрлөөр эсвэл хүлээн авагчаар ялган техникийн замнал зохион байгуулна.

Хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэгийн операторын хоосон вагоноор илгээгчийн замналыг найруулахдаа өртөөний нийтийн болон нийтийн бус хэрэглээний замыг ашиглан зохион байгуулна.

Өртөөний нийтийн хэрэглээний замд илгээгчийн замнал найруулахдаа төмөр замын тээврийн байгууллагатай байгуулсан гэрээний дагуу гүйцэтгэнэ. Гэрээнд дараах зүйлсийг тусгана:

- а. Өртөөний нийтийн хэрэглээний замд замнал найруулахад зарцуулах хугацаа;
- б. Замналаар тээвэрлэхэд шаардагдах хоосон вагоны захиалгыг зөвшилцөх;
- г. Нийтийн хэрэглээний замыг ашигласан вагон зогсолтын хугацааны төлбөр;

Нийтийн бус хэрэглээний замд илгээгчийн замнал найруулсан үед явуулахад бэлэн болсон замналыг нийлэх өртөө рүү гаргахдаа “Төмөр замын техник ашиглалтын дүрэм”-ийн заалтыг баримтлана.

4.5.5. Ачаатай вагоноор найруулах замнал

Ачаатай вагон урсгал ихээр цуглардаг болон ачилтын (өртөө) цэгээс:

1. Техникийн замнал зохион байгуулах өртөөд:

- а. “Улаанбаатар төмөр зам” ХНН
 - Сүхбаатар өртөө
 - Дархан I өртөө
 - Дархан II өртөө
 - Зүүнхараа өртөө
 - Толгойт өртөө

- Улаанбаатар I өртөө
- Улаанбаатар II өртөө
- Чойр өртөө
- Сайншанд өртөө
- Замын-Үүд I өртөө
- Замын-Үүд II өртөө

б. “Монголын төмөр зам” ТӨХК

- Цэций өртөө

2. Илгээгчийн шууд замнал зохион байгуулах өртөөд: (экспорт)

а. “Улаанбаатар төмөр зам” ХНН

- Олон Овоо өртөө
- Эрдэнэт өртөө

б. “Монголын төмөр зам” ТӨХК

- Төмөртэй өртөө

в. “Болд төмөр ерөө гол” ХХК

- Хандгайт өртөө

г. “Тавантолгой төмөр зам” ХХК

- Тавантолгой өртөө

3. Илгээгчийн орон нутгийн замнал зохион байгуулах өртөөд:

а. “Улаанбаатар төмөр зам” ХНН

- Багануур өртөө
- Шивээ овоо өртөө
- Олон овоо өртөө

б. “Монголын төмөр зам” ТӨХК

- Цэций өртөө
- Төмөртэй өртөө

Өртөөдөөс техникийн болон илгээгчийн замналд ороогүй ачаатай вагоноор хэсгийн, түүвэр, дамжуулах, зөөврийн галт тэргийг чиглэлийн дагуу найруулна.

4.5.6. Хоосон вагоноор найруулах замнал

Ачаа ихээр буулгадаг, вагоныг ачилтанд бэлтгэдэг (засвар, цэвэрлэгээ, угаах, ариутгах зэрэг) газар бүхий өртөө болон хоосон вагон ихээр цуглардаг техникийн, хэсгийн өртөөдөөс дараах төрлийн галт тэргийг найруулж явуулна.

Техникийн болон хэсгийн өртөөдөөс:

- хоосон вагоноос бүрдсэн техникийн болон илгээгчийн шууд замнал;
- хоосон вагоноос бүрдсэн илгээгчийн шууд замнал;
- буулгалтын өртөөнөөс замналд хамаарагдаагүй хоосон вагоныг хэсгийн, түүвэр, дамжуулах, зөөврийн галт тэргэнд холбоно.

Галт тэрэг найруулах төлөвлөгөөнд тусгагдаагүй өртөөд хоногийн ажлын төлөвлөгөө, тохируулгын даалгаврын дагуу хоосон вагоныг ачааны галт тэргэнд холбож явуулна.

ТАВ. АЧАА ТЭЭВЭРЛЭЛТИЙН САРЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

5.1. Ачаа тээвэрлэлтийн сарын төлөвлөгөөний үндсэн зорилт нь дэд бүтцийн техник, технологийн боломж, ачааны нөөцөд тулгуурлан ачааг захиалгын дагуу тээвэрлэх явдал юм.

5.1.1. Тээвэрлэлтийн төлөвлөлт нь дараах ажлуудад үндэслэгдэнэ.

а. Тээвэрлэлт зохион байгуулах тухай урт хугацааны гэрээ байгуулах талаар ачаа илгээгчтэй хамтран ажиллах;

б. Ачаа илгээгчээс ирүүлсэн тээвэрлэх ачааны талаар бусад төмөр замын тээврийн байгууллагуудтай зөвшилцөх;

в. Төлөвлөсөн тээвэрлэлтийн төлөвлөгөөг дэд бүтцүүдийн техник, технологийн боломжийг бүрэн ашиглан биелүүлэх;

Ачаа илгээгч нь төмөр замаар ачаа тээвэрлүүлэх захиалгыг орон нутгийн харилцаанд бол илгээх өртөөнд, харин олон улсын харилцаанд бол тээвэрлэх эрх бүхий төмөр замын тээврийн байгууллагад ирүүлнэ.

Ачаа тээвэрлүүлэх захиалагад хүрэх өртөөний нэр, код, салбар замын нэр, ачааны нэр болон түүний уялдуулсан нэрийн код, илгээлтийн төрөл зэргийг тусгасан байна.

Олон улсын харилцаанд тээвэрлэх ачааны захиалгад хилийн дамжин өнгөрөх өртөөний нэрийг заана.

5.1.2. Төмөр замын тээврийн байгууллага захиалгыг хүлээн авах, зөвшилцөх

Ачаа илгээгч ачаа тээвэрлүүлэх захиалгыг орон нутгийн харилцаанд тээвэрлэх сар эхлэхээс 10 хоногийн өмнө, олон улсын харилцаанд 15 хоногийн өмнө тус тус төмөр замын тээврийн байгууллагад ирүүлнэ.

Тээвэрлэгч нь өртөөдийн авсан захиалгыг нэгтгэн судалж, тээвэрлэх боломжтой гэж үзвэл тээврийн төлөвлөгөөний төслийг дэд бүтэц эзэмшигчтэй зөвшилцөхөөр явуулна.

Дэд бүтэц эзэмшигч нь олон улсын төмөр замын харилцаанд ачаа тээвэрлэх тухай тээвэрлэгчээс ирүүлсэн төслийг 10 хоногийн дотор зөвшилцөнө.

Орон нутгийн харилцаанд ачааг тээвэрлэх төлөвлөгөөний төслийг дэд бүтэц эзэмшигчтэй зөвшилцөн батлаж 2 хоногийн дотор өртөөдөд хүргүүлнэ.

Ачаа илгээгчийн ачаа тээвэрлүүлэхээр ирүүлсэн захиалгыг тээвэрлэгч, эсвэл дэд бүтэц эзэмшигч хэсэгчлэн зөвшөөрөх, татгалзах, захиалгад өөрчлөлт оруулах тохиолдолд төмөр замаар ачаа тээвэрлэх дүрмийн дагуу захиалгад өөрчлөлт оруулна.

ЗУРГАА. АШИГЛАЛТЫН АЖЛЫН ТЕХНИКИЙН НОРМЧЛОЛ

6.1. Ерөнхий байдал

Тээвэрлэлтийн үйл ажиллагааг удирдах чухал асуудлын нэг бол дэд бүтцүүдийн техник технологи болон тээврийн хэрэгслэлийг үр дүнтэй ашиглан, тээвэрлүүлэгчийн тээврийн хэрэгцээг

бүрэн ханган тээвэрлэлтийн төлөвлөгөөг биелүүлэх, тээвэрлэлтийн ажлыг өгөөжтэй зохион байгуулж ашиглалтын зардлыг багасгах явдал юм.

Ачаа тээврийн захиалгыг үндэслэн төмөр замын тээврийн байгууллагууд өөрсдийн дэд бүтцийн болон өртөөдийн сарын техникийн нормыг боловсруулна.

Техникийн нормыг боловсруулах үндсэн өгөгдөл нь:

- а. Ачаа тээвэрлэлтийн төлөвлөгөө;
- б. Зүтгүүр ба вагоны паркийн байршил, тоо;
- в. Шугамын тээх, нэвтрүүлэх чадвар, өртөөний болон ачааны зам, талбайн боловсруулах чадвар;
- г. Галт тэрэгний хөдөлгөөний зурмаг;
- д. Галт тэрэг найруулах төлөвлөгөө;

Техникийн нормоор тээвэрлэлтийн ажлын тоон болон чанарын үзүүлэлт, шаардлагатай хөдлөх бүрэлдэхүүний тоо хэмжээг тогтооно. Дэд бүтцүүд өөрсдийн ажлын техникийн төлөвлөгөөг тодорхойлохын тулд ачаатай вагон урсгалын хүснэгтийг зохионо. (хүснэгт 6.1)

Ачилт буулгалтын ажиллагааны үзүүлэлтийн нормыг ташуу хүснэгтийг ашиглан тодорхойлно.

| | | Өртөөд | | | | Бүгд | Уулзварын өртөө | | | Бүгд | Нийт |
|-----------------|-----|--------|---|---|-----|----------------|-----------------|---|---|----------|--------------|
| | | 1 | 2 | 3 | ... | | А | Б | В | | |
| Өртөөд | 1 | | | | | | | | | | |
| | 2 | | | | | | | | | | |
| | 3 | | | | | | | | | | |
| | ... | | | | | | | | | | |
| Бүгд | | | | | | дамжин өнгөрөх | | | | оруулалт | Хүлээн авалт |
| Уулзварын өртөө | А | | | | | | | | | | |
| | Б | | | | | | | | | | |
| | В | | | | | | | | | | |
| Бүгд | | | | | | гаргалт | | | | о/нутаг | ачилт |
| Нийт | | | | | | х/өгөлт | | | | буулгалт | ажил |

Хүснэгт 6.1. Ачаатай вагон урсгалын ташуу хүснэгт.

Ачаатай вагон урсгалыг 4 бүлэгт хуваана:

1. **Дамжин өнгөрөх** - Бусад улс, дэд бүтцээс ажиллагаа хийлгүйгээр зэргэлдээх улс, дэд бүтцэд дамжуулах вагонууд;

2. **Оруулалт** - Зэргэлдээх улс, дэд бүтцээс ирэх тухайн дэд бүтцийн өртөөдөд буулгах ачаатай вагонууд;
3. **Гаргалт** - Тухайн дэд бүтцийн өртөөдөөс зэргэлдээх улс, дэд бүтэцэд буухаар эсвэл тэдгээрээр шууд дамжин өнгөрөхөөр ачигдсан вагонууд;
4. **Орон нутаг** - Тухайн дэд бүтцийн өртөөдөд ачигдаж өөрийн өртөөдөд буух ачаатай вагон;

6.2. Техникийн төлөвлөгөө боловсруулах

Төлөвлөгөөт сар эхлэхээс 15 хоногийн өмнө ирэх сарын тээвэрлэлтийн төлөвлөгөөг эцэслэн шийдвэрлэхээр дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэгийн операторын техник, технологийн боломжийг судлана.

| Гүйцэтгэгч | Үзүүлэлтүүд | сарын өдрүүд | | | | | | | | | | | | | | | |
|--|---|--------------|----|----|----|----|----|----|----|----|----|----|----|----|----|----|----|
| | | 15 | 16 | 17 | 18 | 19 | 20 | 21 | 22 | 23 | 24 | 25 | 26 | 27 | 28 | 29 | 30 |
| ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН БАЙГУУЛЛАГЫН ТЭЭВЭР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН НЭГЖ | Дэд бүтцийн нэвтрүүлэх чадварын хязгаарлалтыг тооцон төвөвлөгдөж байгаа сарын ачаа тээвэрлэлтийн төлөвлөгөөг (ачааны хэмжээ) хангах вагон урсгалын диаграммыг урьдчилсан байдлаар зохиох -1 хоног | ■ | | | | | | | | | | | | | | | |
| | Ачилтын төлөвлөгөөг вагоноор, вагоны төрлөөр зохиох -3 хоног | | ■ | ■ | ■ | | | | | | | | | | | | |
| | Вагон урсгалын ташуу хүснэгтийг вагоны төрлөөр зохиох -1 хоног | | | | ■ | | | | | | | | | | | | |
| | Урьдчилсан вагон урсгалын ташуу хүснэгтийг хэлэлцэж үнэлгээ өгөх, шаардлагатай бол өөрчлөлт оруулж эцсийн байдлаар зохиох | | | | | ■ | | | | | | | | | | | |
| | Ачилтын төлөвлөгөөг вагоноор болон төрлөөр эцсийн байдлаар төлөвлөх | | | | | | ■ | | | | | | | | | | |
| | Вагон эргэлтийн хугацааг урьдчилсан байдлаар бүтцээр нь тодорхойлох (дамжин өнгөрөх, орон нутаг, хоосон вагон) | | | | ■ | ■ | ■ | | | | | | | | | | |
| | Вагоны тохируулгын төрлөөр тооцоолох | | | | ■ | ■ | ■ | | | | | | | | | | |
| | Буулгалтын хугацааг вагоны төрлөөр тодорхойлох | | | | | | | ■ | | | | | | | | | |
| | Хоосон вагон урсгалын ташуу хүснэгтийг оруулах гаргах өртөөдөөр, вагоны төрлөөр зохиох | | | | | | | ■ | | | | | | | | | |
| | Дэд бүтцүүд болон улс хоорондын хоосон вагон солилцооны норм, вагоны төрлөөр | | | | | | | | ■ | | | | | | | | |
| | Дэд бүтэц болон улс хоорондын уулзварын өртөөдөөр дамжуулах галт тэрэгний хэмжээ | | | | | | | | | ■ | | | | | | | |
| | Ажлын паркийн ачааны вагоны тооцоо, эзэмшигчээр, бүтцээр (дамжин өнгөрөх, хоосон, орон нутаг), вагоны төрлөөр | | | | | | | | | | ■ | | | | | | |
| | Ашиглалтын ажлын техникийн төлөвлөгөөний тайлбар бичиж замын удирдлагад танилцуулах | | | | | | | | | | | ■ | | | | | |
| | Ачааны вагоны эргэх хугацааны тооцоо эцсийн байдлаар бүгд бүтцээр (дамжин өнгөрөх, хоосон, орон нутаг) | | | | | | | | | | | | ■ | | | | |
| Төмөр замын тээврийн байгууллагын дарга техникийн төлөвлөгөөг батлах | | | | | | | | | | | | | ■ | | | | |

Хүснэгт 6.2. Ашиглалтын ажлын техникийн нормын үзүүлэлтийг төлөвлөх зурмаг

6.3. Техникийн төлөвлөгөөний нормыг тооцоолох журам.

а. Хоосон вагоны хэрэгцээг тохируулахын тулд түүний тэнцлийг вагоны төрлөөр тооцоолох;

б. Харилцан биенээ орлох чадвартай хоосон вагонуудыг төрлөөр, эзэмшигчээр хуваарилан тэдгээрийн хоосон гүйлт хамгийн бага байх зарчмыг баримтлан, дөт чиглэлийг сонгон, дэд бүтцүүдийн уулзварын өртөөдөд хүргэх бүдүүвчийг боловсруулах;

в. Уулзварын өртөө бүрээр дамжуулах хоосон вагон урсгалын хэмжээг тооцоолох;

г. Дэд бүтцийн болон улс хоорондын уулзварын өртөөдөөр солилцох ачаатай болон хоосон вагоны хэмжээ, галт тэрэгний тоог тооцоолох;

Буулгалт: - Нийтийн болон нийтийн бус хэрэглээний замд буусан, ачаатайгаар бусад дэд бүтцийн болон улс хоорондын уулзварын өртөөдөөр хүлээлгэн өгсөн вагоноор тодорхойлогдоно.

Буулгалтын нормд замын хэмжээнд илүүдлээр зогсч байгаа орон нутгийн вагоныг нэмж тооцож болно.

Ажлын парк - Дэд бүтцийн хэмжээнд байгаа ажлын паркийн нийт вагоныг ачаатай, хоосон болон вагоны төрлөөр тодорхойлно.

Дэд бүтцийн хэмжээнд өртөөдийн ажлын технологиос хамааруулан ачилт, буулгалт, вагоны сул зогсолт, ажлын парк, татах зам, довоор боловсруулсан вагоны тоо, техникийн өртөөдөд орон нутгийн болон дамжин өнгөрөх вагоны зогсолтын нормыг ажиллагаатай ба ажиллагаагүй гэж ялган тооцоолно.

Техникийн төлөвлөгөөний батлагдсан хувийг боловсруулсан тооцооны хамт Хөдөлгөөний нэгдсэн удирдлага, зохицуулалт хариуцсан байгууллагад ирүүлнэ.

Хөдөлгөөний нэгдсэн удирдлага, зохицуулалт хариуцсан байгууллага нь дэд бүтцүүдээс ирүүлсэн техникийн төлөвлөгөөг нэгтгэн төмөр замын сүлжээний ашиглалтын ажлын техникийн төлөвлөгөөг боловсруулж батлуулна.

ДОЛОО. ГАЛТ ТЭРЭГНИЙ УДИРДЛАГЫН ТЕХНОЛОГИ

7.1. Дэд бүтцүүдийн галт тэрэгний хөдөлгөөнийг удирдан зохион байгуулах үүрэгтэй диспетчерийн шуурхай нэгж ажиллана.

Өртөөдийн хэмжээнд шуурхай удирдлагыг өртөөний (сэлгээний) диспетчер ба өртөөдийн жижүүр удирдана.

Тээврийн ажлыг удирдах, шуурхай төлөвлөх, ашиглалтын ажлын үр өгөөжийг дээшлүүлэх, технологийн сахилгыг бэхжүүлэх, ажиллагсдын хөдөлмөрлөх нөхцөл, ая тухыг нэмэгдүүлэх, ажлын уялдаа холбоо, хамтын ажиллагааг хангахын тулд диспетчерийн нэгдсэн ээлжийг зохион байгуулна.

7.1.1. Галт тэрэгний хөдөлгөөний диспетчерийн удирдлага нь дараах зорилтыг хэрэгжүүлнэ.

а. Галт тэрэгний хөдөлгөөний хоногийн, ээлжийн ажлын болон үечилсэн² төлөвлөгөө, ашиглалтын ажлын даалгаврыг биелүүлэхтэй холбоотой диспетчерийн нэгдсэн ээлжийг зохион байгуулах;

б. Галт тэрэгний хөдөлгөөний зурмагийн биелэлтийг хангах;

в. Бусад дэд бүтцийн болон улс хоорондын уулзварын өртөөдөөр галт тэрэг дамжуулах ажиллагааг саадгүй гүйцэтгэх;

г. Галт тэрэгний ба хөдөлмөрийн аюулгүй байдал, өртөөдийн техник захирамжийн акт, технологийн горим, дэд бүтэц эзэмшигчийн өртөөтэй нийлсэн нийтийн бус хэрэглээний замын өртөө хоорондын үйл ажиллагааны нэгдсэн технологийн горим зэрэг нормативын баримт бичгийн шаардлагыг хангах;

д. Орон нутгийн ажлыг удирдах;

е. Дэд бүтцийн засвар үйлчилгээ, барилга угсралтын ажлыг гүйцэтгүүлэхээр цаг хугацаанд нь “Цонх” гаргах;

ё. Зүтгүүрийн бригадыг үр бүтээлтэй ашиглах;

ж. Ашиглалтын паркийн зүтгүүрүүдийн ашиглалт, арчлалтад хяналт тавих;

з. Ачилтын нөөцийг тохируулах;

и. Орон нутгийн ажлыг зохион байгуулах;

й. Ажлын паркийн вагоноор гүйцэтгэх ажлын хэмжээг хянах;

к. Галт тэрэгний хөдөлгөөнд гарсан гэмтэл, саадыг цаг хугацаанд нь арилгуулахаар төмөр замын тээврийн байгууллагын удирдлагын шийдвэрээр сэргээн босгох,галын болон аж ахуйн галт тэргийг өнгөрүүлэх нөхцлийг хангах;

7.1.2. Диспетчерийн шуурхай нэгж нь ажлын явцад төмөр замын тээврийн байгууллагын болон бусад газрын нэгжтэй дараах асуудлаар хамтран ажиллана.

а. Зүтгүүр, зүтгүүрийн бригад, тэдгээрийн хуваарилалтын талаар зүтгүүрийн диспетчертэй;

б. Замын засвар, арчилгаа үйлчилгээ, ДТХ ба холбооны төхөөрөмж, байгууламж, ачааны вагоны засвар, техникийн үйлчилгээ, гэмтлийг арилгах, хөдөлгөөнийг сэргээх асуудлаар холбогдох албадын хариуцсан албан тушаалтантай;


в. Галт тэрэгний хөдөлгөөний зурмагт тусгагдсан тусгай хуваарийг ашиглах, ачаатай ба хоосон вагоныг явуулах, хүргэх хугацааг биелүүлэхээр ачааны диспетчертэй;

г. Бусад дэд бүтэц эзэмшигчийн диспетчерийн шуурхай нэгжтэй галт тэрэг, вагон солилцох ажлыг зохион байгуулах асуудлаар;

д. Хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэгийн оператортой хоосон вагоны ажил ба бусад тээвэрлэлттэй холбоотой асуудлаар;

е. Онцгой байдлын газрын диспетчертэй - Үндэсний аюулгүй байдал, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллийн талаар;

² Үечилсэн төлөвлөлт гэж тухайн үеийн галт тэрэгний болон ачааны ажлын өөрчлөлтөөс хамааруулан хоног, ээлжийн батлагдсан төлөвлөгөө даалгаврыг 3-6 цагийн үелзэлтэйгээр шуурхай байдлаар тодотгон төлөвлөхийг хэлнэ.



Зураг 3. Галт тэрэгний ажлын удирдлага, нормчлол, төлөвлөлтийн горим.

ТАД – Төмөр замын техник ашиглалтын дүрэм;
ГТХЗ – Галт тэрэгний хөдөлгөөний зурмаг;

ГНТ – Галт тэрэг найруулах төлөвлөгөө
ГТГЗ – Галт тэрэгний хөдөлгөөний гүйцэтгэсэн зурмаг.

7.2. Галт тэрэгний ажлыг шуурхай төлөвлөх

7.2.1. Мэдээллийн нэгдсэн санг ашиглан ашиглалтын ажлын удирдлагын бүх түвшинд хамтран ажиллахыг шууд технологи гэх бөгөөд түүнд дараах асуудлууд хамаарна:

- а. Галт тэрэг бүрдэлт ба галт тэрэгний ажлыг шуурхай төлөвлөх технологи;
- б. Ачааны зүтгүүр, зүтгүүрийн бригадыг тохируулах технологи;
- в. Түүвэр, зөөврийн болон дамжуулах галт тэрэгний ажлыг шуурхай төлөвлөх технологи;
- г. Ачааны хоёрлосон ажиллагааг тооцсон ачилтын нөөцийг ашиглах технологи;
- д. Галт тэрэгний бүрэлдэхүүнд техникийн үйлчилгээ хийх ба ачааны вагоныг ачилтанд бэлтгэх, техник үйлчилгээний газрын үзэгч, засварчдын тоог шуурхай тохируулах технологи;

Шуурхай төлөвлөлт нь удирдлагын дараах түвшинд үйлчилнэ.

- а. Төмөр замын тээврийн байгууллагуудын нэгжүүд
- б. Өртөө, зүтгүүрийн болон вагон депо

7.2.2. Төмөр замын тээврийн байгууллагын хөдөлгөөнийг удирдах нэгж нь галт тэрэгний хөдөлгөөний зурмагийн төлөвлөлтөд дараах зорилтуудыг хэрэгжүүлбэл зохино.

- а. Галт тэрэг урсгалыг тасралтгүй жигд, саадгүй өнгөрүүлэх;
- б. Галт тэрэгний хөдөлгөөний зурмагт тохируулан уулзварын өртөөдөөр ачааны галт тэрэг солилцох;
- в. Хөдлөх бүрэлдэхүүний ашиглалтын ажлын үндсэн үзүүлэлтүүдийг биелүүлэх;
- г. Дэд бүтцийн нэвтрүүлэх чадварыг үр бүтээлтэй ашиглах;
- д. Ачаатай ба хоосон вагоны хүргэх хугацааг баримтлах;
- е. Техникийн өртөөд дэх ажиллагаатай ба ажиллагаагүй дамжин өнгөрөх вагоны зогсолтын нормыг биелүүлэх;
- ё. Гэмтэлтэй вагоныг засварын замд тавих, засварт байх тогтоосон хугацааг баримтлах;
- ж. Дэд бүтцэд хийгдэх төлөвлөгөөт засвар, үйлчилгээний ажилд гаргах “Цонх”-ыг хугацаанд нь олгох;
- з. Галт тэргэнд техникийн үйлчилгээ хийх, техник үйлчилгээний газрын вагон үзэгчид болон зүтгүүр, зүтгүүрийн бригадыг оновчтой байршуулан үр дүнтэй ажиллах;

7.2.3. Төлөвлөж байгаа хоногийн эхэнд дэд бүтцийн хэмжээнд бэлэн хүлээгдэж байгаа вагонуудыг тодорхойлно.

Дамжин өнгөрөх вагоныг – Төлөвлөж байгаа хоногийн эхэнд бэлэн байгаа болон бусад дэд бүтцүүдээс ирэх дамжин өнгөрөх вагон, бусад дэд бүтцүүдэд очихоор ачигдсан вагоны нийлбэрээс тухайн хоногт хүлээлгэн өгөх вагоныг хасч;

Орон нутгийн ачаатай вагон - Төлөвлөж байгаа хоногийн эхэнд байсан орон нутгийн ачаатай вагон ба бусад дэд бүтцүүдээс тухайн дэд бүтцийн өртөөдөд буухаар ирэх ачаатай вагон, өөрийн өртөөдөд буухаар ачигдсан вагоны нийлбэрээс төлөвлөсөн хоногт буулгасан вагоны тоог хасч;

Хоосон вагон - Төлөвлөж байгаа хоногийн эхэнд байсан хоосон вагон болон хоосноор бусад дэд бүтцүүдээс ирсэн, ачааг нь буулгасан вагоны нийлбэрээс хоосноор хүлээлгэн өгсөн болон ачигдсан вагоныг хасч тус тус тодорхойлно.

Хоногийн эхэнд хүлээгдэж байгаа ачаатай, хоосон дамжин өнгөрөх, орон нутгийн ба хоосон вагон, шууд харилцаанд ачихаар төлөвлөсөн, буулгалтаас суларсан, хоосон вагоны хүлээлгэн

өгөлт, зэргэлдээх дэд бүтцээс хүлээн авах дамжин өнгөрөх болон тухайн дэд бүтцийн өртөөдөд буух ачаатай болон хоосон вагоны хүлээн авалтыг төлөвлөж байгаа хоногт уулзварын өртөө бүрээр тооцоолно.

7.2.4. Галт тэрэгний хоногийн ажлыг төлөвлөх үед ачааны вагоныг ашигтайгаар хуваарилан байрлуулах мөн түүнчлэн дэд бүтэц доторхи вагон урсгалын тохируулга нь төлөвлөж байгаа галт тэрэгний хэмжээ, хэсгийн тээх нэвтрүүлэх чадвараас хэтрэхгүй байхаар тооцоолно.

Галт тэрэгний хөдөлгөөний диспетчерийн тойрог, ялгалтын өртөөдийг вагон, бүрэлдэхүүнээр хангах ажлыг тэдгээрийн хүчин чадлаас хэтрүүлэхгүй байхаар зохицуулна.

7.2.5. Галт тэрэгний хоногийн ажлын төлөвлөгөөг зохиохдоо дэд бүтэц хоорондын уулзварын өртөөдөөр хүлээлгэн өгөх галт тэрэг, вагоны тоо болон тохируулгаар илгээгдсэн галт тэрэгний зүтгүүрийг хөдөлгөөний зурмагийн төлөвлөсөн хувааритай (нитка) уялдуулах

Галт тэрэгний хоногийн ажлын төлөвлөгөөний төслийг хөдөлгөөнийг удирдах нэгжийн дарга болон орлогч дарга нар шаардагдах зохицуулалтыг хийж төлөвлөгөөг бэлэн болгон дараах үзүүлэлтүүдийг тооцоолно.

- а. Уулзварын өртөөдөөр солилцох галт тэрэг, вагоны тоо;
- б. Дэд бүтцийн ажлын паркийн вагоны тоо;
- в. Ашиглалтын паркийн зүтгүүрийн тоо;
- г. Хүлээлгэн өгөх галт тэрэг вагоны тоо - өртөөдөөс найруулсан дамжин өнгөрөх галт тэрэгний тоо ба хоосон вагоноос бүрдэх замналын нийлбэрээр тодорхойлогдоно.

Төлөвлөж байгаа хоногт уулзварын өртөөдөд хүргэх хугацаа нь ойртож яваа дамжин өнгөрөх галт тэргийг анхаарвал зохино.

7.2.6. **Ажлын паркийн вагоны тоо** – Төлөвлөж байгаа хоногийн эхэнд дэд бүтцийн өртөөдөд бэлэн байгаа ажлын паркийн вагон, төлөвлөхөөс өмнөх хоногийн төгсгөл хүртэл галт тэрэг, ачааны ажлын гүйцэтгэл нь хүлээгдэж байгаа болон засварын өртөөдөд түр хугацаагаар орхигдсон галт тэргэн дэх вагонуудаар төлөвлөнө.

7.2.7. **Ашиглалтын паркийн шаардагдах зүтгүүрийн тоо** – Зүтгүүрийн мөрөнд ажиллах шаардлагатай зүтгүүрийн тоог тохируулгаар яваа дан зүтгүүрийг оролцуулан хүлээн авсан, хүлээлгэн өгсөн галт тэрэгний тоо, зүтгүүрийн бригадын ажлын хэсэг бүрт нэг хос галт тэргэнд оногдох, шаардагдах зүтгүүрийн коэффициентоор үржүүлж тодорхойлох бөгөөд нийт бодит зүтгүүрийг үндэслэн өөрчлөлт оруулсан паркийг зүтгүүр үйлчлэх тодорхой мөрүүдэд хуваарилана.

Өөрчлөлтийн дүнгээр галт тэргийг жигд солилцох зорилгоор нөөцөөр (дан зүтгүүр) явуулах зүтгүүрийн парк тодорхойлогдоно.

7.2.8. Төмөр замын сүлжээн дэх дэд бүтцүүдийн галт тэрэгний ажлын үечилсэн төлөвлөгөөг зохиоход дараах асуудлуудыг шийдвэрлэнэ.

- а. Галт тэрэгнүүдийг өртөөдөд хүргэх, хүлээн авах төлөвлөгөө боловсруулах;
- б. Зүтгүүр ба зүтгүүрийн бригадаар хангагдсан, явуулахад бэлэн болсон галт тэргийг хөдөлгөөний зурмагаар (нитка) хуваарилах;
- в. Галт тэрэг найруулах төлөвлөгөө ба ялгалтын, хэсгийн, ачааны өртөөдөөс явуулах галт тэргийг зориулалт, галт тэргэн дэх бүлгийн сонголтоор тооцоолох;
- г. Галт тэрэгний хөдөлгөөний ээлжийн болон хоногийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсан зүтгүүр ба зүтгүүрийн бригадаар бэхлэгдсэн бүрэлдэхүүнийг зориулалтаар нь дугаарлах;

д. Орон нутгийн ачаатай эсвэл буулгалтаас суларсан хоосон вагоныг буулгалтын болон ачилтын өртөөдөд зөөвөрлөн хүргэх төлөвлөгөө зохиох;

7.2.9. Техникийн өртөөдөөс явуулах галт тэрэгний төлөвлөгөөг галт тэрэгний ажлын үечилсэн төлөвлөгөөний хүрээнд өртөөдийн хоорондох ажлын уялдааг хангахаар, галт тэрэг найруулах төлөвлөгөөний тооцоог хийж дараах зүйлсийг тогтооно.

а. Галт тэрэгний чиглэл ба холбох бүлэг вагоны зөвшөөрөгдсөн тоо; (галт тэрэг найруулах төлөвлөгөөний хувилбар)

б. Бүрэлдэхүүний урт ба жингийн дээд, доод хэмжээнд тохируулан чиглэл бүрийн вагоны хуримтлагдаж дуусах хугацаа;

в. Явуулах замд бүрэлдэхүүнийг шилжүүлэн тавих хугацааг тооцоолон бүрэлдэхүүн найруулж дуусах хугацаа;

г. Галт тэргийг явуулахад бэлэн болгосон хугацаа;

Галт тэрэг бүрдүүлэх тооцоонд орон нутгийн вагонд өртөөний нийтийн болон нийтийн бус хэрэглээний замууд, засварын замуудад технологийн ажиллагаа (ачилт, буулгалт, шилжүүлэн ачилт, салгалттай засвар зэрэг) гүйцэтгэж дуусгасан хугацааг нэмж тооцвол зохино.

Үүний тулд эдгээр вагонуудыг диспетчерийн зүтгүүр, зөөврийн, түүвэр, хэсгийн галт тэрэгнүүдийн алинд нь холбовол ашигтай болохыг судалж шийдэх хэрэгтэй.

Тухайн төлөвлөгдөж байгаа хугацаанд үйлчлэх галт тэрэгний хөдөлгөөний батлагдсан зурмаг эсвэл галт тэрэгний хөдөлгөөний зурмагийн хувилбарын хуваарьт (нитка) өөрөөс найруулсан ба дамжин өнгөрөх галт тэрэгний чиглэлийг дугаарчлан үзүүлнэ.

Найруулж бэлтгэсэн чингэлэгийн, хөргүүрт болон бусад хурдавчилсан галт тэрэг мөн түүнчлэн технологийн замналыг галт тэрэгний хөдөлгөөний зурмагт тусгасан тусгай хуваариар (нитка), харин галт тэргийг өнгөрүүлэх чиглэлд тохирсон жин, урттай бусад замналын галт тэргийг хөдөлгөөний зурмагийн дурын хуваариар явуулбал зохино.

НАЙМ. ОРОН НУТГИЙН АЖЛЫГ УДИРДАХ

8.1. Ерөнхий байдал

Орон нутгийн ачааг удирдан зохион байгуулах ажиллагаанд:

а. Хоосон вагоныг захиалгын дагуу ачилтын өртөөдөд хүргэх;


б. Ачигдсан вагоныг өртөөний замаас татан авч хүрэх өртөөний чиглэлд явуулах;

в. Тээвэрлүүлэгчийн захиалга, тээвэрлэлтийн төлөвлөгөөний дагуу ачилт буулгалтын ажлыг зохион байгуулах, түүвэр, зөөврийн, дамжуулах галт тэрэг найруулах, явуулах;

г. Ачаа хүргэх хугацааг баримтлах;

Орон нутгийн ажлын шуурхай удирдлагад:

Тээвэрлүүлэгч, хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэгийн оператор зэрэг тээврийн удирдлагын бүх түвшинд тухайн дэд бүтцийн диспетчерийн шуурхай нэгжийн хамтран боловсруулсан галт тэрэгний болон ачааны ажиллагааны хоног, ээлжийн ажлын болон үечилсэн төлөвлөлт болно.



Зураг 4. Орон нутгийн ажлыг удирдах ажиллагааны ерөнхий бүдүүвч.

Тайлбар: 1 – Нийтийн бус хэрэглээний зам, талбай эзэмшигчийн замд вагон тавих, татах гэрээ ба нэгдсэн технологийн горим; 2 – Вагоны ачааны ажиллагаанд байх тогтоосон норм; 3 – Тээвэрлэлтийн гэрээ зөвшилцөх; 4 – Тээвэрлэлтийн захиалга зөвшилцөх; 5 – Дэд бүтцийн өнөөгийн байдал; 6 – Зүтгүүр болон зүтгүүрийн бригад

8.2. Орон нутгийн ажлыг төлөвлөх

8.2.1. Орон нутгийн ажлын хоногийн болон ээлжийн ажлын төлөвлөлтөнд дараах ажлууд хамаарна.

а. Ачаа илгээгч, хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэгийн оператортой тохиролцсон төлөвлөгөөний дагуу хоосон вагон урсгалын хөдөлгөөнийг төлөвлөх;

б. Буулгалтаас суларсан хоосон вагонуудыг өртөөнөөс татаж авах, явуулах журам;

в. Галт тэрэгний хөдөлгөөний ажил болох орон нутгийн ачаатай, хоосон вагон урсгалын хөдөлгөөнийг төлөвлөх;

г. Өртөөний ачааны ажлын төлөвлөлт;

д. Орон нутгийн ажлын үзүүлэлтийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр ажлын паркийн нийт вагоноор, вагоны төрлөөр төлөвлөнө.

8.2.2. Орон нутгийн ажлын үечилсэн төлөвлөгөөнд дараах ажлууд хамаарна.

а. Галт тэрэг бүрдэлтийг тооцон орон нутгийн зориулалттай ачааны галт тэрэг найруулах, явуулах ажлын төлөвлөлт;

б. Түүвэр, зөөврийн, дамжуулах галт тэрэг ба диспетчерийн мэдлийн сэлгээний зүтгүүрийн ажлыг төлөвлөх;

г. Өртөөний орон нутгийн ба ачааны ажлын хоногийн болон үечилсэн төлөвлөлтийг уялдуулах;

Орон нутгийн ажлын үечилсэн төлөвлөлтийг дэд бүтэц, диспетчерийн тойрог тус бүрээр төлөвлөх бөгөөд үүнд:

а. Орон нутгийн ачаа ба ачилтанд өгөх хоосон вагонуудыг очих өртөөдөд нь зөөж хүргэх;

б. Нийтийн болон нийтийн бус хэрэглээний салбар замуудад ачилт буулгалтанд вагон тавих, татах;

в. Ачааны ажиллагаа дууссаны дараа вагонуудыг цуглуулж техникийн өртөө хүргэхээр явуулах ажлууд хамаарна.

Батлагдсан технологи, орон нутгийн галт тэрэгний хатуу зурмагтай уялдуулан зүтгүүр, вагоны байдал, хуваарилалтыг тооцон тэдгээрийн ажлыг нийтийн болон нийтийн бус хэрэглээний зам, талбайн ажиллах дэглэмийг ашигтайгаар нийцүүлэн түүвэр, зөөврийн, дамжуулах галт тэрэг, диспетчерийн мэдлийн сэлгээний зүтгүүрийн ажлыг төлөвлөх, өртөөдөд ажиллах журмыг зааж орон нутгийн галт тэргийг дугаарчлан товлон.

Төлөвлөх үед хоосон вагоны хуваарилалтыг өөрийн ачилтанд үлдээх, тохируулгын даалгавраар явуулах, нөөцөнд тавихаар тооцвол зохино. Ээлжийн ахлах диспетчер шаардлагатай үед орон нутгийн ажлын үечилсэн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулна.

а. Техникийн үндсэн өртөөнөөс явуулах галт тэргэнд зүтгүүрийг товллох;

б. Техникийн үндсэн өртөөнөөс найруулсан зөөврийн галт тэрэгний явуулах хугацааг товллох;

в. Зөөврийн галт тэрэгний хөдөлгөөн болон түүвэр, зөөврийн галт тэргийг өртөөдөөс явуулах, очих хугацаа;

г. Хөдөлгөөнд “Цонх” гаргаж хөдөлгөөнийг түр хугацаагаар зогсоосон нөхцөлд хэсгийн, түүвэр, зөөврийн галт тэрэгнүүдийг өнгөрүүлэх болон зурмагийн хуваарийг (нитка) өөрчлөх

зайлшгүй шаардлагатай төрөл бүрийн хүндрэл, саатал гарсан үед галт тэрэгний хөдөлгөөнийг зохион байгуулахад шаардлагатай шийдвэрийг гаргах;

Ачилтын хэд хэдэн өртөөнөөс шатласан замнал зохион байгуулах үед ачилтын өртөөдийн ээлжийн болон хоногийн төлөвлөгөө даалгаварт хоосон вагон хүргэх, татаж авах журам, ачигдсан бүлэг вагоныг найруулах өртөө хүртэл хэсгээр явуулах зурмагийг орон нутгийн ажлын үечилсэн төлөвлөгөөнд тусгаж холбогдох өртөөдөд мэдэгдэнэ. Ийм маягаар хоосон вагоноос бүрдэх шатласан замналын ажлыг төлөвлөх хэрэгтэй.

8.3. Буулгалтыг төлөвлөх

Тээвэрлэлтийн үйл ажиллагаа нь ачаатай вагоныг хүлээн авагчийн замд тавьж өгснөөр эсвэл нийтийн бус хэрэглээний замуудад болон бусад улсын замд ачаатай вагоныг хүлээлгэн өгснөөр дуусах бөгөөд энэ нь төмөр замын тээврийн хамгийн эцсийн ажил үйлчилгээ болох буулгалт болно.

Дэд бүтэц эзэмшигчид нь өөрсдийн буулгалтыг төлөвлөхийн өмнө өртөөдөд бэлэн байгаа буулгах ачаатай вагон, төлөвлөхийн өмнөх хоногт орж ирсэн болон төлөвлөж байгаа хоногийн турш бусад улс, дэд бүтцээс ирсэн орон нутгийн ачаатай вагонуудын бодит байдлыг судлан дүгнэж, буулгалтын төлөвлөгөөний төслийг нийт вагоноор, вагоны төрлөөр, өмчийн хэлбэр харгалзахгүйгээр дараах өгөгдлийг үндэслэн боловсруулна.

- а. Өмнөх хоногийн буулгалтын төлөвлөгөөний биелэлтийн явц, буулгалтын өртөөнд бэлэн байгаа орон нутгийн ачаатай вагон;
- б. Дэд бүтцийн хэмжээнд буулгах өртөөдөд хүргэх орон нутгийн ачаатай вагон;
- в. Орон нутгийн ачаатай замналын галт тэрэг, вагоны тоо;

Буулгалтын төлөвлөгөө, таамаглалыг орон нутгийн ачаатай вагоныг буулгах өртөөдөд хүргэх хөдөлгөөний байдал, технологийн замналаар яваа орон нутгийн вагоны талаарх мэдээлэл, орон нутгийн ачаа зөөвөрлөж байгаа галт тэрэгний зурмагаар ирэх хугацааны төлөвлөлт ба өртөөдөд галт тэрэг, вагонд технологи ажиллагааг гүйцэтгэх хугацааны биелэлтийн талаарх лавлагааны мэдээллийг үндэслэн вагон тус бүрээр дугаарчлан гаргана.

Вагон хуваарилагч диспетчер нь 13 цагаас өмнө буулгалтын төлөвлөгөө таамаглалд орон нутгийн зөөвөрлөлтийг түр хугацаагаар хязгаарласан, өнгөрсөн хоногийн буулгалтын төлөвлөгөөнөөс үлдсэн нэмэх шаардлагатай вагон ба хүргэх хугацаа нь дуусч байгаа ачаатай вагон зэргийг тооцон өөрчлөлт оруулна.

Дугаарчилсан өөрчлөлтийг (шаардлагатай бол) орон нутгийн зарим вагонд, буулгалтын нэг өртөөнд очих хаягтай бүлэг вагонд эсвэл нэг галт тэрэгний бүх вагоноор гүйцэтгэнэ. Өөрчлөлт хийх үед буулгахаар төлөвлөж байгаа вагоны тоо бага бол вагон хуваарилагч диспетчер төлөвлөгөөнөөс хасах болсон вагоны (бүлэг вагон) шалтгааныг заавал дурдана. Ийм маягаар орон нутгийн ачааг техникийн өртөөнөөс буулгах өртөө хүртэл зөөвөрлөх төлөвлөгөөний төслийг зохиож өртөөдөд явуулна.

Өртөөний дарга нь:

- а. Вагон хуваарилагч диспетчерийн боловсруулж ирүүлсэн буулгалтын төлөвлөгөөний төсөл мөн түүнчлэн буулгалтын төлөвлөгөөнд хамрагдаагүй ч тухайн өртөөнд хаяглагдсан, оройтон ирж байгаа орон нутгийн вагоны тухай мэдээлэлийг авах;

б. Нийтийн бус хэрэглээний зам, талбай эзэмшигчийн ачааны фронтыг түр хугацаагаар хаасан, гэрээгээр хориглосон шалтгаанаар ачаа буулгахыг хориглосон мөн түүнчлэн буулгалтанд тавихыг хүлээж өртөөний зам дээр зогсох вагоны сул зогсолтыг багасгах зорилгоор ачааны фронтын болон сэлгээний зүтгүүрийг үр бүтээлтэй ашиглах журмын талаар тодотгох;

в. Вагон хуваарилагч диспетчерийн боловсруулсан төлөвлөгөөнд өөрчлөлт оруулахаар санал өгөх;

Буулгахаар төлөвлөсөн вагоны тоог багасгах (буухгүй болсон шалтгааныг заавал заах) эсвэл нэмэгдүүлэх (буулгалтын өртөөнд вагон ирүүлэхийг түргэтгэх саналтайгаар) саналын хувилбарууд байж болно. Вагон хуваарилагч диспетчер өртөөдөөс ирүүлсэн саналыг ээлжийн ахлах диспетчерт танилцуулах бөгөөд зөөвөрлөлтийг түргэтгэх, зарим өртөөдийн буулгалтыг эрчимжүүлэхээр зурмагт нэмэлт оруулан тээвэр зохион байгуулалтын нэгжийн даргад танилцуулан, 14:00 цагаас өмнө төмөр замын тээврийн байгууллагын удирдлагаар батлуулан гүйцэтгэгч нарт илгээнэ.

8.4. Ачилтын төлөвлөлт

8.4.1. Төмөр замын анхдагч ажил үйлчилгээ бол ачилт юм. Ачилтын төлөвлөгөөний биелэлтээс төмөр замын тээврийн байгууллагын үйл ажиллагаа, ашиг орлого хамаарна. Ачилтын ажлыг ачаа илгээгч бүрээс ирүүлсэн захиалгын дагуу дараах байдлаар төлөвлөнө.

- а. Ачаа илгээгчээр;
- б. Ачааны төрлөөр;
- в. Хөдлөх бүрэлдэхүүний тоо, төрлөөр;

8.4.2. Дараах тохиолдолд ачилтын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулж болно.

- а. Ачаа илгээгч нь төлөвлөж байгаа хоногт явуулах ачааг бэлтгээгүй;
- б. Хоосон вагоныг ачилтын өртөөнд хугацаанд нь хүргэж өгөөгүй;
- в. Ачаа илгээгч болон хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийн оператор нь ачилтанд тавьсан эсвэл тавих вагоноос ямар нэг хүндэтгэх шалтгаанаар татгалзсан;
- г. Ачилтыг хязгаарласан;
- д. Гэрээгээр хориглосон;
- е. Буулгалтын өртөөнд тухайн ачаа илгээгчийн ачаа ихээр хуримтлагдсан;
- ё. Ачаа илгээгч нь өр зээлээ барагдуулаагүй;

Диспетчерийн шуурхай нэгж нь өртөөдөөс ирүүлсэн ачилтын захиалгыг өртөө бүрээр, дэд бүтцийн хэмжээнд бүхэлд нь нэгтгэн ачилтанд өгөх вагоны хөдөлгөөнийг дараах байдлаар тогтоож төлөвлөнө.

а. Буулгалтаас суларсан, засвараас гарсан вагонуудыг ачилтанд бэлтгэх, мөн түүнчлэн зэхэлтийн замууд, нийтийн болон нийтийн бус хэрэглээний замуудад байгаа өөрийн эзэмшлийн хоосон вагоны тоо, төрлийг тогтоож цуглуулах арга хэмжээ авах;

б. Төлөвлөгөөт хоногт багтаан ачигдаж болох вагоны тооцоог гаргаж тэдгээрийг ачилтын өртөөнд хүргэх ажлыг зохион байгуулах;

Доорхи асуудлуудыг ачилтын өртөө тус бүрээр тогтооно. Үүнд:

а. Өмнөх өдрүүдийн буулгалтын төлөвлөгөөний биелэлт, ачилт хийгээгүй эсвэл дутуу ачсан шалтгаан;

б. Хоосноор ирсэн болон буулгалтаас суларсан вагоны тоо;

- в. Ачилтыг гэрээгээр хориглосон эсэх;
- з. Ачилт буулгалтын ажиллагаа гүйцэтгэх, ачилт буулгалтын фронтод вагон тавих, татах ажиллагаанд хязгаарлалт хийсэн эсэх;
- д. Өртөөний замд хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэгийн операторын ямар төрлийн хоосон вагон байгаа тухай мэдээ;
- е. Ачаа илгээгчийн өмнөх зээлийн төлөлт, одоогийн тээвэрлэлтэнд хийх санхүүгийн байдлын талаарх мэдээ;

Диспетчерийн шуурхай нэгж нь өртөөдөөс ирүүлсэн ачилтын захиалгыг холбогдох албадтай зөвшилцөн зохих өөрчлөлтийг оруулж, төлөвлөж байгаа хоногийн өмнөх өдрийн 15:00 цагаас өмнө төмөр замын тээврийн байгууллагын удирдлагаар батлуулна.

Төлөвлөгөөт хоног эхлэхээс 2 цагийн өмнө диспетчерийн тойргоор дамжуулан холбогдох аж ахуйн нэгжүүдэд болон Хөдөлгөөний нэгдсэн удирдлага, зохицуулалт хариуцсан байгууллагад хүргүүлнэ.

8.4.3. Тээвэр зохион байгуулалтын нэгжийн батласан хуанлийн төлөвлөгөөг үндэслэн ачигдах илгээгчийн болон шатласан замналыг хоногийн төлөвлөгөөнд тусгана. Замналаар ачих хуанлийн төлөвлөгөөг сараар боловсруулах бөгөөд ачаа илгээгчийн ирүүлсэн саналыг үндэслэн 10 хоногоор тодотгон өөрчлөлт оруулж болно.

Галт тэрэгний болон ачааны ажлын хоногийн төлөвлөгөөнд ачилтын өртөөг хоосон вагоноор хангах, ачигдсан замналыг татаж авах журам ба хугацаа, шатласан замналын бүлэг вагоныг ачигдсаны дараа нэгтгэх журмыг тусгасан байна.

8.4.5. Үечилсэн төлөвлөлтийн явцад вагон паркийг зохицуулагч диспетчер вагоны техник үйлчилгээний газар (ТҮГ) -тай техникийн болон хэсгийн (ачааны) өртөөдийн сэлгээний диспетчер эсвэл өртөөний жижүүрт ачилтанд өгөх хоосон вагоныг бэлтгэх ба ачаатай вагонд хоёрлосон ажиллагаа гүйцэтгүүлэхээр тэдгээрт техник коммерийн үзлэг засвар хийх даалгавар өгнө. Эдгээр өртөөдөд ачилтанд өгөх хоосон вагонуудыг эцэслэн сонгож үзлэгийн дэвтэрт тэмдэглэнэ.

Ачилтанд тэнцсэн хоосон вагонуудыг ачилтын өртөөнд хүргэх галт тэргийг зориулалт, чиглэлээр сонгон үечилсэн төлөвлөгөөнд тусгана.

Ачилтын болон техникийн өртөөдийн ачааны ажиллагааны үечилсэн төлөвлөгөөнд дараах ажиллагаанууд хамаарна.

- а. Орон нутгийн ажлын төлөвлөгөө зохиох. Урьдчилсан өгөгдөл болох өртөөн доторх дамжуулах вагонуудыг найруулах, ачилт, буулгалтын фронтод вагон тавих, татах дараалал, хугацаа, илгээгчийн замнал найруулах журмаар тодорхойлогдох өртөөний орон нутгийн ажлыг төлөвлөх;
- б. Өртөөдөд бэхлэгдсэн сэлгээний зүтгүүрийн ажлын төлөвлөгөө зохиох;

8.4.6. Ачаа илгээгчийн тээврийн үйлчилгээний технологи ба салбар замын дэд бүтцийн хөгжлийг тооцон “Вагон эргэлтийн технологийн хугацаа мөн түүнчлэн вагонд ачаа ачих, буулгах технологийн нормыг боловсруулах, тодорхойлох журам”-д тохируулан нийтийн бус хэрэглээний замд вагон эргэх технологийн хугацааг тодорхойлно.

Вагон эргэлтийн технологийн хугацааг ачааны нэг ажиллагаатай, ачааны хоёрлосон ажиллагаатай, замналын гэсэн зарчмаар ялгаварлах бөгөөд түүнд дараах ажиллагаа хамаарна.

- а. Задлах ба бүлэглэх;

- б. Тавилт ба ачааны фронтуудад вагоныг байрлуулах;
- в. Ачилт, буулгалтын ажиллагаа;
- г. Ачааны хоёрлосон ажиллагаанд шилжүүлэн тавих;
- д. Татаж авах;
- е. Бусад ажиллагаа (тавилт, таталт хүлээх, пүүлэх, хуримтлуулах, ажилбар хоорондын бусад сул зогсолт) ;
- ё. Найруулах;
- ж. Хүлээн авах, хүлээлгэн өгөх ажиллагаа;

Ажилбар хоорондын сул зогсолтыг тооцсон үйл ажиллагааны үргэлжлэх хугацаа нь нийлэх өртөө ба нийтийн бус хэрэглээний зам, талбайн хоногийн ажлын төлөвлөгөө зурмагаар тодорхойлогдоно.

8.4.7. Нийтийн бус хэрэглээний зам, талбайд вагон эргэх технологийн хугацаанаас гадна дараах нормуудыг тооцно.

- а. Вагонд ачаа ачих ба буулгах технологийн норм;
- б. Нийтийн бус хэрэглээний зам, талбайн боловсруулах чадвар;
- в. Хүлээн авах, хүлээлгэн өгөх бүрэлдэхүүний жин, уртын норм;
- г. Нийтийн бус хэрэглээний зам, талбайн технологийн ажиллагаа гүйцэтгэх хугацааны норм;
- д. Вагон хүлээлцэх замаас вагоныг өртөөнд татаж авах хугацаа;
- е. Нэгэн зэрэг тавих, татах вагоны тоо;

Төмөр замын сүлжээгээр явах зөвшөөрөлтэй дагнасан хэрэглээний замд байгаа бүх вагоныг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр тэдгээрийн технологийн нормативыг тооцох бөгөөд тэр нь ачаатай, хоосон вагоны хүргэх хугацааг тохируулах, ачаа тээвэрлэх захиалгыг хугацаанд нь биелүүлээгүй, дэд бүтцэд зогсоох хугацааг хэтрүүлсэн талуудын хариуцлагыг тодорхойлох үндэс болно.

8.4.8. Дэд бүтэц ашиглуулах гэрээнд доорхи асуудлыг тусгасан байвал зохино.

- а. Дэд бүтэц эзэмшигчийн мэдлийн зүтгүүрийг үр ашиггүй гүйлт гаргахгүйгээр төмөр замын сүлжээнд байрлуулан ашиглахыг харилцан тохиролцож зохион байгуулах
- б. Дэд бүтцүүдийн хэсгүүдээр аялах галт тэрэгний жин, уртын нормыг аль болох ижил, жингийн хугарал хийхгүй байхаар тогтоож, вагон урсгалыг зохион байгуулах ашигтай хувилбарыг сонгох

Ялгалтын ажлыг оновчтой зохион байгуулахын тулд:

- а. Бусад улсын төмөр замаас орж ирсэн дэд бүтэц эзэмшигчдийн өртөөдийн хаягтай замналжуулаагүй вагон урсгалыг галт тэрэг найруулах төлөвлөгөөний дагуу хүрэх өртөөдөөр нь найруулж явуулах
- б. Дэд бүтэц эзэмшигчдийн өртөөдөөс бусад улс болон дэд бүтцэд очих вагон урсгалыг илгээгчийн замналаар эсвэл галт тэрэг найруулах төлөвлөгөөнд нийцүүлэн очих улс, дэд бүтцээр нь нэгтгэн найруулж явуулах
- в. Бусад улсын төмөр замаас орж ирсэн хоосон вагон урсгалыг очих өртөөд, дэд бүтцээр нэгтгэн явуулах

8.5. Ачаа хүргэх хугацааны биелэлтэд хийх шуурхай удирдлага, хяналт, шинжилгээ

8.5.1. Ачаатай ба хоосон вагон хүргэх хугацааны биелэлтэнд хийх шуурхай шинжилгээ, хяналтыг судалгаа шинжилгээний автоматжуулсан систем, тээвэрлэлт, удирдлагын бүх түвшинд гарсан вагоны хөдөлгөөн болон ачаа хүргэх хугацаатай холбоотой зөрчлийн шалтгааныг тодорхойлсон тайланг үндэслэн гүйцэтгэх бөгөөд үүнд:

а. Ачаа илгээлт ба вагоны хөдөлгөөний нормт хугацаанд судалгаа шинжилгээ хийх; (мониторинг)

б. Хүргэх хугацааг хэтрүүлсэн вагоныг илрүүлэх. Саатсан шалтгаан, хариуцлагын заагийг тодруулж үйлчилж байгаа журмын дагуу аяллын явцад саатсан вагоны баримт бичгийн бүрдэлт, саатлыг багасгахаар авсан арга хэмжээнд хяналт тавих;

в. Ачаа, вагон хүргэх хугацааг баримтлах талаар диспетчерийн авсан шуурхай арга хэмжээ;

г. Гарсан зөрчил ба түүний шалтгаанд шинжилгээ хийж цаашид гаргахгүй байх талаар төлөвлөгөө боловсруулах;

8.5.2. Шуурхай удирдлага, хяналт, шинжилгээнд:

а. Ачаатай вагон - Тээвэрлэлтийн баримт бичиг бүрдүүлсэн мөчөөс хүрэх өртөөнд ачаа хүлээн авагчид хүлээлгэн өгөх хүртэлх мөч;

б. Хоосон вагон - Төмөр замаар ачаа тээвэрлэх дүрмийг үндэслэн эсвэл ачааг тээвэрлэхээр ирүүлэх хугацааг талууд хэлэлцэн тохирч төмөр замын падаанд заасан хугацаанд хяналт тавихад илэрсэн нэг эсвэл хэд хэдэн зөрчил;

в. Ачаа хүргэх тогтоосон хугацааг хэтрүүлсэн вагон;

г. Ачилтын өртөөнөөс явуулах тогтоосон хугацаанаас хэтэрч явсан вагонууд;

д. Хөдөлгөөнд түр хугацаагаар саатуулагдсан галт тэргэнд яваа вагонууд;

8.5.3. Тайлангийн өгөгдлийг бүрдүүлэх хариуцлагатан:

а. Өртөөдөд - Өртөөний дарга

б. Дэд бүтцийн хэмжээнд - Тээвэр зохион байгуулалтын нэгжийн орлогч дарга, диспетчерийн шуурхай нэгжийн дарга

в. Төмөр замын сүлжээний хэмжээнд – Хөдөлгөөний нэгдсэн удирдлага, зохицуулалт хариуцсан байгууллагын дарга

Вагоныг саатуулсан зөрчлийн шалтгааныг журмын дагуу зөрчил тус бүрээр өртөөд ангилан хуваарилж, өртөөний ажилтны бүрдүүлсэн ерөнхий маягтын акт болон тээвэрлэлтийн баримт бичгэнд энэ тухай тэмдэглэл хийсэн эсэхийг шалгаж магадлана.

Вагоныг саатуулсан зөрчлийн шалтгааныг тогтоосон тайланг төмөр замын тээврийн байгууллагын удирдлагад хүргүүлнэ. Тайланд дараах бүлгүүдийг оруулна.

а. Зөрчилд хийсэн динамик шинжилгээ. Үүнд: вагоны саатал болон ачаатай, хоосон вагоны хүргэх хугацаа хэтрүүлсэн зөрчлийн нийт тоог дэд бүтэц эзэмшигч болон хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэгийн оператороор;

б. Гарсан зөрчлийн динамик шинжилгээг хоногийн дунджаар, 10 хоногоор, сараар тус тус гаргана.

в. Вагоны саатал болон ачаатай хоосон вагон хүргэх хугацаа хэтрүүлсэн шалтгааныг дэд бүтэц эзэмшигч болон хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэгийн оператор бүрээр нарийвчлан тогтооно.

8.5.4. Төмөр замын тээврийн байгууллагын тээвэр зохион байгуулалтын нэгж өртөөдөөс ирүүлсэн тайланг нэгтгэн шинжилгээ хийнэ. Үүнд:

а. Вагоны хөдөлгөөнийг саатуулсан болон ачаа хүргэх хугацааг хэтрүүлсэн шалтгааны үндсэн зөрчлийн нийт тоо, тэдгээрийн ангиллыг (үйлчлүүлэгч байгууллагын буруутай ажиллагаа, гаалийн баримт бичиг бүрдүүлэлт, техник коммерийн зөрчил арилгах, ачилтын эсвэл буулгалтын өртөө вагоныг хүлээн аваагүй төмөр замын тээврийн байгууллагын буруугаас гэх мэт) тогтоох;

б. Төмөр замын тээврийн байгууллагад хамаарах буруутай үйл ажиллагааг нарийвчлан тогтоох;

в. Өртөөний ажилтнуудын буруугаас ачаа, вагон хүргэх хугацааг хэтрүүлсэн болон бусад шалтгааныг нарийвчлан тогтооно.

Хугацаа хэтрүүлсэн ижил зөрчилтэй бүлэг вагоныг нийтэд нь эсвэл вагон тус бүрээр нарийвчлан шинжлэнэ. Тодорхой шалтгаантай вагоны зөрчлийн үндэслэлийг дараах байдлаар тодруулна.

а. Вагонтой ажилласан үйл ажиллагааны (ачилтанд, ачилтын өртөөнд, вагон боловсруулах ажиллагаанд, хүрэх өртөөнд, ирэлтэнд) биелэлтийн хугацаанд шинжилгээ хийх замаар;

б. Хүрэх өртөөнд вагон хүлээн авах ба ачаа буулгахад тавигдсан хязгаарлалтаар (буулгах ачаатай болон ачигдах хоосон вагоны тоо хэмжээнээс хэтэрсэн, ачилтын фронтын ажлын дэглэм зөрчигдсөн, ачаа хөлдсөн, буулгах машин механизмын гэмтэл саатал гэх мэт);

в. Өртөөний холбогдох ажилтны илтгэлээр.

8.5.5. Төмөр замын тээврийн байгууллагын буруутай үйл ажиллагаанаас ачаа, вагон хүргэх хугацааг хэтрүүлсэн шалтгааныг судлаж дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

а. Вагон урсгал нэмэгдсэн тохиолдолд техникийн замналын галт тэрэг багассан үед бүлэглэсэн галт тэрэг найруулахаар галт тэрэг найруулах төлөвлөгөө болон галт тэрэгний хөдөлгөөний зурмагт өөрчлөлт оруулах;

б. Вагон хүлээн авах, түүнд ажиллагаа хийхэд хүндрэл гарснаар буулгалтын төлөвлөгөө биелээгүй өртөөний хаягаар ачилт хийхийг хязгаарлах;

в. Вагон урсгалд хурдавчилсан аргаар ажиллагаа хийх ба хүргэлтийг түргэтгэх;

д. Галт тэрэгний хөдөлгөөний зурмагт тусгагдсан тусгай хуваарийн галт тэргийг урьтаж өнгөрүүлэх;

е. Хүрэх хугацаа нь дуусах дөхсөн ачаатай ба хоосон вагонтой галт тэргийг урьтаж явуулах;

ё. Их хэмжээгээр ачилт, буулгалт хийдэг өртөөнд вагон хүргэх ажлыг зохион байгуулах.

8.5.6. Төмөр замын тээврийн байгууллага нь ачаа хүргэх хугацааны биелэлтэд хийсэн шинжилгээний тайланг Хөдөлгөөний нэгдсэн удирдлага, зохицуулалт хариуцсан байгууллагад ирүүлнэ.

ЕС. ТӨМӨР ЗАМЫН ДЭД БҮТЦЭЭР ТЭЭВЭРЛЭЛТИЙГ ХАНГАХ

9.1. Ерөнхий байдал

Дэд бүтцийн объектуудыг арчлах, үйлчлэх төмөр замын хэсэг, өртөөдөд засварын болон барилга угсралтын ажил гүйцэтгэх, техник үзлэгийн газарт вагонд техникийн үйлчилгээ хийх, вагон үзлэгийн ээлжийн ажлыг удирдах, гэмтэлтэй вагонуудад урсгал засвар хийлгэхээр өртөөдөд хүргэх, засварын замд тавих, вагоны бүрэн бүтэн байдлыг хангах нэгдсэн технологийн горимийг

хэрэгжүүлэхэд тээвэрлэгч болон дэд бүтэц эзэмшигч, тэдгээрийн нэгж, шугам зам дахь аж ахуйн нэгжүүдийн хамтын нягт ажиллагаа шаардагдана.

Тээвэрлэлтийн болон дэд бүтцийн элементүүдийн иж бүрдэл хоорондын технологийн нэгдэл нь галт тэрэгний хөдөлгөөний батлагдсан зурмагийг биелүүлэх, дэд бүтцэд засвар, өөрчлөлт хийхээр “Цонх” гаргасан үед нэвтрүүлэх чадварыг ашигтайгаар удирдахад чиглэгдэнэ.

9.2. Дэд бүтцийн урсгал засвар, арчлалтын ажлыг төлөвлөх үеийн нэгжүүдийн хамтын ажиллагаа

9.2.1. Ашиглаж байгаа төхөөрөмж, байгууламжийг өөрчлөн шинэчлэх, шинээр барих шаардлага, зам, сум, дохиолол, төвлөрүүлэл, хориглолын байгууламж ба холбоо, цахилгаан хангамжинд хийгдэх засварын тогтоосон нормативыг үндэслэн дэд бүтцийн объектуудийн барилга угсралт, засварын ажлын төлөвлөгөөг дэд бүтэц эзэмшигчид боловсруулна.

Дэд бүтэц эзэмшигч, тээвэр зохион байгуулалт, холбоо, татах нэгжийн болон барилга угсралт, засварын байгууллагын төлөөлөгчдийг оролцуулан төмөр замын тээврийн байгууллагын даргын тушаалаар батласан ажлын хэсэг дараа онд төлөвлөсөн галт тэрэг урсгалыг өнгөрүүлэх нөхцлийг хангасан төлөвлөгөө ба техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний төслийг жил бүр боловсруулна.

Ажлын хэсгийн боловсруулсан төлөвлөгөөний төслийн санхүүжилтийн хэмжээ, дэд бүтцийн болон засварын иж бүрдлийн бэлэн байдал, татах хэрэгслийн нөөц, дэд бүтцийн шинэчлэлт, урсгал засвар арчлалттай холбоотой ажлын хэмжээг зохих нэгжүүдтэй зөвшилцөн зарим өөрчлөлт оруулан батлуулахаар техник эдийн засгийн зөвлөлийн хуралд оруулна.

9.2.2. Дэд бүтцийн урсгал засвар, арчлалтын төлөвлөгөөнд дараах өгөгдлүүд хамаарна.

- а. Гүйцэтгэгч байгууллага;
- б. Зам засварын бүх төрлийн ажил гүйцэтгэх газар, засварын ажлын хэмжээ;
- в. Засварын төрлөөс хамааруулан 7 хоногт болон жилийн турш гаргах “Цонх” – ны тоо, үргэлжлэх хугацаа;
- г. Хэсэгт хийгдэх зам засварын ажлын эхлэх, дуусах хугацаа;
- д. Зам засварын ажил гүйцэтгэх технологи, аж ахуйн галт тэрэг ажиллуулах журам;
- е. Ажил гүйцэтгэгчдэд шаардагдах бараа, материал хэрэгслэлийн нөөц, нэвтрүүлэх чадварыг түр хугацаагаар түргэтгэх арга хэмжээ;
- ё. “Цонх” гаргасан өдрүүдэд уулзварын өртөөдөөр солилцох галт тэрэгний хэмжээ;
- ж. Ажилд шаардагдах зүтгүүр болон аж ахуйн галт тэрэгний тоо, тэдгээрийн ажлын дэглэм, үргэлжлэх хугацаа;
- з. “Цонх”- ны ажил гүйцэтгэсний дараах галт тэрэгний хөдөлгөөний хурд;
- и. Засвар хийсэн хэсэгт тогтоосон хурдны үргэлжлэх тооцооны хугацаа;

Төрөл бүрийн засварын ажил эхлэхийн өмнө ажил гүйцэтгэж байгаа болон дууссаны дараах үеийн галт тэрэгний хөдөлгөөний хурдны хязгаарлалт, “Цонх” гаргасан өдрүүдэд уулзварын өртөөдөөр солилцох галт тэрэгний хэмжээг төлөвлөгөөнд тусгасан байна.

Дэд бүтцэд засвар, шинэчлэлт хийх жилийн төлөвлөгөөг авсны дараа “Цонх” гаргах хуанлийн төлөвлөгөө зохионо. “Цонх” гаргахыг хоногийн ажлын төлөвлөгөө зурмагт тусгаснаар дэд бүтцэд шинэчлэлт, өөрчлөлт, засвар, арчилгаа хийх төлөвлөгөөний эхний ажил дуусна.

9.2.3. Төмөр замын зам засварын ажилд “Цонх” гаргах ажлыг төлөвлөх баримт бичиг бол “Төмөр замд барилга угсралтын ба зам засварын ажилд цонх гаргах, түүнийг ашиглах журмын тухай” зааврыг үндэслэн гаргасан “Орон нутгийн онцлогийг харгалзан “Цонх” гаргах захиалга авах, зөвшөөрөл өгөх журам” болон “Замын ажлыг гүйцэтгэх үед галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах журам”-ыг үндэслэнэ.

9.2.4. Тээвэрлэлтийн төлөвлөгөөг биелүүлэх, ашиглалтын ажлын бүтээмжийг сайжруулах зорилгоор дэд бүтцэд хийх засвар, үйлчилгээ, арчилгааны ажилд тээвэр зохион байгуулалтын нэгж, дэд бүтэц эзэмшигч нар дараах нөхцлийг баримтлавал зохино.

а. “Цонх”-ны ажлын бүтээмжийн дээд зэрэгт байлгах;

б. “Цонх”-ны нэг ажил гүйцэтгэх үед хугацаа ба чиглэл нь тохирсон зам засвар, автоматик, телемеханик, дохиолол холбооны болон эрчим хүч, усан хангамж, цахилгаанжуулалтын ажлыг нэгэн зэрэг гүйцэтгэх;

в. Ажлыг зэрэгцүүлэн гүйцэтгэх үед бүх машин, механизмыг дээд зэргээр төвлөрүүлэн иж бүрнээр ашиглах;

г. Нэг хоорондын замтай хэсэгт нэвтгүүлэх чадварыг түр хугацаагаар түргэтгэх зорилгоор ачааны галт тэргийг багцаар, галт тэрэгний хөдөлгөөнийг хугацаагаар тохируулах техник, зохион байгуулалтын арга хэрэглэх;

д. Засварын болон бэлтгэл ажлыг “талбайгаас” гүйцэтгэх;

е. “Цонх”-ны ажлын үед нэгтгэсэн галт тэрэг өнгөрүүлэх;

ё. Дэд бүтцийн объектуудыг үнэлэх, оношлох иж бүрэн автоматжуулсан систем хэрэглэх;

ж. Замын пост, диспетчерийн суман шилжүүлгийг түр хугацаагаар байгуулах;

9.2.5. “Цонх”-ны ажлын технологийн мөрдөлтөд галт тэрэгний хөдөлгөөний диспетчер шуурхай удирдлагаар хэрхэн хангаж байгаа байдалд тээвэр зохион байгуулалтын нэгж шинжилгээ хийн хяналт тавина. Хоногийн ажил дуусах үед “Цонх” гаргасан ажлын төлөвлөгөөний болон галт тэрэгний зурмагийн биелэлтэд шинжилгээ хийнэ.

“Цонх”-ны ажлын явцад шугам замын удирдлагын (өртөө, зам, холбоо дохиолол, эрчим хүчний анги) хүрээнд дараах хяналтыг тавина.

а. Гүйцэтгэх ажил нь “цонх” гаргахаар батлагдсан төлөвлөгөөт зурмагтай тохирч байгаа эсэх;

б. Галт тэрэгний хөдөлгөөний зурмагийн хувилбарын биелэлт;

в. “Цонх”-ны ажлын төлөвлөгөөний биелэлт;

г. Галт тэрэгний хөдөлгөөний хурд хязгаарласан анхаарамжийн хүчинтэй байх хугацаа түүний өөрчлөлт;

д. Засварын ажил гүйцэтгэх үеийн технологийн горимийн биелэлт;

9.3 Дэд бүтцээр үйлчлэх үеийн нэгжүүдийн хамтын ажиллагаа

9.3.1. Дэд бүтэц эзэмшигч, тээвэрлэгчийн хамтын ажиллагаа, дэд бүтцийн объектуудын үзүүлэлтүүд болон техник, технологийн норматив нь галт тэрэгний хөдөлгөөний зурмаг, өртөөдийн ажлын технологитой тохирч байвал зохино.

Тээвэр зохион байгуулалтын нэгж нь дэд бүтэц эзэмшигчтэй хамтран технологийн “Цонх” олголтын бодит байдал, гүйцэтгэж байгаа ажил, хоорондын замын хөдөлгөөнийг нээж байгаа байдалд хяналт тавина. Олгосон технологийн “Цонх”-ны үргэлжлэх хугацаа, дүрэм, журам

зөрчигдсэн тохиолдол бүрийг судалж технологийн “Цонх”-ыг үр бүтээлтэй ашиглах техник технологийн ба зохион байгуулалтын арга хэмжээг боловсруулна.

Дэд бүтэц ба хөдлөх бүрэлдэхүүнд гарсан техникийн эсвэл технологийн саатлын улмаас “Цонх”-ыг өөрчлөх шаардлага гарсан тохиолдолд “Галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын журам”, “Төмөр замын дэд бүтцийн хөдөлгөөнийг нээх, хаах, ашиглах, дэд бүтцийн үйлчилгээ үзүүлэх, дэд бүтцийг шинэчлэн сайжруулах, засварлах журам”-ын дагуу нэн даруй арга хэмжээ авна.

9.3.2. Тээвэрлэгч болон дэд бүтэц эзэмшигчдийн төлөөлөлүүд өртөөний төхөөрөмж байгууламж, зам, суман шилжүүлэг, барилга байгууламжид үзлэг хийнэ. Үзлэгээр илрүүлсэн техник хэрэгслэл, төхөөрөмжийн гэмтлийг хугацаанд нь хэрхэн арилгаж байгаад өртөөний жижүүр эсвэл өртөөний дарга өдөр бүр хяналт тавина. Өртөөний болон зам, сум, дохиолол холбоо, эрчим хүчний ажилтнаас хамааралгүй гарсан техник хэрэгслийн гэмтлийг тогтоосон хугацаанд арилгаж чадаагүй тохиолдолд “Зам сум, холбоо, дохиолол, төхөөрөмжийн үзлэгийн дэвтэр” -т тусгай тэмдэглэл хийж ажлын хэсгийн дарга нь холбогдох нэгжийн болон төмөр замын тээврийн байгууллагын орлогч дарга нар т цахилгаанаар мэдэгдэнэ.

Цахилгаан мэдээлэл авсны дараа техник хэрэгслэлийн хэвийн ажиллагааг сэргээх арга хэмжээний тухай (засварын ажлыг дуусгах, хугацаа хариуцагчийг заасан) болон гэмтэлтэй суман шилжүүлэг ба өртөөний замыг галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнд хаах шаардлага гарсан тохиолдолд хаах тухай тушаал гаргана.

9.3.3. Өвөлд бэлтгэх ажлын хүрээнд тээвэрлэгч нь дэд бүтэц эзэмшигч болон бусад нэгжүүдтэй хамтран аж ахуйн нэгж болон ажилтнуудыг өвөлд бэлтгэх, зам, суман шилжүүлгийн цасыг цэвэрлэх асуудлаар хамтран ажиллана. Өвөлжилт хүндэрсэн нөхцөлд галт тэрэг урсгалыг саадгүй өнгөрүүлэх, галт тэрэг хүлээн авах, явуулах, зам, суман шилжүүлгүүдийг болон өртөөний орчмын цасыг цаг хугацаанд нь цэвэрлэх шуурхай ажлын штаб байгуулж, аж ахуйн нэгжүүдэд байгаа машин механизм, хүн хүчийг татан оролцуулна.

Цастай тэмцэх ажилд оролцож байгаа хүмүүст аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх, багаж хэрэгслээр хангах, машин механизмыг шаардагдах газарт хуваарилах, дохиочин томилох ажлыг замын аж ахуйн ашиглалтын ажилтан удирдана.

9.4 Вагоны техникийн байдалд хяналт тавих асуудлаар хамтран ажиллах

9.4.1. Вагоны техникийн байдалд хяналт тавих ажиллагаа хөдөлгөөнд оролцохоос эхэлнэ. Хоорондын замд вагоны гүүшин халалтыг илрүүлэх төхөөрөмж болон вагоны техникийн байдалд хяналт тавих бусад хэрэгслэл байрлуулсан тохиолдолд ТҮГ-ын вагон үзэгчид галт тэрэг ирэх хугацаа, хүлээн авах замын дугаар, бүрэлдэхүүн дэх халсан гүүшинтэй вагоны байрлал болон бусад гэмтлийн талаар ТҮГ-ын оператороос мэдээлэл авна.

Гэмтэлтэй вагонтой галт тэргийг өртөөнд хүлээн авах журмыг өртөөний техник захирамжийн акт, орон нутгийн зааварт тусгасан байна. Гэмтэлтэй вагонд техникийн байдлаараа нийтийн болон нийтийн бус хэрэглээний замд ашиглах боломжгүй, засварт оруулах эсвэл бүртгэлээс хасах вагонууд хамаарна.

Вагоны гэмтлийг вагоны аж ахуйн ажилтан эсвэл вагонд техникийн үйлчилгээ хийх эрх бүхий ажилтан тогтооно. Галт тэргийг техникийн үзлэгт оруулах ба түүний бэлэн байдлын тухай мэдээлэх мөн түүнчлэн техник үзлэгийн газаргүй өртөөнд вагоныг галт тэргэнд холбохын өмнө үзлэг засвар хийх журмыг дэд бүтэц эзэмшигч тогтооно.

Вагон үзлэгийн бригад нь вагонд хийх техникийн үйлчилгээ, засварын ажлыг ТҮГ-ын болон өртөөний ажлын технологийн процесс, галт тэрэгний хөдөлгөөний зурмагийн дагуу гүйцэтгэнэ.

9.4.2. Хэрэв галт тэрэгний бүрэлдэхүүнээс салгаж засах шаардлагатай вагон илрүүлсэн тохиолдолд вагон үзэгч уул вагонд шохойн тэмдэглэгээ хийж, ТҮГ-ын операторт засварын хэмжээний тухай радио холбоогоор эсвэл телефон утсаар мэдэгдэнэ. “Мэдэгдэх хуудас” -ыг 2 хувь үйлдэж өртөөний жижүүр, ТҮГ-ын операторт дамжуулна.

Вагонд техникийн үзлэг хийсний дараа вагон үзэгч нь галт тэрэг техникийн хувьд бэлэн болсон тухай оператор, ахлах үзэгчид мэдэгдэнэ. Ахлах үзэгч нь “Үзлэгийн дэвтэр” -т бичлэг хийн гарын үсэг зурна.

ТҮГ-т оператор байхгүй тохиолдолд өртөөний жижүүрт дамжуулна. Галт тэргийг явуулах үед вагон үзэгч нь аюулгүй зайд байрлан хөдөлж байгаа галт тэрэгний вагонуудын явах ангийн техникийн байдал, тоормосны болон авто угсрааны төхөөрөмжид хяналт тавина.

Галт тэргийг үдсэн вагон үзэгч сүүлийн вагонд дохио байгаа тухай холбооны хэрэгслэлээр операторт, харин гэмтэл илрүүлсэн тохиолдолд радио холбоо болон гар дохиогоор галт тэргийг зогсоох дохиог машинчид өгнө.

Вагоныг ачилтанд тэнцэх эсвэл төлөвлөгөөт засвар хийх шаардлагыг үзэгч вагоны тэвшин дэх тэмдэглэгээг үндэслэн шийдвэрлэнэ. Вагоныг ачилтанд өгөхийн өмнө өртөөний ажилтан вагонд ачих ачааны нэр, дугаарыг зааж техникийн үйлчилгээ хийлгэхээр үзлэгийн дэвтэрт бичиж ахлах үзэгчээр гарын үсэг зуруулна.

9.4.3. Вагон үзлэгийн ээлжийг удирдах технологид дараах асуудлууд хамаарна.

- а. Галт тэргийг баталгаатай аюулгүй өнгөрүүлэх хэсгийн урт ба бүдүүвч;
- б. Галт тэргийг баталгаатай аюулгүй өнгөрүүлэх хэсэгт ажиллах вагон үзлэгийн бригадыг төвлөрсөн удирдлагаар хангах;
- в. Үйл ажиллагааны хяналт, төлөвлөлт, санхүүжилтийг аргачлалаар хангах ба нэгдсэн технологийг мөрдөх;
- г. ТҮГ болон вагон ашиглалтын депо, өртөөний ажлын технологийн процесс, ашиглалтын ажлын төлөвлөгөө, галт тэрэг найруулах төлөвлөгөө, галт тэрэгний хөдөлгөөний батлагдсан зурмагт агуулагдсан технологийн норм, нормативыг хатуу мөрдөх;
- д. Ашиглалтын ажилтай холбоотой ажилтны хөдөлмөрийн болон хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах;
- е. Вагонд техникийн үйлчилгээ хийдэг ажилтнуудын байршил, хөдөлмөр зохион байгуулалт, үйл ажиллагааны уялдаа;

Технологийн горим нь бүхэлдээ дараах асуудлуудыг хамруулсан вагон үзлэгийн ээлжийн ажлын зохион байгуулалтын систем болно.

- а. Өртөөний замд вагонд техникийн үйлчилгээ хийх журам, үргэлжлэх хугацаа;
- б. Вагонд хийх техникийн үйлчилгээ, ажилбар бүрийг гүйцэтгэх хугацааны нормчлол, ажилтны байршил, хөдөлмөрийн зохион байгуулалт, үйл ажиллагааны уялдаа;

9.4.4. Вагон үзлэгийн бригадын жилийн хэрэгцээг дараах үе шаттайгаар тогтооно.

- а. Тээвэр зохион байгуулалтын нэгж нь ТҮГ бүхий өртөөдөөр жилийн турш хоногийн дунджаар өнгөрүүлэх галт тэрэгний тоог тооцоолж вагоны аж ахуйн нэгжид хүргүүлнэ;

б. Вагоны аж ахуйн нэгж ирүүлсэн тооцоог үндэслэн дараа жилд шаардагдах вагон үзлэгийн бригадын төлөвлөгөөний төслийн тоог вагон ашиглалтын деподоор гаргуулах;

в. Вагон ашиглалтын депод вагон үзэгч нарын ээлжийн амралт, өвчлөл зэргийг нөхөх коэффициентийг үндэслэн вагон үзлэгийн нэг ээлжинд ажиллах хүний дундаж тоог тогтоосон төлөвлөгөөний төслийг вагоны аж ахуйн албанд явуулна;

г. Вагоны аж ахуйн нэгж деподоос ирүүлсэн төлөвлөгөөний төслийг судлан зарим өөрчлөлт оруулан батлуулж вагон ашиглалтын депод хүргүүлнэ;

д. Депо батлагдсан төлөвлөгөөний дагуу вагон үзлэгийн ээлжийн ажилтануудыг бүрдүүлнэ;

9.4.5. Ашиглалтын ажлын сарын техникийн нормчлолыг боловсруулах үед вагон үзлэгийн бригадын ажлын нормчлолыг дараах байдлаар тогтооно.

а. Өртөөдөд болон вагоныг тээвэрлэлтэнд бэлтгэх газруудад техникийн үйлчилгээ хийх вагон үзлэгийн бригадын хоногийн дундаж тоог тодорхойлох;

б. Өртөөдөд болон вагоныг тээвэрлэлтэнд бэлтгэх газруудад техникийн үйлчилгээ хийх, вагон үзлэгийн бригаданд ажиллах хүмүүсийн тооцоо;

в. Вагон үзлэгийн бригадын орон тоог төлөвлөж байгаа сарын хоногийн дундаж галт тэрэгний тоо, нэг вагонд техник үйлчилгээ хийхэд зарцуулах хугацаа болон ээлжийн амралт, өвчлөл зэргээс эзгүй байгаа орон тоог орлон ажиллах коэффициентийг тооцон тогтооно.

Ачааны хөдөлгөөнд ажиллах вагон үзлэгийн бригадын ажлын сарын нормчлол дараах үе шаттай байна.

а. Дэд бүтэц эзэмшигч төлөвлөж байгаа сарын хоногийн дундаж орон тоог вагон ашиглалтын деподоор тооцоолж тээвэр зохион байгуулалтын нэгжтэй зөвшилцөн деподод хүргүүлнэ.

б. Вагон ашиглалтын депо, өртөөдтэй хамтран төлөвлөж байгаа сард вагон үзлэгийн бригадын ажлыг зохион байгуулахад шаардагдах хугацааны нормыг тооцоолж тогтооно.

в. Вагонд техникийн үйлчилгээ хийхэд зарцуулагдах хугацааны нормыг дэд бүтэц эзэмшигч тээвэр зохион байгуулалтын нэгжтэй зөвшилцөн батлаад вагон ашиглалтын деподод гүйцэтгүүлэхээр явуулна.

г. Вагон ашиглалтын депо шаардлагатай үед вагон үзлэгийн бригадын нарийн зурмагыг боловсруулж батлан ТҮГ-ын болон вагоныг тээвэрлэлтэнд бэлтгэх газрын дарга нарт дамжуулна.

9.4.6. Вагон үзлэгийн бригадын ажлын шуурхай удирдлага нь тээвэрлэлтийн төлөвлөгөөг биелүүлэх, өртөөдөд галт тэргэнд хийгдэх техникийн үйлчилгээг ашиглалтын хамгийн бага зардлаар гүйцэтгэх мөн түүнчлэн вагон үзлэгийн ээлжийн ажил амралтын дэглэмийг хууль тогтоомжийн дагуу мөрдүүлэхэд чиглэгдэнэ.

Вагон үзлэгийн бригадын шуурхай удирдлагын төлөвлөгөөний хувилбар нь төлөвлөгдөж байгаа сарын ашиглалтын ажлын зохион байгуулалтын онцлог, хөдөлгөөний зурмагийн үзүүлэлт, ашиглалтын ажлын сарын техникийн норм зэрэгт үндэслэгдсэн, технологийн ба нөөцийн хязгаарлалтыг хангасан байвал зохино.

Вагон үзлэгийн бригадын шуурхай удирдлагын үндсэн зорилт нь:

а. Ачааны (зөөврийн ба дамжуулах хөдөлгөөнийг оролцуулан) ба зорчигчийн галт тэрэгний хөдөлгөөний хэмжээг хангахад шаардагдах вагон үзлэгийн бригадыг тодорхойлох;

б. Явуулахад бэлэн болсон галт тэрэг бүрийг вагон үзлэгийн бригадаар хангах;

9.5 Гэмтэлтэй вагоныг засварын замд тавих, засварын газартай өртөөдөд шилжүүлэх талаар хамтран ажиллах

9.5.1. Техникийн байдлаар нийтийн болон нийтийн бус хэрэглээний замд ашиглах боломжгүй гэмтэлтэй вагоныг вагоны аж ахуйн ажилтан тогтооно. Вагоны гэмтлийг нотлох баримт бичиг нь вагоныг засварт илгээх мэдэгдэх хуудас бөгөөд тэр нь вагоныг гэмтэлтэй ангилалд хамааруулах үндэслэл болно. Мэдэгдэх хуудсыг вагон ашиглалтын засвар, техникийн үйлчилгээний заавар, техникийн үйлчилгээний систем, дүрмийн шаардлагад тохироогүй бүх төрлийн вагонд бичнэ.

9.5.2. Гэмтэлтэй вагоныг засварын өртөөнөөс засварын газарт илгээх үед мэдэгдэх хуудаснаас гадна вагон үзлэгийн газрын ажилтны бүрдүүлсэн “Дагалдах хуудас” дагалдана. Өртөө нь вагоны аж ахуйн бүрдүүлсэн мэдэгдэх хуудаст заагдсан засварын ажлыг гүйцэтгүүлэхээр гэмтэлтэй вагонуудыг өртөөний замаас засварын замд эсвэл орон нутгийн заавар үгүй бол хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэгийн оператортой байгуулсан гэрээгээр тодорхойлогдох журмын дагуу нийтийн бус хэрэглээний замд тавина.

Вагон тавих үед өртөөний ачаа вагон хүлээлцэгч ажилтан вагон тавих, татах журмын дагуу “Санамж” нээнэ. Нийтийн бус хэрэглээний замд шилжүүлсэн гэмтэлтэй вагон нь дэд бүтцийн гэмтэлтэй вагоноос хасагдана. Засварт явуулж байгаа гэмтэлтэй бүх вагонууд мөн түүнчлэн бүртгэлээс хасах, хаягдал төмөр болгох газарт хүргэх, ажлын бус паркийн бүх вагонуудыг техник үзлэгийн газарт хүргэхэд хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахаар бэлтгэсэн байна.

Хэрэв вагоны техникийн байдал нь хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахгүй тохиолдолд вагоныг ойрын салгалттай засварын газарт хүргэхээр явуулж, төлөвлөгөөт засварт оруулахаар бэлтгэнэ.

Дунд болон их засварт орох ажлын бус паркийн вагоныг шилжүүлэх ажлыг тээвэр зохион байгуулалтын нэгж нь төмөр замын техник ашиглалтын дүрмийн шаардлага, вагоны аж ахуйн тодорхойлсон мэдэгдэх болон дагалдах хуудасыг үндэслэн зохион байгуулна.

Энэ ажлын хүрээнд вагоны аж ахуй “Ачааны вагоны засвар, техникийн үйлчилгээний систем” -ийн тухай захирамжийн дагуу шаардлагатай баримт бичгийг бүрдүүлнэ.

Төлөвлөгөөт засварт орох вагоныг тэдгээрийн техникийн байдлаас үл хамааран засвар хоорондын хугацаа, гүйлтийн хэмжээ хэтэрсэн вагоныг хугацаанд нь засварт оруулж гэмтэлгүй вагоны жагсаалтад оруулах хариуцлагыг хүлээнэ.

АРАВ. ЗҮТГҮҮР, ЗҮТГҮҮРИЙН БРИГАДЫН АЖЛЫГ УДИРДАХ

10.1. Энэ технологи нь галт тэрэгний хөдөлгөөнд үйлчлэх зүтгүүр, зүтгүүрийн бригадын үйл ажиллагааг хангах мөн түүнчлэн тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч төмөр замын тээврийн байгууллагуудын аж ахуйн нэгжүүдийн хамтран ажиллах журмыг тодорхойлно.

Тээвэр зохион байгуулалтын болон зүтгүүрийн аж ахуйн нэгжүүдийн хамтран ажиллах үндсэн зорилго бол ачаа, зорчигч тээвэрлэхэд шаардагдах галт тэрэгний хэрэгцээг тодорхойлох, тэдгээрийг зүтгүүр, зүтгүүрийн бригадаар хангах явдал юм.

10.1.1. Тээвэр зохион байгуулалтын болон зүтгүүрийн аж ахуйн нэгжүүдийн хамтын ажиллагаа дараах зарчимд үндэслэгдэнэ.

- а. Татах хэрэгслийн нөөцийг төлөвлөх, нэгдсэн технологийн горимын шаардлагыг биелүүлэх, төсөв бүрдүүлэх, чанарын үзүүлэлтүүдийг тодорхойлох, биелэлтэд хяналт тавих;
- б. Зүтгүүрийн эргэх мөр хооронд зүтгүүр, зүтгүүрийн бригадыг төвлөрсөн удирдлагаар хангах;
- в. Галт тэрэгний хөдөлгөөний зурмаг, өртөөдийн болон ашиглалтын деподын ажлын технологийн горимоор тогтоогдсон технологийн норм, нормативыг хатуу мөрдөх;
- г. Зүтгүүрийн бригадын ажиллах, амрах дэглэмийн шаардлагыг хангах;
- д. Зүтгүүрийг техникийн үйлчилгээ, төлөвлөгөөт засварт хугацаанд нь оруулах;
- е. Галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлагыг хангах;

Технологийн үндсэн баримт бичиг бол төмөр замын хэсгүүдийг зүтгүүрийн паркаар үйлчлэх ажлын технологийн горим болно. Сүхбаатар – Улаанбаатар, Улаанбаатар – Замын Үүд, Дархан – Эрдэнэт, Улаанбаатар – Багануур, Зүүнбаян – Тавантолгой, Тавантолгой – Гашуунсухайт гэх мэт дурьдаж болно.

10.1.2. Зүтгүүр, зүтгүүрийн бригадыг удирдах технологи дараах зарчимд үндэслэгдэнэ.

- а. Дэд бүтэц эзэмшигч, тээвэрлэгчийн тогтоосон зүтгүүр, зүтгүүрийн бригадын эргэх мөрийн урт ба бүдүүвч;
- б. Ачааны галт тэргийг зүтгүүрээр үйлчлэх (ганц, хос гэх мэт) технологи, хэсэг бүрт ажиллах зүтгүүрийн бригадын ажлын онцлогийг тооцсон технологи;
- в. Дэд бүтцийн зарим объектод засвар, шинэчлэлт, арчилгаа, үйлчилгээ хийхээр “Цонх” гаргасан үед галт тэрэгний хөдөлгөөн зохион байгуулах онцлог;
- г. Төлөвлөгдсөн тээвэрлэлтийг хангахад шаардагдах зүтгүүр, зүтгүүрийн бригадын тоог тодорхойлж, тохируулах;
- д. Зүтгүүрийг техникийн үйлчилгээ, төлөвлөгөөт засварт хугацаанд нь оруулах;
- е. Зүтгүүр, зүтгүүрийн бригадын ажлын технологийг эдийн засагт үндэслэгдсэн зарчмаар оновчтой болгох;

10.2 Зүтгүүр, зүтгүүрийн бригадын эргэх мөрийн бүдүүвч, ачааны галт тэрэгний жин, уртын хэмжээг тогтоох

10.2.1. Зүтгүүр, зүтгүүрийн бригадын эргэх мөрийн урт ба бүдүүвч, ачааны галт тэрэгний жин, уртын хэмжээ, тэдгээрийн өөрчлөлтийг тогтоох ажиллагаанд:

- а. Зүтгүүрийн төрөл, түүний техникийн тодорхойлолт, татах хөдөлгүүрийн чадал, замын хэвгий зэрэг шаардагдах өгөгдлийг бүрдүүлэх;
- б. Дэд бүтцийн вагоны аюулгүй аялах баталгаат мөр, зүтгүүрийн засвар хоорондын гүйлтийн нормтой холбоотойгоор зүтгүүр эргэх хэсгийн хилийг техник эдийн засгийн үндэслэлтэй ашигтай хувилбарыг тодорхойлох;

10.2.2. Дараах тохиолдолд тээвэр зохион байгуулалтын нэгж зүтгүүр эргэх мөрийг өөрчлөн тогтооход санал оруулна.

- а. Зүтгүүрийн ажлыг оновчтой болгох санал ирэх;
- б. Хуучин зүтгүүрийг шинэчлэх эсвэл шинэ зүтгүүр ашиглалтанд оруулах;
- в. Дэд бүтцийн байдал өөрчлөгдөх (цахилгаанжуулах, шинээр хэсгийн өртөө ашиглалтад оруулах гэх мэт) ;
- г. Дэд бүтэц эзэмшигч, тээвэрлэгчийн замд бусад дэд бүтэц эзэмшигчийн зүтгүүртэй түүний найруулсан галт тэргийг гаргах;

Зүтгүүр, зүтгүүрийн бригадын эргэх мөрийг тогтооход зүтгүүрийн аж ахуйн нэгж, зүтгүүрийн ашиглалтын депо, дэд бүтэц эзэмшигч, зүтгүүр эргэх мөрт ажилладаг эсвэл ажиллах зүтгүүр эзэмшигчийг оролцуулбал зохино.

10.2.3. Зүтгүүрийн аж ахуйн нэгж, зүтгүүрийн депо зүтгүүр эргэх мөрийг шинээр тогтоох бүрт зүтгүүрийг техникийн үйлчилгээ, засварт оруулах технологийг боловсруулахын тулд:

а. Тээвэр зохион байгуулалтын нэгж зүтгүүр эргэх тухайн хэсгээр тээвэрлэх ачааны хэмжээг хангахаар төлөвлөж байгаа зүтгүүрийн тоо, түүний хоногийн дундаж гүйлтийн талаар мэдээлэл өгнө.

б. Зүтгүүр эргэх мөрт үйлчлэх зүтгүүрийн шугамын нийт гүйлтийг тодорхойлно.

г. Дэд бүтэц эзэмшигчийн тогтоосон аргачлалын дагуу төрөл бүрийн засварт оруулах зүтгүүрийг тодорхойлох, засварын программыг боловсруулах;

д. Засвар хийх зүтгүүр ашиглалтын депогийн хүчин чадлаас хамааруулан хоногийн дундаж гүйлтийг үндэслэн зүтгүүрийг засварт оруулах хугацааг тогтоох;

е. Зүтгүүрийг засварт оруулах төлөвлөгөөг жил, улирал, сараар төлөвлөх;

Дэд бүтэц эзэмшигч, тээвэрлэгчийн замаар галт тэрэгний хөдөлгөөнд оролцож байгаа зүтгүүрийн өмчлөгч нь зүтгүүрийг засварт оруулахаас 3 хоногийн өмнө дэд бүтэц эзэмшигчийн зохих нэгжид мэдэгдэнэ. Зүтгүүрийн бригадын ажиллах мөрийн уртыг тогтоох, өөрчлөхөд тээвэр зохион байгуулалтын ба зүтгүүрийн аж ахуйн нэгжүүд хамтран оролцоно.

10.2.4. Галт тэрэгний бүрэлдэхүүний жингийн нормыг галт тэрэгний бүрэлдэхүүнд үйлчлэх зүтгүүрийн ашигтай хувилбартай уялдуулан сонгоно.

Галт тэрэгний бүрэлдэхүүний ашигтай жин ба бүрэлдэхүүнд үйлчлэх зүтгүүрийн сонголтын шалгуур нь дэд бүтцэд ашиглаж байгаа техникийн боломжоор тээвэрлэлт гүйцэтгэхэд гарах хамгийн бага ашиглалтын зардал болно. Жигдрүүлсэн ба жингийн дээд (ашигтай) хэмжээг татах тооцоогоор тогтооно.

Хоёр ба түүнээс дээш дэд бүтцээр аялах ачааны галт тэрэгний жингийн нормыг дэд бүтцүүдийн тээвэр зохион байгуулалтын нэгж, зүтгүүрийн болон замын аж ахуйн нэгжүүд зөвшилцөн тогтооно. Харин нэг дэд бүтцийн хүрээнд тухайн дэд бүтцийн тээвэр зохион байгуулалтын болон зүтгүүр, замын аж ахуйн нэгжтэй зөвшилцөн дэд бүтэц эзэмшигч тогтооно.

Тогтоосон жингийн нормтой галт тэргийг жолоодох шаардлагыг хангаж чадахгүй зүтгүүр ашиглахыг хориглоно.

10.3 Ачааны галт тэргэнд үйлчлэх зүтгүүр ба зүтгүүрийн бригадын нормчлол

10.3.1. Ерөнхий байдал

Ачааны хөдөлгөөнд үйлчлэх зүтгүүрийн тоог зурмагийн ба аналитик аргаар тогтооно. Удирдлагын бүх түвшинд үйлчлэх зүтгүүр ба зүтгүүрийн бригадын тоог дараах байдлаар гаргана.

а. Хоног, ээлжинд – Хоног, ээлжийн шуурхай төлөвлөгөөгөөр;

б. Сард – Сарын ажлын техникийн төлөвлөгөөгөөр;

в. Жилд – Галт тэрэгний хөдөлгөөний батлагдсан зурмагаар;

10.3.2. Ачааны хөдөлгөөнд үйлчлэх зүтгүүрийн парк ба шаардагдах зүтгүүрийн бригадыг нормчлох:

а. Ачааны хөдөлгөөнд үйлчлэх зүтгүүрийн тоо, жилд тээвэрлэхээр төлөвлөж байгаа захиалсан ачаа эргэлт ба зүтгүүрийн хоногийн дундаж бүтээмжээр тодорхойлогдоно.

б. Тээвэр зохион байгуулалтын нэгж тооцооны жилийн, ашиглалтын паркийн зүтгүүрийн хоногийн дундаж бүтээмжийн даалгаврыг сараар хувааж тогтооно.

в. Тээвэр зохион байгуулалтын нэгж өгөгдсөн ачаа эргэлт ба ашиглалтын паркийн зүтгүүрийн төлөвлөсөн жилийн бүтээмжийг үндэслэн шаардагдах ашиглалтын паркийн хоногийн дундаж зүтгүүрийн тоог улирал, сараар хуваарилан тооцоолно.

г. Өгөгдсөн тээвэрлэлтийг биелүүлэхэд шаардагдах өөрийн паркийн зүтгүүрийн тоог тээвэр зохион байгуулалтын нэгж зүтгүүрийн аж ахуйн нэгжтэй хамтран тодорхойлно.

д. Зүтгүүрийн тоо ба засварын программыг үндэслэн зүтгүүрийн аж ахуйн нэгж засварын депотой хамтран гэмтэлтэй зүтгүүрийн эзлэх хувийг тогтоох ба төлөвлөж байгаа жилийн тээвэрлэлтийг зохион байгуулахад шаардагдах зүтгүүрийн паркийн нийт тоог тодорхойлно.

е. Зүтгүүрийн аж ахуйн нэгж тээвэр зохион байгуулалтын нэгжтэй хамтран зүтгүүрийн бригадын тоог тодорхойлно.

ё. Өөрийн найруулсан галт тэргээр ачаа тээвэрлэлтийг зохион байгуулахад, гэрээгээр түрээсэнд өгсөн зүтгүүрийн бригадыг тооцон, нэмж шаардагдах зүтгүүрийн бригадын тоог тодорхойлно.

ж. Зүтгүүрийн аж ахуйн нэгжирэх онд ажиллах зүтгүүрийн бригадын тоог тооцоолно.

з. Шаардагдах зүтгүүрийн бригадыг деподоор хуваарилах.

и. Зүтгүүр ашиглалтын деподод дуудлагаар мөн нэрийн жагсаалтаар ажиллах зүтгүүрийн бригадын ашиглалтын нормыг депо батлана.

10.3.3. Ачааны хөдөлгөөний зурмагийн хэмжээг хангах зүтгүүр ба зүтгүүрийн бригадын ажлын нормчлол:

10.3.3.1. Галт тэрэгний хөдөлгөөний боловсруулсан зурмаг ба зүтгүүрийн мөрийг үндэслэн ачааны галт тэргэнд үйлчлэх зүтгүүрийн тоог зурмагийн аргаар тодорхойлно.

Зүтгүүр эргэх мөрийн зурмагийг түүний эргэх хэсэг бүрээр зохионо.

а. Хөдөлгөөнийг удирдах нэг хэсгээр – тээвэр зохион байгуулалтын нэгжийн мэргэжилтэн.

б. Хоёр түүнээс дээш хэсгээр – Зүтгүүрийн аж ахуйн нэгжийн мэргэжилтэн.

10.3.3.2. Зүтгүүрийн эргэлтэнд байх хугацааны нормыг дараах үе шаттайгаар тогтооно.

а. Зүтгүүр ачааны хөдөлгөөнд татах мөрд хоёр чиглэлд аяласан хугацаа;

б. Зүтгүүр эргэх депотой өртөөнд зогсох хугацааны норм;

г. Зүтгүүрийн бригад солих өртөөнд зүтгүүр хоёр чиглэлд зогсох хугацааны нормоор тодорхойлогдох бөгөөд тэр нь зогсолтын тооноос хамаарна.

д. Зүтгүүр эргэлтийнхээ хугацаанд үндсэн депотой өртөөнд байх хугацааны норм;

Зүтгүүр эргэх мөрөнд байрлах зүтгүүрийн бригадын эргэх хэсгээр зохиогдсон ачааны галт тэрэгний хөдөлгөөний батлагдсан зурмаг, зүтгүүр эргэлтийнхээ хугацаанд депо ба өртөөний замд зогсох нормт хугацааг үндэслэн тээвэр зохион байгуулалтын нэгжийн ажилтан зүтгүүр эргэх хэсгийн зурмагийг зохионо.

10.3.3.3. Зүтгүүрийн эргэх хугацааг үндэслэн галт тэрэг хэсэг бүрээр хос галт тэргэнд шаардагдах зүтгүүрийн коэффициентийг тодорхойлно.

10.3.3.4. Шаардагдах зүтгүүрийн хэрэгцээг тодорхойлсон аргаар хөдөлгөөний батлагдсан зурмагт тусгагдсан тээвэрлэлтийг хангахад шаардагдах, дуудлагаар ажиллах зүтгүүрийн бригадын тоог дараах байдлаар тодорхойлно.

а. Зүтгүүрийн бригадын туслах ажил гүйцэтгэх хугацаа ба бэлтгэл, эцсийн ажиллагаа гүйцэтгэхэд шаардагдах хугацааг тогтоох;

б. Зурмагаар явах хугацааны норм, үндсэн ба эргэлтийн депотой өртөөдөд зогсох хугацааг тооцон зүтгүүрийн бригадын эргэх зурмаг зохиох;

10.3.3.5. Шаардагдах зүтгүүр ба түүний ашиглалтын үзүүлэлтийг зүтгүүрийн нийт паркаар, татах хэрэгслэлийн төрлөөр (цахилгаан, дизель) мөн түүнчлэн галт тэрэг (транзит, хэсгийн, түүвэр, зөөврийн ба дамжуулах) бүрээр тусад нь тооцоолно. Үүний тулд зүтгүүр ашиглалтын үзүүлэлтийг дараах байдлаар бүлэглэнэ.

а. Зүтгүүрийн бригадын эргэх мөрөөр;

б. Зүтгүүрийн бригадын бүртгэгдсэн деподоор;

в. Зүтгүүр ашиглалтын деподоор;

г. Замаар бүхэлд нь;

10.3.4. Сарын техникийн төлөвлөгөө зохиох үед зүтгүүр, зүтгүүрийн бригадын тоог нормчлох.

10.3.4.1. Ачааны паркийн зүтгүүрийн нормчлолд дараах асуудлууд тусгагдана.

а. Тээвэр зохион байгуулалтын нэгж зүтгүүрийн аж ахуйн нэгжтэй хамтран төлөвлөгдсөн тээвэрлэлтийг хангахад шаардагдах ачааны ашиглалтын паркийн зүтгүүрийг сараар, хоногийн дунджаар, зүтгүүр эргэх мөрөөр тооцоолон тогтооно.

б. Гэмтэлгүй зүтгүүрийг шаардлагатай үед зүтгүүрийн эргэх мөрөөр дахин хуваарилах;

10.3.4.2. Ачааны хөдөлгөөнд үйлчлэх зүтгүүрийн сарын техникийн нормчлолыг тогтоосон журмын дагуу дараах дарааллаар гүйцэтгэнэ.

а. Тээвэр зохион байгуулалтын нэгж зөөврийн болон дамжуулах галт тэрэгний хөдөлгөөн мөн түлхэгч зүтгүүрийн ажлыг тооцон, төлөвлөж байгаа сарын хоногийн дундаж ашиглалтын паркийн зүтгүүрийг, зүтгүүрийн бригадын ажиллах хэсгээр тодорхойлох;

б. Төлөвлөгдөж байгаа сард шаардагдах зүтгүүрийн хэмжээг зүтгүүрийн аж ахуйн нэгжтэй зөвшилцөх, батлах;

в. Зүтгүүрийн аж ахуйн нэгжт ирэх сард ашиглалтын деподоор ашиглах, арчлах, ачааны хөдөлгөөний гэмтэлгүй зүтгүүрийн сарын даалгаврыг тогтоох;

10.3.4.3. Ачааны хөдөлгөөнд үйлчлэх зүтгүүрийн бригадын сарын ажлын хэмжээг дараах дарааллаар тогтооно.

а. Зүтгүүрийн бригадыг солих өртөөдөөр тогтоосон сарын дундаж галт тэрэгний хөдөлгөөний (техникийн төлөвлөгөөгөөр) хэмжээг үндэслэн дуудлагаар ажиллах зүтгүүрийн бригадын аялал, гүйцэтгэх хугацаа ба сарын бүтээлийн нормыг тогтооно.

б. Орлох (нөхөх) коэффициентийг тооцон бүртгэгдсэн депогийн хүрээнд ажиллах зүтгүүрийн бригадын тоог нэрсийн жагсаалтаар тооцоо хийх;

10.3.4.4. Зүтгүүрийн бригадын ажлын тогтоосон технологиос хамааруулан зүтгүүрийн бригадыг аялалд дуудах ажлыг зүтгүүр ашиглалтын депод дараах байдлаар зохион байгуулна.

- а. Зурмагийн хатуу хуваариар (дуудлагагүй систем) ;
- б. Дуудлагын системээр;
- в. Холимог системээр;
- г. Нэрийн жагсаалтаар (зурмагаар);

10.3.5. Галт тэрэгний ажлыг ээлж, хоногоор төлөвлөх үеийн суудлын болон ачааны хөдөлгөөний зүтгүүр, зүтгүүрийн бригадыг нормчлох:

10.3.5.1. Галт тэрэгний хөдөлгөөний ээлжийн болон хоногийн ажлын төлөвлөгөөнд ачааны хөдөлгөөний зүтгүүрийн паркийг дараагийн хоногийн ажлаар, түүний эргэх мөрөөр, дэд бүтцээр бүхэлд нь тооцоолно.

Гол замын ачааны хөдөлгөөний зүтгүүрийн паркийг зүтгүүрийн бригадын эргэх мөр бүрээр нэг хос галт тэргэнд шаардагдах зүтгүүрийн коэффициентоор тодорхойлж, хэсгийн хурдны байдлаас хамааруулан ирэх хоногийн галт тэрэгний хөдөлгөөний зурмагт тусгана.

Зүтгүүрийн паркийг нормчлох үед дараах нөхцлийг мөрдөнө.

а. Галт тэргийг зүтгүүрийн ямар нэг илүүдэл гүйлтгүйгээр өртөөнөөс явуулах, зүтгүүрийг төлөвлөгөөт засвар техникийн үйлчилгээнд оруулах;

б. Галт тэрэгний ээлжийн болон хоногийн ажлын төлөвлөлтийн хүрээнд ачааны хөдөлгөөнд ашиглах зүтгүүрийн паркийг 14 цагаас өмнө замын хэмжээгээр нормчилно.

Хоногт тогтоосон галт тэрэгний хөдөлгөөний хэмжээг хангахад шаардагдах зүтгүүрийн паркийг тодорхойлох хариуцлагатан:

а. Нэг замын хязгаарт байрлах зүтгүүр эргэх хэсэгт диспетчерийн шуурхай нэгжийн ээлжийн ахлах диспетчер.

б. Хоёр ба түүнээс дээш дэд бүтцийн хүрээнд байрлах зүтгүүр эргэх хэсэгт зүтгүүрийн аж ахуйн диспетчер зүтгүүр эргэх бүх хэсэгт төвлөрүүлэн шуурхай удирдлагаар хангана.

Зүтгүүр эргэх мөр, зүтгүүр ашиглалтын деподоор тооцоот хоногт ашиглах ашиглалтын паркийн зүтгүүрийн тоог татах албанд танилцуулж зөвшилцсөний дараа дараагийн хоногийн тохируулгын даалгаврыг тогтооно.

10.3.5.2. Ээлжийн болон хоногийн ажлыг төлөвлөх үед ачааны хөдөлгөөнд өгөх шаардлагатай зүтгүүрийн бригадыг төлөвлөхдөө:

а. Дараагийн хоногт өнгөрүүлэхээр төлөвлөсөн галт тэрэг урсгалыг хангахад шаардагдах зүтгүүрийн бригадын тоог тэдгээрийн бүртгэгдсэн депод ба эргэлтээр нийтэд нь тодорхойлох;

б. “Эргэх” бригадыг тооцон зүтгүүр ашиглалтын депогоос галт тэргэнд өгөх зүтгүүрийн бригадын хэрэгцээг тодорхойлох;

Зүтгүүрийн бригадын бүртгэгдсэн деподоор галт тэргэнд үйлчлэх зүтгүүрийн бригадын нийт тоог төлөвлөж байгаа хоногийн галт тэрэгний хэмжээ, галт тэргийг зүтгүүрээр үйлчлэх хувилбар ба зорчигчийн хөдөлгөөнд тохируулгаар үйлчлэхээр явуулах зүтгүүрийн бригадын тооноос хамааруулан тогтооно.

Галт тэрэгний хөдөлгөөний ээлжийн болон хоногийн ажлын төлөвлөлтийн хүрээнд ачааны хөдөлгөөнд шаардагдах зүтгүүрийн бригадын нормчлолыг 14 цагаас өмнө гүйцэтгэнэ.

Хувийн хэвшлийн найруулсан галт тэрэгний үйлчлэх мөр ба зүтгүүрийн бригадын ажлын зохион байгуулалт нь төмөр замын сүлжээнд мөрдөгдөж байгаа зүтгүүр ба зүтгүүрийн бригадын ажлын технологитой тохирч байвал зохино

10.3.6. Сэлгээний ба бусад ажиллагаанд үйлчлэх зүтгүүр ба зүтгүүрийн бригадын нормчлол.

10.3.6.1. Тээвэр зохион байгуулалтын нэгж нь зүтгүүрийн аж ахуйн нэгжтэй хамтран ашиглалтын ажлыг хангах сэлгээний зүтгүүрийн тоог дараах нөхцлөөр тогтооно.

а. Нийтийн болон нийтийн бус хэрэглээний замд сэлгээний ажил гүйцэтгэх;
б. Өртөөний замд боловсруулах вагоны хэмжээнээс хамааруулан сэлгээний ажил гүйцэтгэх;

10.3.6.2. Дэд бүтцийн хэмжээнд шаардагдах сэлгээний зүтгүүрийн тооцоог өгөгдсөн ачаа эргэлтэнд тулгуурлан дараах журмаар тооцоолно.

а. Дэд бүтцийн хэмжээнд хоногт дунджаар боловсруулах вагоны тоо болон сэлгээний нэг зүтгүүрээр хоногт дунджаар боловсруулахаар төлөвлөж байгаа вагоноор;
б. Сэлгээний зүтгүүрийн ачаалалыг 87%-иас хэтрүүлэхгүй (сэлгээний зүтгүүрийн ажиллах хугацааны үргэлжлэлийг ээлжийн ажлын цагтай харьцуулахад) байлгахаар;

Төлөвлөж байгаа үеийн өмнөх улиралд сэлгээний зүтгүүрийн ажилд хийсэн шинжилгээг үндэслэн тодорхойлно.

10.3.6.3. Шаардагдах сэлгээний зүтгүүрийн тоог өртөөдөөр дараах журмаар тооцоолно.

а. Ялгалтын, хэсгийн ба ачааны өртөөдөд шаардагдах сэлгээний зүтгүүрийн тоог, сэлгээний ажил гүйцэтгэх хугацаа тогтоох аргачлал, өртөөний ажлын технологийн горимд тохируулан тогтооно.

б. Завсрын өртөөдөд шаардагдах сэлгээний зүтгүүрийн тоог ачааны өртөөнийхтэй адил завсрын нэг өртөөнөөс вагонтой эсвэл вагонгүй нөгөө өртөөнд очих хугацааг тооцон тогтооно.

в. Зорчигчийн өртөөнд шаардагдах сэлгээний зүтгүүрийн тоог зорчигчийн галт тэрэгний ирэлт, явуулалтад хийх хоногийн ажлын төлөвлөгөө зурмаг ба өртөөний ажлын технологийн горимийг үндэслэн тооцоолно.

10.3.6.4. Сэлгээний зүтгүүрийн тогтоосон тоог үндэслэн сэлгээний хөдөлгөөнийг хангахад шаардагдах зүтгүүрийн бригадын тоог тодорхойлно.

10.3.7. Аж ахуйн галт тэрэгний зүтгүүр ба зүтгүүрийн бригадын нормчлол:

10.3.7.1. Оны эцэст дэд бүтэц эзэмшигч нь ирэх онд гүйцэтгэх дэд бүтцийн объектуудын шинэчлэл, засвар, үйлчилгээ, оношилгооны ажлын төлөвлөгөөг гүйцэтгэхэд шаардагдах зүтгүүрийн тоог хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигчийн зүтгүүрийг оролцуулан сар, ээлжээр тодорхойлно.

10.3.7.2. Зүтгүүрийн аж ахуйн нэгж ирэх оны аж ахуйн хөдөлгөөнд шаардагдах зүтгүүрийн тоог тооцоолсон дэд бүтэц эзэмшигчийн ирүүлсэн төлөвлөгөөний төслийг судлаж шийдвэрлэнэ.

10.3.7.3. Аж ахуйн галт тэргэнд өгөх зүтгүүрийн техникийн тодорхойлолт нь (чадал, бүтээмж зэрэг) төлөвлөж байгаа ажлыг хангахаар байвал зохино.

10.3.7.4. Аж ахуйн ажилд шаардагдах зүтгүүрийн бригадын тоо нь ээлжийн ажилд шаардагдах зүтгүүр цагаар тодорхойлогдоно.

10.3.7.5. Аж ахуйн хөдөлгөөнд ажиллах зүтгүүрийн бригадыг дэд бүтцийн хэмжээнд тогтоосон журмын дагуу бэлтгэнэ.

10.4. Зүтгүүр ба зүтгүүрийн бригадын ажлын шуурхай удирдлага

10.4.1. Ерөнхий байдал

10.4.1.1. Зүтгүүр ба зүтгүүрийн бригадын шуурхай удирдлагын зорилго нь ажлын хоногийн турш тээвэрлэлтийг зүтгүүр ба зүтгүүрийн бригадаар хангах, техникийн үйлчилгээ, засвар зэхэлтэнд зүтгүүрийг хугацаанд нь оруулах зэрэг ажлыг ашиглалтын хамгийн бага зардлаар гүйцэтгэх, зүтгүүрийн бригадыг ажил амралтын цагийн тогтоосон нормоор хангах нөхцлийг бүрдүүлэхэд оршино.

10.4.1.2. Зүтгүүр ба зүтгүүрийн бригадыг шуурхай удирдах төлөвлөгөөний шалгуур үнэлгээ нь дараах үзүүлэлтүүдийг бууруулахад оршино.

а. Төлөвлөж байгаа хоногт тээвэрлэлтийг хангахад шаардагдах зүтгүүр ба зүтгүүрийн бригадыг;

б. Галт тэрэгний ажилд зүтгүүрийн парк болон тохируулгаар явах ганц зүтгүүрийн тоо ба галт тэрэгний зогсолтыг багасгаснаар түлшний зарцуулалтыг;

в. Зүтгүүрийн бригадын үр бүтээлгүй, сул зогсолттой холбоотой ажлын цагийн зарцуулалт;

10.4.1.3. Зүтгүүр ба зүтгүүрийн бригадын ажлыг удирдах шуурхай төлөвлөгөөний хувилбарууд нь тогтоогдсон технологийн болон нөөцийн хязгаарлалтыг хангана.

а. Дэд бүтцийн хувьд тээвэр зохион байгуулалтын болон зүтгүүрийн аж ахуйн нэгжээр;

б. Шугамын аж ахуйн нэгжийн хувьд өртөө, зүтгүүрийн депо, зүтгүүрийн бригадын бүртгэгдсэн ба эргэлтийн депо, зүтгүүрийн техник үйлчилгээний газраар;

10.4.1.4. Тээвэрлэлтийг хангах зүтгүүр ба зүтгүүрийн бригадын үндсэн бодлого дараах асуудлуудыг шуурхай шийдвэрлэснээр тодорхойлогдоно.

А. Дэд бүтэц бүрээр бүхэлд нь:

а. Хөдөлгөөний төрөл бүрт шаардагдах зүтгүүр ба зүтгүүрийн бригадын;

б. Зүтгүүрийн эргэх мөрийн хүрээнд нөөцөөр илгээх зүтгүүрийн хэрэгцээ ба зүтгүүрийн бригадын ажиллах хэсгийн хүрээнд тохируулгаар илгээх (сулаар) зүтгүүрийн бригадын;

в. Зүтгүүрийг засварт оруулах, засвар техникийн үйлчилгээ, шинэчлэлт хийсний дараа депогоос гаргах;

г. Эргэх мөрийн хооронд зүтгүүрийг хуваарилах;

Б. Зүтгүүрийн ашиглалтын депо бүрээр:

а. 3 цагийн үелзэлтэйгээр зүтгүүр, зүтгүүрийн бригадыг галт тэргэнд өгөхөөр төлөвлөх;

б. Зүтгүүрийг засвар, техникийн үйлчилгээ, шинэчлэлтээс гаргах;

в. Зүтгүүр, зүтгүүрийн бригадыг 3 цагийн үелзэлтэйгээр галт тэргэнд уях төлөвлөгөө (үечилсэн төлөвлөлтийн үед);

10.4.1.5. Зүтгүүр ба зүтгүүрийн бригадын шуурхай ажлын системд бодлого боловсруулах, үр дүнг хянах, шуурхай төлөвлөх, таамаглах байдлыг үнэлэх ажлууд хамаарна.

10.4.2. Зүтгүүр, зүтгүүрийн бригадын ажлын шуурхай удирдлагыг хэрэгжүүлэх хүрээнд диспетчерийн шуурхай нэгж нь дараах үүргийг гүйцэтгэнэ.

10.4.2.1. Нэг дэд бүтцийн хүрээнд:

- а. Ашиглалтын паркад байгаа зүтгүүрүүдийн тоог хянах, шилжүүлэх ба зүтгүүрийн эргэх мөрөөр шуурхай тохируулах;
- б. Ажлын бус паркад байгаа зүтгүүрийн тоог хянах;
- в. Зүтгүүрийг бэхлэгдээгүй эргэх мөрөнд ажиллуулахгүй байх;
- г. Зүтгүүрт техникийн шинэчлэлт хийх, урсгал засвар, ТО-2 техникийн үйлчилгээнд хугацаанд нь оруулах;
- д. Зүтгүүрийн бригадыг түүний ажиллах мөрөнд шилжүүлэх, бэлэн байдалд хяналт тавих, тэднийг шуурхай тохируулах;
- е. Зүтгүүрийн бригадын ажил, амралтын дэглэмийг мөрдөх, хянах;
- ё. Дуудлагаар ажилладаг зүтгүүрийн бригадын бэлэн байдалд хяналт тавих;
- ж. Гүйлтийн нормын биелэлтийг хянах;
- з. Зүтгүүрийн бригадыг тэдгээрийн ажиллах хэсэгт хугацаанд нь солих нөхцлийг хангах;
- и. Нэрийн жагсаалтаар ажилладаг зүтгүүрийн бригадыг эргэх өртөөнөөс үндсэн өртөөнд цаг хугацаанд нь буцаах;
- й. Ашиглалтын паркийн зүтгүүрийг тэдгээрийн ажиллах хэсгээр нь шуурхай нормчлох;
- к. Зүтгүүрийн эргэх мөрөөр өнгөрүүлж байгаа зүтгүүрийг хянах;
- л. Хэсэгт түр хугацаагаар үлдээсэн галт тэргийг зүтгүүр ба зүтгүүрийн бригадаар хангах;

10.4.2.2. Хоёр ба түүнээс дээш дэд бүтцүүдийн хүрээнд:

- а. Ашиглалтын паркад байгаа зүтгүүрүүдийн бэлэн байдал, шилжилтийг хянах;
- б. Ашиглалтын бус паркад байгаа зүтгүүрүүдийн бэлэн байдал, шилжүүлэлтийг хянах;
- в. Бэхлэгдээгүй эргэх мөрөнд ажиллаж байгаа зүтгүүрийн (3 цагийн үелзэлтэй) хөдөлгөөнийг хянах;
- г. Бэхлэгдээгүй эргэх мөрөнд ажиллаж байгаа зүтгүүрийг буцаах, хоногийн төлөвлөгөөг мөрдөх, хянах;
- д. Дэд бүтэц хоорондын уулзварын өртөөдөөр дамжуулах зүтгүүрт хяналт тавих;
- е. Ажиллагаагүй зүтгүүрийн дамжуулалтыг (шилжүүлэлт) мөрдөх;
- ё. Хоёр ба түүнээс дээш дэд бүтцийн зүтгүүр эргэх мөрөнд ажиллаж байгаа зүтгүүрийн төлөвлөгөөт урсгал засвар, техникийн үйлчилгээнд орох ба шинэчлэлт хийхээр депо явах хөдөлгөөнийг хянах;
- ж. Хоёр ба түүнээс дээш дэд бүтцийн зүтгүүрийн бригадын эргэх хэсэгт ажиллаж байгаа зүтгүүрийн бригадын хуваарилалтад хяналт тавих;
- з. Хоёр ба түүнээс дээш дэд бүтцийн зүтгүүр эргэх мөрөнд аялж байгаа зорчигчийн алсын харилцааны галт тэрэгний өнгөрүүлэлтэд хяналт тавих;
- и. Хоёр ба түүнээс дээш дэд бүтцийн хүрээнд байрлах зүтгүүр эргэх мөрүүдэд ачааны паркийн зүтгүүрийг тохируулах даалгавар бэлтгэх;
- й. Хоёр ба түүнээс дээш дэд бүтцийн хүрээнд байрлах зүтгүүр эргэх мөрүүдээр ашиглалтын паркийн зүтгүүрийг шуурхай төлөвлөх;

10.4.3. Ачааны галт тэрэгний зүтгүүр ба зүтгүүрийн бригадын шуурхай удирдлага.

10.4.3.1. Зүтгүүр ба зүтгүүрийн бригадын шуурхай удирдлагын үндэс нь:

а. Ачааны хөдөлгөөнд:

- Галт тэрэгний хөдөлгөөний батлагдсан болон хувилбарын зурмагийг (цонхны үед, тээврийн онцгой нөхцөлөөр аялах г.м) үндэслэн зүтгүүрийн технологийн эргэлтийн зурмаг ба хоног,

ээлжийн ажлыг 6 цагт хуваан түүнийг гурав гурван цагаар үечлэн төлөвлөсөн галт тэрэг урсгалыг өнгөрүүлэх таамагласан загвар.

б. Сэлгээний ба бусад ажил мөн түүнчлэн аж ахуйн хөдөлгөөнд:

- Тээвэр зохион байгуулалтын нэгж болон дэд бүтэц эзэмшигчийн захиалга.

10.4.3.2. Галт тэргийг зүтгүүрээр хангах ажиллагааны үндэс:

- а. Галт тэрэг найруулах төлөвлөгөө ба хөдөлгөөний зурмагт бэхлэх;
- б. Уулзварын өртөөдөөр солилцохоор зөвшилцсөн галт тэрэг;
- в. Зүтгүүрийн паркийн ажлын технологийн горимоор тогтоосон техникийн ба эргэлтийн өртөөдөд гаргасан нөөц зүтгүүр;
- г. Дамжин өнгөрөх галт тэрэгний зүтгүүрийг эргэлтийн өртөөнд солих төлөвлөгөө;

Үүний тулд бүрэлдэхүүнийг зүтгүүрээр хангах нэгдсэн шууд технологийг хэрэгжүүлнэ

а. Сэлгээний диспетчер нь зүтгүүрийн депогийн жижүүртэй хамтран галт тэрэг найруулах төлөвлөгөөг үндэслэн өртөөнд байгаа зүтгүүрийг болон өртөөнд ойртон ирж байгаа галт тэрэгний бүрэлдэхүүнийг зүтгүүрийн бригадаар хангах төлөвлөгөөг урьдчилан төлөвлөж (3 цагийн өмнө), зурмагт уях;

б. Хэрэв өртөө нь бүх бүрэлдэхүүнийг зүтгүүр, зүтгүүрийн бригадаар хангах боломжгүй болсон тохиолдолд зүтгүүрийн диспетчер нь хөдөлгөөний ээлжийн ахлах диспетчерээр дамжуулан дэд бүтцийн удирдлагадтай зөвшилцөн зохих арга хэмжээг авна.

10.4.3.3. Эргэх мөрөнд үйлчилж байгаа бүх зүтгүүрүүдийн ажилд тасралтгүй хяналт тавих замаар зүтгүүрийг ТО-2 үзлэгт цаг хугацаанд нь оруулах нөхцлийг хангана.

Зүтгүүрийг цаг хугацаанд нь төлөвлөгөөт засвар, техникийн үйлчилгээ, шинэчлэлд оруулахын тулд зүтгүүрийн депогийн батласан зурмагийг үндэслэн засвар техникийн үйлчилгээнд оруулах, шинэчлэлт хийхээр тогтсон зүтгүүрийн тоо, дугаарыг хоногийн төлөвлөгөөнд тусгасан байна.

Зүтгүүрийг засвар, техникийн үйлчилгээ ба шинэчлэлд тавих, тэндээс гаргах ажилд зүтгүүрийн диспетчер хяналт тавина.

10.4.3.4. Зүтгүүрийн паркийг тохируулах арга хэмжээг боловсруулахтай нэгэн зэрэг зүтгүүрийг бригадаар хангах төлөвлөгөөг боловсруулна. Үүнд дараах асуудлууд хамаарна.

- а. Ажилд гаргахаар үндсэн депод ирэх зүтгүүрийн бригадын тоо;
- б. Зүтгүүрийн бригадыг үндсэн депогоос явуулах ба эргэлтийн депогоос үндсэн депод “Зорчигч” маягаар буцааж ирүүлэх төлөвлөгөө;
- в. Хэсэг дэх завсрын өртөөдөд зүтгүүргүй орхигдсон галт тэргийг авахаар илгээх төлөвлөгөө;

10.4.4. Сэлгээний болон бусад ажил гүйцэтгэх зүтгүүр, зүтгүүрийн бригадын ажлын шуурхай удирдлага

10.4.4.1. Тээвэр зохион байгуулалтын нэгж зүтгүүрийн аж ахуйн нэгжтэй хамтран шугамын аж ахуйн нэгжүүдэд сэлгээний зүтгүүр ажиллуулах тухай тушаал гаргана. Тушаалаар тогтоосон төлөвлөгөөг зүтгүүрийн депогийн удирдлага заавал гүйцэтгэвэл зохино.

10.4.4.2. Сэлгээний зүтгүүр ажиллуулах тушаал болон сэлгээний зүтгүүр гаргах хоног нь ээлжийн төлөвлөлтийн үндэс болно.

Тээвэр зохион байгуулалтын нэгж нь ээлжийн төлөвлөгөөгөөр тогтоосон сэлгээний зүтгүүрийн тоог багасгах шийдвэрийг зүтгүүрийн бригад ирэхээс 6-аас доошгүй цагийн өмнө гаргахыг зөвшөөрнө.

10.4.4.3. Сэлгээний зүтгүүрийн ажлын ачаалалд сар бүр шинжилгээ хийж түүнийг нэмэгдүүлэх эсвэл багасгах арга хэмжээ авна.

Ээлжийн болон хоногийн төлөвлөгөөгөөр тогтоосон сэлгээний зүтгүүрийн тоог дараах тохиолдолд нэмэгдүүлж болно.

- а. Өргөтгөл хийсний дараа өртөөнд сэлгээний нэмэгдэл район ашиглалтанд оруулсан;
- б. Нийтийн болон нийтийн бус хэрэглээний салбар замыг үйлчлэхээр нэмэгдэл гэрээ байгуулсан;

10.4.5. Аж ахуйн ажил гүйцэтгэх зүтгүүр ба зүтгүүрийн бригадын ажлын шуурхай удирдлага

10.4.5.1. Тогтоосон тооны зүтгүүр гаргах жилийн төлөвлөгөөг батласан тушаал нь ээлжийн болон хоногийн ажлын төлөвлөлтөөр аж ахуйн хөдөлгөөнд ажиллуулах зүтгүүр ба зүтгүүрийн бригадын тооны үндэс болно.

10.4.5.2. Ээлжийн болон хоногийн ажлыг төлөвлөх үед дэд бүтэц эзэмшигч нь тээвэр зохион байгуулалтын болон зүтгүүрийн аж ахуйн нэгжид дараагийн хоногын засварын ажилд шаардагдах зүтгүүрийн захиалгыг дараах агуулгатай өгнө.

- а. Захиалагчийн нэр;
- б. Ажил төлөвлөж байгаа газар;
- в. Ажлын төрөл;
- г. Ажил гүйцэтгэх хугацаа;
- д. Аж ахуйн галт тэрэгний дээд жин;
- е. Зүтгүүрийн төрөл;
- ё. Зүтгүүрийн бүртгэгдсэн депо;
- ж. Зүтгүүр байлгах хугацаа ба өртөөний нэр;

Зүтгүүрийн аж ахуйн нэгж захиалгыг батлаж зүтгүүрийн депод шаардагдах тооны зүтгүүр, зүтгүүрийн бригадаар хангах үүрэг өгнө.

10.4.5.3. Дэд бүтцийн объектод зам засварын ажил гүйцэтгэх зүтгүүр ба зүтгүүрийн бригадын ажлын технологи боловсруулах үед дараах асуудлыг тодорхойлно.

- а. Ажлын байр руу зүтгүүр явуулах өдөр, хугацаа болон тэдгээрийг бүртгэгдсэн депод нь эсвэл хуваарилсан өртөө рүү буцаах журам;
- б. Аж ахуйн галт тэргийг ажлын байр руу явуулах ба тэдгээрийг хуваарилсан өртөө рүү буцаах зурмаг;
- в. Зүтгүүрийн депогоос гаргах зүтгүүрийн тоо маяг;
- г. Зүтгүүрийг хүлээн авах ба гаргах журам;
- д. Дэд бүтцэд зам засварын ажил хийлгэхээр гаргасан зүтгүүрийг зэхэх, төлөвлөгөөт засварт оруулах, техникийн үйлчилгээ хийх журам;
- е. Зүтгүүрийг зэхэх, техникийн үйлчилгээ, засвар хийх депо;
- ё. Зүтгүүрийг техникийн үйлчилгээ, төлөвлөгөөт засварт оруулахаар явуулах зурмаг;

- ж. Бүртгэгдсэн депогоос явуулах зүтгүүрийн бригадын тоо;
- з. Бригадын бэлэн байх өртөө;
- и. Эмнэлгийн үзлэгт орох журам;
- й. Аяллын өмнө зааварчилгаа авах журам;
- к. Зүтгүүрийн бригадыг ажлын байранд хүргэх, буцаах журам;
- л. Зүтгүүрийн бригадын амрах журам ба зүтгүүрийн аж ахуйн нэгжийн захиалгаар ажиллах ээлжийн турш болон ээлж дууссаны дараа хооллолт зохион байгуулах журам;

10.4.6. Зүтгүүр ашиглах шуурхай удирдлага

Зүтгүүр болон зүтгүүрийн бригадын ажлыг:

- а. Дэд бүтцийн хэмжээнд зүтгүүрийн аж ахуйн нэгжийн зүтгүүрийн диспетчер
- б. Татах хэсгийн мөрөнд зүтгүүрийн депогын жижүүрүүд шуурхай удирдлагаар хангана.

Зүтгүүрийн диспетчерүүдийн үндсэн үүргийг хүснэгт 9.1 -т үзүүлэв.

Шинэ зүтгүүр, зүтгүүрийн бригадын ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд галт тэрэгний хөдөлгөөнтэй холбоотой тээвэр зохион байгуулалтын болон замын аж ахуйн, дохиолол холбоо, эрчим хүчний нэгжийн төв болон шугамын диспетчерүүдтэй нягт холбоотой ажиллана.

Зүтгүүрийн диспетчерийн бусад нэгжүүдийн диспетчерүүдтэй хамтран ажиллах үүрэг

Хүснэгт 9.1.

| Хамтран ажиллах ажилтан | Үүрэг |
|---|---|
| Зүтгүүрийн депогийн жижүүр | <ul style="list-style-type: none"> - Үндсэн ба эргэлтийн депод бэлэн байгаа ашиглалтын паркийн зүтгүүрийг шалгах; - Зүтгүүрийг засварт оруулах хуваарийн биелэлт, засвараас гаргалтанд хяналт тавих; - Хөдөлгөөний бүх төрлийг зүтгүүрийн бригадаар хангах; - Эргэлтийн өртөөнд ажиллаагүй зогсч байгаа зүтгүүрийн зогсолтын нормыг хэтрүүлэхгүй байх; - Үндсэн ба эргэлтийн депод зүтгүүрийн зогсох нормыг биелүүлэх; - Ээлжийн болон хоногийн ажлын төлөвлөгөө ба галт тэрэгний хөдөлгөөний байдлыг хугацаанд нь мэдэгдэх; - Эргэлтийн депод зүтгүүрийн бригадын амрах нормыг хангах; - Зүтгүүр, зүтгүүрийн бригадыг хугацаанд нь галт тэргэнд өгөх нөхцлийг хангах; - Тохируулгын даалгавраар ганцаар явах зүтгүүр, зорчигчоор сул явах бригадыг цаг хугацаанд нь явуулах; - Зүтгүүрийг хугацаанд нь нөөцөнд тавих ажлыг зохион байгуулах; |
| Зүтгүүрийн бригадыг бүртгэгч | <ul style="list-style-type: none"> - Зүтгүүрийн бригадын ажилдаа ирэх ажлыг зохион байгуулах - Эргэлтийн өртөөнд зүтгүүрийн бригадын амрах хугацааг баримтлах; |
| Зүтгүүрийн техник үзлэгийн мастер | <ul style="list-style-type: none"> - Зүтгүүрийг ТО-2 үзлэгт оруулах, гаргах төлөвлөгөөг хангах; - Зүтгүүр зэхэх ба техникийн үзлэгт байх тогтоосон хугацааг мөрдөх; |
| Галт тэрэгний хөдөлгөөний диспетчер (ДНЦ) | <ul style="list-style-type: none"> - Аяллын замд зүтгүүрийн бригадыг солихыг шаардах; - Зүтгүүрийн бригадын ажиллах дэглэмийг зөрчихгүйн тулд хоцорсон галт тэргийг хурдавчилсан аргаар өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах; - Хэсэг дэх галт тэрэгний байдал ба зүтгүүрийн хуваарилалтанд хяналт тавих; |

| | |
|---|---|
| | <ul style="list-style-type: none"> - Хэсэгт байгаа үйлдвэрээс болон засвараас ирж байгаа эсвэл засварт явуулж байгаа ганц, бүлэг зүтгүүр мөн түүнчлэн урсгал засвар, техникийн үйлчилгээнд оруулах, шинэчлэл хийгдэх зүтгүүрүүдийг хянах; - Ээлжийн ажлын төлөвлөгөөг хангахаар зүтгүүр, зүтгүүрийн бригадыг галт тэргэнд хугацаанд нь өгөх; |
| Зэргэлдээх хэсгийн ДНЦ | <ul style="list-style-type: none"> - Зэргэлдээх хэсэгт байгаа өөрийн хэсгийн зүтгүүрийг хянах; - Зүтгүүр тогтоосон хугацаандаа буцаж ирж байгааг хянах; |
| Өртөөний жижүүр (ДСП) | <ul style="list-style-type: none"> - Явуулах галт тэргийг зүтгүүр ба зүтгүүрийн бригадаар хангах ажлыг зөвшилцөх; - Засварт явж байгаа, тэндээс буцаж байгаа ганц болон бүлэг зүтгүүрийн өнгөрүүлэлтэнд хяналт тавих; - Өртөөний замд зүтгүүрийн зогсох технологийн хугацааг баримтлах; - Хоног, ээлжийн ба галт тэрэгний ажлын үечилсэн төлөвлөгөө, галт тэрэгний байдлын талаар мэдээлэх; |
| Зэргэлдээх дэд бүтцийн зүтгүүрийн диспетчер | <ul style="list-style-type: none"> - Тээвэр зохион байгуулалтын болон зүтгүүрийн аж ахуйн нэгжийн тушаал, захирамжтай танилцах; - Бусад дэд бүтцийн зүтгүүрүүдийг урсгал засвар, техникийн үйлчилгээнд оруулах нөхцлийг хангах; - Тохируулгын даалгавраар яваа ганц зүтгүүрийг уулзварын өртөөдөөр хугацаанд нь дамжуулах; |

Зүтгүүр ба зүтгүүрийн бригадын ажлын шуурхай удирдлага

Хүснэгт 9.2.

| Үзүүлэлтүүд | Зүтгүүрийн диспетчер | |
|--|--|--|
| | Зүтгүүрийн депогийн жижүүр | Галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын түвшин |
| Зүтгүүрийн диспетчерийн зориулалт | Депогийн хүрээнд зүтгүүр ба зүтгүүрийн бригадыг шуурхай удирдлагаар зохион байгуулах | Замын хэмжээнд ашиглалтын паркийн зүтгүүрийг бүхэлд нь түүний эргэх мөрөөр шуурхай удирдлагаар хангах |
| Зүтгүүрийн диспетчерийн үндсэн үүргүүд | Ашиглалтын ажлын ээлжийн болон хоногийн ажлын төлөвлөгөөний дагуу галт тэргийг зүтгүүр ба зүтгүүрийн бригадаар хангах | Өгөгдсөн ачааны хөдөлгөөнийг зүтгүүр ба зүтгүүрийн бригадаар хангах ажлыг дэд бүтцийн хэмжээнд зохион байгуулах, удирдах |
| | Депогийн хүрээний өртөөдийн галт тэргийг зүтгүүр, зүтгүүрийн бригадаар хангах ажлыг тохируулах | Ээлжийн болон хоногийн ажлын төлөвлөгөө зохиох, зүтгүүр ба зүтгүүрийн бригадыг галт тэргэнд өгч байгаа байдалд хяналт тавих |
| | Галт тэрэгний хөдөлгөөний диспетчер, зүтгүүрийн диспетчертэй хамтран зүтгүүрийн бригадын тасралтгүй ажиллах тогтоосон хугацааг баримтлах | Зүтгүүрийн бригадын болон зүтгүүрийн аж ахуйн нэгжийн ажилтны буруугаас гарсан галт тэрэгний саатлыг арилгах арга хэмжээг авах |
| | Зүтгүүрийг засвар, техникийн үзлэг, шинэчлэлд хугацаанд нь оруулах ажлыг зохион байгуулах | Зүтгүүрийн аж ахуйн нэгжийн ажилтны буруугаас зорчигчийн болон ачааны галт тэрэгний хөдөлгөөний зурмаг тасалдсан, баригдсан шалтгааныг тогтоож шуурхай арга хэмжээг авах |

| | | |
|--|---|---|
| | Зүтгүүр, зүтгүүрийн бригадын ажиллах хугацааны биелэлтэд хяналт тавих | Зүтгүүрийн паркийн арчлалтын норм ба тоонд хяналт тавих |
| | Ашиглалтын паркийн зүтгүүрийн хангалтанд хяналт тавих | |

10.4.7. Зүтгүүр ба зүтгүүрийн бригадыг шуурхай удирдах төлөвлөгөөний биелэлт, хяналтыг зохион байгуулах:

Дэд бүтцийн хэмжээнд ашиглалтын ажлыг диспетчерийн шуурхай нэгж, зүтгүүрийн депо ба өртөөдийн удирдлага зохион байгуулах бөгөөд тэд зүтгүүр ба зүтгүүрийн бригадын ажлын цаг ашиглалтын төлөвлөгөөний биелэлтийг хариуцна.

Зүтгүүр, зүтгүүрийн бригадын төлөвлөгөөний биелэлтийг шууд хариуцан, шуурхай удирдлагаар хангах албан тушаалтан:

- а. Дэд бүтцийн хэмжээнд - Зүтгүүрийн аж ахуйн нэгжийн зүтгүүрийн диспетчер;
- б. Шугам замд - Өртөөний ба сэлгээний диспетчер, зүтгүүрийн депогийн тоо бүртгэгч;

Зүтгүүрийн эргэх хугацааны биелэлтийг түүний элементүүдээр хариуцах албан тушаалтан:

- а. Аяллын замд - Зүтгүүрийн аж ахуйн нэгжийн ажилтан;
- б. Өртөөний замд - Тээвэр зохион байгуулалтын нэгжийн ажилтан;

Зүтгүүрийн бригадын аялах хугацааны ажлын цагийн тогтоосон хугацааны биелэлтийг шууд хариуцагч:

а. Депогийн нутаг дэвсгэрт зүтгүүр хүлээн авах, өгөх үед:

- Зүтгүүрийн бригадын ажилд ирсэн мөчөөс хяналтын цэгээр өнгөрөх хүртэлх хугацаа, буцах үед хяналтын цэгийг өнгөрснөөс ажлаас чөлөөлөгдөх (замналын хуудас хүлээлгэн өгөх) хүртэлх хугацаанд - Депогийн жижүүр;

б. Зүтгүүрийн бригадын өртөөний нутаг дэвсгэрт байх хугацаанд:

- Өртөөний жижүүр ба өртөөний диспетчер;

в. Өртөөний замд зүтгүүр хүлээн авах, хүлээлгэн өгөх үед:

- Зүтгүүрийн бригадын ажилд ирсэн мөчөөс зүтгүүр хүлээн авах хүртэл, зүтгүүр хүлээлгэн өгсөн мөчөөс машинчийн замналын хуудас хүлээлгэн өгөх хүртэл - Депогийн жижүүрийн;

- Зүтгүүр хүлээн авах мөчөөс явуулах хүртэл, галт тэрэг ирсэн мөчөөс зүтгүүрийг хүлээлгэн өгөх хүртэл - Өртөөний жижүүр ба сэлгээний диспетчерийн;

- Зүтгүүрийн бригадын галт тэрэгтэй байх хугацаанд - Өртөөний жижүүр, галт тэрэгний хөдөлгөөний диспетчерийн;

- Зүтгүүрийн бригад ажил гүйцэтгэхээр сул “Зорчигч”-оор явах үед - Депогийн жижүүр, галт тэрэгний хөдөлгөөний диспетчерийн;

Төлөвлөгөөний биелэлтийн явцад хоногийн турш хяналт тавих бөгөөд шаардлагатай бол өөрчлөлт оруулна. Тээвэрлэлтийг зүтгүүр, зүтгүүрийн бригадаар хангах үед зүтгүүрийн диспетчер хяналт тавьж, гарсан хүндрэл саатлыг арилгах ажлыг хугацаанд нь зохион байгуулна.

Ээлжийн ахлах диспетчер галт тэрэгний болон ачааны ажлын үечилсэн төлөвлөгөөний үе бүрийн өмнө тухайлбал өдрийн ээлжинд 12 болон 18 цагт ажлын явцыг дүгнэнэ.


Зүтгүүр, зүтгүүрийн бригадын ажлын төлөвлөгөө даалгаврын биелэлтийг ээлжийн ажил дууссаны дараа:

а. Дэд бүтцийн хэмжээнд – Диспетчерийн шуурхай нэгжийн дарга

б. Шугам замд - Өртөө, депогийн дарга нар авч хэлэлцэн үнэлэлт өгч, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах төлөвлөгөө боловсруулна.

Зүтгүүр ашиглалт, зүтгүүрийн бригадын ажлын цаг ашиглалтын үзүүлэлтэд хийх шуурхай шинжилгээг бодит хугацаанд зурмаг хэлбэрээр хийнэ.

Зураг 7. Татах нөөцийн удирдлагын процесс



Зүтгүүрийн бригадын ажлын цаг ашиглалтад хийх шинжилгээ нь элемент бүрийн бодит утга, хэм хэмжээ, эрхийн хооронд зөрүү гарах болгонд шалтгааныг тогтооход оршино.

Зүтгүүрийн ашиглалттай холбоотой зарим тодорхой үзүүлэлт биелээгүйн хариуцлагыг холбогдох албадын ажилтан хүлээнэ.

Галт тэрэг явуулах, зүтгүүрийг хуваарийн дагуу техникийн үйлчилгээ, урсгал засварт оруулах, ээлжийн болон хоногийн төлөвлөгөө биелээгүй мөн техник хэрэгслийн гэмтлийн улмаас өртөөний ажлын технологийн горим, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдал алдагдах, ашиглалтын ажилд саатал гаргасан буруутанг тогтоох асуудлыг хэлэлцэж шийдвэрлэхэд санал зөрөх тохиолдолд асуудлыг төмөр замын тээврийн байгууллагын удирдлагын хүрээнд шийдвэрлэнэ.

АРВАН НЭГ. МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ

11.1. Төмөр замын тээврийн байгууллагуудын тээвэрлэлтийн технологийн нэгдсэн горимийн мэдээлэл хангамж нь тээвэрлэлтийн үйл ажиллагааг зохион байгуулахад оролцогч төмөр замын тээврийн байгууллагууд болон төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчидыг шаардагдах мэдээллээр хангах мэдээллийн бааз бүхий хоорондоо харилцан үйлчлэх автоматжуулсан системийн иж бүрдлийг ашиглахад чиглэгдэнэ.

Технологийн нэгдсэн горимын мэдээлэл хангамжийн автоматжуулсан систем нь дараах үндсэн асуудлыг шийдвэрлэнэ.

а. Ирэх жилийн тээвэрлэх ачааны хэмжээг төмөр замын тээврийн байгууллагуудын дэд бүтцийн хүчин чадал, засвар үйлчилгээ, барилга угсралтын ажлыг жил, улирал, сараар төлөвлөх, таамаглах;

б. Дэд бүтцийн техник технологийн боломжийг тооцон ачаа илгээгч, нийтийн бус хэрэглээний зам эзэмшигч, хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэгийн оператор болон бусад улсын төмөр замтай ачаа, хоосон вагоны замналжуулалт ба хэмжээг харилцан тохиролцож тээвэрлэлтийн үйл ажиллагааны технологийн элементүүдийг тогтоох, төлөвлөх;

в. Тээвэрлэлтийн үйл ажиллагааг шуурхай удирдах ба хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх;

г. Тээвэрлэлтийн үйл ажиллагааны үзүүлэлтүүдийн статистик ба шуурхай тайлан хөтлөх;

11.2. Вагоны паркийн тоо, тэдгээрийн байршил, хуваарилалт, татах хэрэгслэлийн нөөц, ачаа тээвэрлэлтийг зохион байгуулах урт хугацааны гэрээ, дэд бүтцийн хэсэг, техникийн болон ачааны өртөөдийн нэвтрүүлэх чадварын байдал, тээвэрлэлтийн үйл ажиллагааны таамаглал ба математик загварчиллалын хэрэгсэл, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигчийн тоо тэдгээрийн ажлын технологи, ялангуяа нэвтрүүлэх, боловсруулах чадвар нь хязгаарлагдмал өртөө, хэсэг зэргийн мэдээллийн өгөгдлийг ашиглан ачаа тээвэрлэлт ба хоосон вагоны хөдөлгөөнийг төлөвлөх ба таамаглах. Дэд бүтцийн боломжийг үнэлэхэд тээвэрлэлтийн үйл ажиллагааны явцыг дэд бүтцийн хэмжээнд загварчлан гүйцэтгэнэ.

11.3. Дэд бүтцийн техник технологийн боломжийг тооцон ачаа илгээгч, нийтийн бус хэрэглээний зам талбай эзэмшигч болон бусад дэд бүтцүүдтэй хамтран ачаатай ба хоосон вагоны замналжуулалтын хэмжээг харилцан тохиролцох:

а. Ачаа хүлээн авагчийн буулгах чадвар болон дэд бүтцийн боломжинд тохирсон хэмжээний ачилтын захиалгыг ачаа илгээгчтэй зөвшилцөх;

б. Дэд бүтцийн хамгийн их ачаалалтай элементийг тодорхойлж дэд бүтцийн байдал, ачаалалд хяналт, шинжилгээ хийх;

в. Дэд бүтцийн боломжид тохирох хоосон вагоны гүйлтийн хэмжээг зөвшилцөх;

г. Тээвэрлэгч нь ачаа илгээгч, хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэгийн операторт төлөвлөж байгаа сарын ачаа тээвэрлэлтийн төлөвлөгөө ба хоосон вагоны хөдөлгөөний логистик бүдүүвчийг өгнө.

11.4. Тээвэрлэлтийн үйл ажиллагааны элементүүдийг тогтоох, төлөвлөх ажиллагаанд дараах автоматжуулсан системийг ашиглана.

а. Галт тэрэгний хөдөлгөөний зурмаг боловсруулах;

б. Галт тэрэг найруулах төлөвлөгөөний тооцоо;

в. Илгээгчийн замналжуулалтын төлөвлөгөө боловсруулах;

г. Ашиглалтын ажлын техникийн нормчлолыг тогтоох;

д. Татах хэрэгслэл, зүтгүүрийн бригадын төлөвлөлт ба нормчлол;

е. Нийтийн болон нийтийн бус хэрэглээний замуудад гүйцэтгэх үйл ажиллагааны технологийн нормыг тооцоолох;

11.5. Өөрийн мэдлийн мэдээллийн системтэй томоохон хэрэглэгчийн удирдлагын автоматжуулсан системийг төмөр замын тээврийн байгууллагад хэрэглэж байгаа автоматжуулсан системтэй холбож тээвэрлэлтийн баримт бичиг бүрдүүлэх ба ачилтын мэдээлэл авах, дамжуулах ажиллагааг автоматаар гүйцэтгэдэг системийг ашиглан цаасгүй технологи нэвтрүүлэх.

11.6. Удирдлагын автоматжуулсан системийн мэдээллийн баазыг ашиглан вагоны ба зүтгүүрийн парк, галт тэрэгний, орон нутгийн, өртөөний ажил болон зүтгүүрийн бригадын ашиглалт, галт тэрэгний хөдөлгөөний гүйцэтгэсэн зурмагийн шуурхай удирдлагад шинжилгээ, хяналт, үнэлгээ хийнэ.

Тээвэрлэлтийн үйл ажиллагааны удирдлага, хяналт, шинжилгээ, үнэлгээ дараах объектуудад хийгдэнэ.

а. Ачаатай ба хоосон вагоны тээвэрлэлтийн гэрээний биелэлт,

б. Ачилт ба тээвэрлэлтийн төлөвлөгөөний биелэлтэд ачаа илгээгч бүрээр хяналт тавих,

в. Зүтгүүр ба зүтгүүрийн бригадын бэлэн байдал, хуваарилалт,

г. Өртөөнд болон засварт байгаа вагоны зогсолтын хугацааны биелэлт.

11.7. Төмөр замд хэрэгжүүлсэн төрийн болон салбарын, аж ахуйн нэгжийн мэдээллийн системийн шаардлагыг үндэслэн тээвэрлэлтийн үйл ажиллагааны үзүүлэлтийн статистик ба шуурхай тайлан хөтлөнө.

11.8. Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчдын технологийн нэгдсэн горимийн хүрээнд дэд бүтэц эзэмшигч нь ачаа илгээгч, хүлээн авагч, хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэгийн операторыг гэрээний дагуу мэдээллээр хангах үйлчилгээ үзүүлнэ.

АРВАН ХОЁР. ТЭЭВЭРЛЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

12.1. Ашиглалтын ажилд хийх шинжилгээний зорилго нь тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч төмөр замын тээврийн байгууллага түүний аж ахуйн нэгжүүдийн тээвэрлэлтийн төлөвлөгөө, техникийн норм болон галт тэрэгний хөдөлгөөний зурмагийг биелүүлэх явдал юм.

Шинжилгээний дүнд өгөгдсөн төлөвлөгөө, даалгавар, техникийн нормыг биелүүлэхэд учирсан доголдол саатлын шалтгааныг тогтоож хүндрэлээс гарах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулна. Шинжилгээний явцад авсан арга хэмжээний үр дүнг хэлэлцэнэ.

Биелэлтийг төлөвлөгөөтэй харьцуулахаас гадна бодит ажлын хэмжээнд тохируулан оруулсан өөрчлөлттэй мөн түүнчлэн биелэлтийг өмнөх үетэй, эсвэл өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулна.

Ашиглалтын ажилд шинжилгээ хийхдээ салбар нэгжүүдийн үйл ажиллагааны үзүүлэлтүүд хоорондоо нягт уялдаатай байдгийг анхаарвал зохино.

Тухайлбал ачилтын төлөвлөгөөний биелэлтийг шинжлэхдээ ажлын паркийн вагоны хөдөлгөөний өөрчлөлт, орон нутгийн ажил, буулгалтын төлөвлөгөөний биелэлт, хоосон вагоны ашиглалт, дэд бүтэц хоорондын уулзвар өртөөдөөр солилцох галт тэрэг, вагоны хэмжээ, дэд бүтцийн болон татах хэрэгслэлийн хязгаарлалт болон бусад хүчин зүйлийн нөлөөллийг авч үзнэ.

12.2. Төмөр замын тээврийн байгууллага, түүний аж ахуйн нэгжүүдийн ашиглалтын ажлын статистик болон тайлант үзүүлэлтүүдийг жил, улирал, сараар, дэд бүтэц болон аж ахуйн нэгжийн удирдлагын түвшинд шинжилж үнэлнэ.

Удирдлагын хүрээнд дараах үндсэн шинжилгээ хийгдэнэ.

Татах хэрэгслэлийн нөөцийг удирдах хүрээнд:

а. Дэд бүтцийн болон нэгжүүдийн удирдлагын түвшинд:

- Зүтгүүр болон зүтгүүрийн бригадын ажлын цаг ашиглалтыг зүтгүүрийн эргэх мөрөөр болон дэд бүтцээр нийтэд нь шуурхай шинжлэх;

б. Зүтгүүр ашиглалтын деподын түвшинд:

- Төлөвлөгөөт засварын гүйцэтгэлийг шинжлэх;
- Зүтгүүр болон зүтгүүрийн бригадын ажлын цаг ашиглалтанд шуурхай шинжилгээ хийх;

Нийтийн болон нийтийн бус хэрэглээний замууд хооронд ачилтын нөөцийг тохируулах ажлын хүрээнд:

а. Дэд бүтцийн болон нэгжүүдийн удирдлагын түвшинд:

- Ачилтын захиалгыг дэд бүтцээр, өртөөдөөр хангаагүй шалтгаан болон вагон ашиглалтыг шинжлэх;

- Галт тэрэгний хөдөлгөөний зурмаг, галт тэрэг найруулах төлөвлөгөөний биелэлтийг шуурхай шинжлэх;

б. Өртөөдийн түвшинд:

- Тооцооны хуудасны биелэлтэд хийх шинжилгээ;
- Хоосон вагоны зогсолтыг үйлдэл бүрээр шинжлэх;

Галт тэрэгний ажлыг төлөвлөх, удирдах хүрээнд:

а. Дэд бүтцийн болон нэгжүүдийн удирдлагын түвшинд:

- Техникийн болон замналын хурдны биелэлт;

- Дэд бүтцүүд болон хэсэг хоорондох галт тэрэг, зүтгүүр дамжуулалтын биелэлт;
- Зорчигчийн ба ачааны галт тэрэгний хөдөлгөөний зурмагийн биелэлт;
- Ялгалтын (галт тэрэг найруулж явуулдаг өртөөд) өртөөд дахь ажиллагаатай ба ажиллагаагүй вагоны сул зогсолтын биелэлт;
 - Ашиглалтын ажилд саатал гаргасан техник хэрэгслэлийн гэмтлийн шалтгаан, үргэлжлэх хугацаа, гарсан хохирол, авсан арга хэмжээ;
 - Зүтгүүрийн бригадын ажлын дэглэмийн биелэлт;
 - Зүтгүүр ашиглалтын үзүүлэлтүүдийн биелэлт (бүтээмж, гүйлт, жин, хэсгийн хурд) ;

б. Аж ахуйн нэгжийн түвшинд:

- Нийт вагоны сул зогсолтын нормын биелэлтийг ажилбар бүрээр шинжлэх;
- Зүтгүүрийн бригадын хяналтын цэгээс аялалд явуулах хүртэлх ба аялалаас ирснээс хяналтын цэгээр өнгөрөх хүртэлх хугацааны биелэлт;
- Галт тэргийг өртөөнөөс явуулж чадаагүй шалтгаан;

Орон нутгийн ажлыг удирдах хүрээнд:

а. Дэд бүтцийн болон нэгжүүдийн удирдлагын түвшинд:

- Орон нутгийн ажлын тоон ба чанарын үзүүлэлт болон ачаа, вагон хүргэх хугацааны биелэлтэд шуурхай шинжилгээ хийх;
- Ачилт, буулгалт, орон нутгийн вагон зөөвөрлөлт ба дамжуулалтын биелэлтэд шинжилгээ хийх;
- Орон нутгийн галт тэрэгний зурмагийн болон найруулах төлөвлөгөөний биелэлт;
- Сэлгээний болон зөөврийн зүтгүүрүүдийн ашиглалт (өртөөдөөр, замаар, бүхэлд нь);

б. Өртөөдийн түвшинд:

- Орон нутгийн вагоны сул зогсолтын биелэлтийг ажилбар бүрээр шинжлэх;
- Орон нутгийн ажлын гүйцэтгэлийг шинжлэх (ээлж бүрээр) ;

12.3. Ашиглалтын ажилд хийх шинжилгээг шуурхай ба үечилсэн гэж ангилна.

Шуурхай шинжилгээ – Өнгөрсөн хоногийн гол ажилд анхаарлаа хандуулж дэд бүтцийн болон түүний аж ахуйн нэгжүүдийн ажлын үр дүнг өдөр бүр тунгаан хэлэлцэхэд чиглэгддэг. Шуурхай шинжилгээг өнгөрсөн хоногийн ажлын шуурхай мэдээ, галт тэрэгний хөдөлгөөний гүйцэтгэсэн зурмаг зэрэг материалуудыг ашиглан хийдэг.

Тухайлбал ачилтын төлөвлөгөө болон буулгалтын даалгавар, дамжуулах галт тэрэг, вагон, галт тэрэгний хөдөлгөөний зурмаг, вагон эргэлт, галт тэрэгний замналын хурд болон дэд бүтцийн зүтгүүр, вагоны ашиглалтын биелэлтийг шинжлэнэ.

Галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдал, төмөр замын техник ашиглалтын дүрмийн биелэлтэд онцгой анхаарвал зохино.

Шуурхай шинжилгээний гол зорилго нь ажлыг хэвийн явуулахад саад болсон зөрчил, дутагдлыг илрүүлэх, галт тэрэгний хөдөлгөөний болон дэд бүтцэд засвар үйлчилгээ хийх “Цонх”-ны ажлын төлөвлөгөө зурмагийг биелүүлэх, дараагийн хоногийн төлөвлөгөөг биелүүлэхэд учирч болох хүндрэлийг анхааруулахад чиглэгдэнэ.

Үечилсэн шинжилгээ – 5, 7, 10 хоног, сар, жил гэх мэт тодорхой хугацаанд хийнэ. Энэ шинжилгээ нь ерөнхий ба зорилтот байж болно. Ерөнхий шинжилгээг сар бүр хийх бөгөөд аж ахуйн нэгжүүдийн үндсэн асуудлуудыг авч үзнэ.

а. Ачилт, буулгалт, галт тэрэг, вагон солилцоо, тохируулгын даалгавар, хөдлөх бүрэлдэхүүний ашиглалт зэрэг техникийн нормуудын биелэлт;

б. Галт тэрэгний хөдөлгөөний зурмаг, галт тэрэг найруулах төлөвлөгөө, илгээгчийн ба илгээгчийн шатласан замналыг оролцуулсан төлөвлөгөөний биелэлт;

в. Ачааны зүтгүүрийн бүтээмж, хэсгийн хурдыг оролцуулсан чанарын үзүүлэлтүүдийн биелэлт;

г. Тайлант хугацаан дахь дэд бүтэц болон түүний аж ахуйн нэгжүүдийн ашиглалтын байдал (зүтгүүр, вагоны тоо, байршил, галт тэрэгний байдал) ;

д. Тээвэрлэлтийн өөрийн өртөг ба хөдөлмөрийн бүтээмж;

е. Хөдөлгөөний аюулгүй байдал;

12.4. Үечилсэн зорилтот шинжилгээгээр дээр дурьдсан ашиглалтын ажлуудын зарим тодорхой асуудлыг гүнзгийрүүлэн авч үздэг. Мөн тээвэрлэлтийн үр ашиг, хүний нөөцийн хангалт, тэдгээрийн өгөөж, хөдөлмөрийн болон үйлдвэрлэлийн сахилга зэргийг шинжилнэ.

Ашиглалтын ажилд хийх шинжилгээний үндсэн өгөгдөл статистик тоо бүртгэлийн батлагдсан маягтуудад тусгагдсан тоон болон чанарын үзүүлэлтүүдийн бодит гүйцэтгэлийн тухай мэдээ ба ачааны, техникийн болон зорчигчийн өртөөдөд төрөл бүрийн шалтгаанаар саатсан бүх галт тэрэг, вагоны мэдээ багтана.

12.5. Дэд бүтцийн хэмжээний болон түүний шугамын аж ахуй нэгжүүдэд тогтоосон техникийн нормын биелэлтэд хийх шинжилгээний тогтоосон түвшинг тодорхойлох, биелээгүй шалтгааныг тодруулах, тэдгээрийг арилгах, арга хэмжээ боловсруулах, тогтоосон нормыг давуулан биелүүлэхэд ашиглаж болох нөөцийг илрүүлэх мөн хэсэг, өртөөдийн тээх, нэвтрүүлэх, боловсруулах чадварыг дээшлүүлэхээр хэрэгжүүлсэн төслийн ажлыг үр өгөөжтэй зохион байгуулахад үзүүлсэн нөлөөг тодорхойлох зорилгоор гүйцэтгэнэ.

Тоон үзүүлэлтийн (ачилт, буулгалт, галт тэрэг вагон солилцоо, тохируулгын даалгавар) биелэлтэнд хийх шинжилгээг бодит гүйцэтгэлтэй харьцуулан тайлант хоног болон өссөн дүнгээр үнэлнэ.

Чанарын үзүүлэлтийн биелэлтэнд хийх шинжилгээг (вагон эргэлт, аялал, хэсгийн хурд, нийтийн болон нийтийн бус хэрэглээний замд вагон тавих, татахыг хүлээх хугацаа, ачааны нэг ажиллагаан дахь зогсолт, техникийн өртөөн дэх зогсолт зэрэг) техникийн төлөвлөгөөтэй харьцуулан хийнэ.

Вагоноор тээвэрлэлтийн ажил гүйцэтгэх явцад түүнд хийгдэх бүхий л үйл ажиллагааг гүйцэтгэхэд зарцуулагдах хугацааг тогтоосон хугацаатай харьцуулан шинжилвэл зохино. Үүнд:

а. Хөдөлгөөнд байсан;

б. Техникийн өртөөнд зогссон;

в. Ачааны ажиллагаа гүйцэтгэсэн;

Ашиглалтын ажлын тоон ба чанарын үзүүлэлтийн биелэлтийг 10 хоног, сар, улирал, жилээр өссөн дүнгээр гаргаж өнгөрсөн хугацааны оны мөн үеийн биелэлттэй харьцуулж дэд бүтцийн ажлын динамик хөдөлгөөнийг гаргаж үнэлэлт өгнө.

12.6. Шинжилгээ хийх үеийн ачилтын төлөвлөгөөний биелэлтийг вагоноор, тонноор, ачааны нэр, хөдлөх бүрэлдэхүүний төрлөөр гаргасан тайланг үндэслэн өнгөрсөн оны мөн үетэй харьцуулж шинжлэнэ.

Тээвэр зохион байгуулалтын нэгж ачилтын төлөвлөгөөний биелэлт, ачилтын өртөөд ачаа илгээгчийг хоосон вагоноор хангаж байгааг өдөр бүр тооцоолон шинжилнэ.

Шинжилгээ хийх хоногийн эхэнд тухайн дэд бүтцэд байсан хоосон вагоныг төрлөөр, эзэмшигчээр гаргах. Бусад дэд бүтцээс хоосноор ирэх вагон болон өөрийн өртөөдөд байгаа хоосон вагоныг тооцоолон хоосон вагоны зөөвөрлөлт, тэдгээрийг тухайн хоногт багтаан ачилтын замуудад тавьсан байдал, хоцроож хангасан, дутуу хангагдсан, цагийн тасалдал гарсан, огт хангаагүй зэрэг шалтгааныг судлан шинжилнэ.

Ачилтын төлөвлөгөө биелээгүй зарим шалтгаанд хийх шинжилгээ:

а. Буулгалтын төлөвлөгөө тасарсан, хоосон вагоны хүлээн авалтын төлөвлөгөө биелээгүй зэргээс хоосон вагон хүрэлцээгүй;

б. Хоосон вагонтой галт тэрэгний замналын хурд удааширснаас хоосон вагоны хангалт хүрээгүй. Энэ тохиолдолд ямар шалтгаанаар хурд удааширсныг, тухайлбал галт тэрэг найруулах өртөөний болон дэд бүтцийн хязгаарлалтаас болж галт тэрэгний хөдөлгөөнийг хангалтгүй зохион байгуулсан зэрэг шалтгааныг тогтооно.

в. Ачаа илгээгч ачааг төлөвлөгөөний дагуу тээвэрлэлтэд бэлтгээгүй. Энэ тохиолдолд ачилтын төлөвлөгөө биелээгүй, ачаа илгээгч бүрийн шалтгааныг тодруулна.

12.7. Өнгөрсөн тайлант хоногийн ажлын үр дүнгээр буулгалтын төлөвлөгөөний биелэлтийг өртөөд хөдлөх бүрэлдэхүүний төрлөөр гаргаж вагоныг хугацаанд нь буулгаагүй шалтгааныг тодруулна.

Өртөөдөд буулгалтын төлөвлөгөөний биелэлтийг ээлжийн турш өртөөний жижүүр шуурхай удирдлагаар хангаж шинжилнэ.

Буулгалтын төлөвлөгөөний биелэлтэд шинжилгээ хийх үед буулгах вагоны тоо, орон нутгийн ачаатай вагоны хөдөлгөөний хурд, түүний эргэх хугацаа, буулгалтын даалгаврыг биелүүлэхэд нөлөөлөх хүчин зүйлийг тодорхойлон өртөөний ажлын технологийг мөрдөнө.

Үүнээс гадна зарим өртөөдөд буулгах ачаатай вагоны урсгал ихсэх, буулгалтын төлөвлөгөөг биелүүлэхэд өртөөний болон ачилт буулгалтын замуудын техник хангамж хангалттай эсэхийг тодруулах шаардлагтай.

Дараачийн хоногийн буулгалтын төлөвлөгөөг “Төмөр замын галт тэрэгний болон ачааны ажлын шуурхай төлөвлөлт” зааврын дагуу тээвэр зохион байгуулалтын нэгж зохионо.

Буулгалтын төлөвлөгөөг биелүүлэхэд нөлөөлсөн шалтгааныг дараах байдлаар авч үзнэ.

а. Бусад дэд бүтцээс тухайн дэд бүтцэд ирэх орон нутгийн ачаатай вагон хугацаандаа ирээгүй, эсвэл өмнөх хоногийн орон нутгийн ачилтын төлөвлөгөө биелээгүйгээс буулгалтын төлөвлөгөө биелээгүй.

б. Түүвэр, зөөврийн болон дамжуулах галт тэрэгний ажлыг хангалтгүй төлөвлөж, зохион байгуулснаас сэлгээний хэрэгслэл хүрэлцээгүй өртөөдөд орон нутгийн вагонд хийгдэх ажиллагааны технологит хугацаа зөрчигдсэн зэргээс орон нутгийн ачааны зөөвөрлөлтийн төлөвлөгөө биелээгүй.

в. Ачаа хүлээн авагч буулгалтын ажлыг муу зохион байгуулсан.

Ачааны ажлын жигд хэвийн ажиллагааг зөрчихөд хүргэсэн шалтгааныг шинжилгээнд тусгана.

12.8. Галт тэрэг хүлээн авах, хүлээлгэн өгөх төлөвлөгөөний биелэлтийг тайланд тусгагдсан өгөгдлөөр техникийн үзүүлэлт ба галт тэрэг хүлээн авах, хүлээлгэн өгөх шуурхай төлөвлөгөөтэй харьцуулж тээвэр зохион байгуулалтын нэгж шинжлэнэ.

Галт тэрэг ба вагон хүлээн авах шинжилгээнд ялгалтын ба хэсгийн өртөөдөөс галт тэргийг цагт нь найруулж байгаа эсэх тэдгээрийн өнгөрүүлэлт, дамжин өнгөрөх галт тэргийг хэсгийн, техникийн өртөөдөөр хэрхэн өнгөрүүлж байгаад анхаарах хэрэгтэй.

Уулзварын өртөөдөөр вагон хүлээлгэн өгөлтөд шинжилгээ хийхээр дамжин өнгөрөх вагон оруулалт, бусад дэд бүтцийн өртөөдөд очих ачилт болон гаргалт, хоосон вагоны хүлээлгэн өгөлтөд анхаарах хэрэгтэй. Эдгээр вагон урсгалыг уулзварын өртөөдөд хүргэх хугацааны биелэлтэд шинжилгээ хийнэ.

Дэд бүтэц хоорондын уулзварын өртөөдөөр дамжуулах ачаатай вагоныг дамжин өнгөрөх вагоны тоотой, харин хоосон вагоныг тухайн дэд бүтцэд байгаа нийт хоосон вагонтой харьцуулж тодорхойлно. Өртөөдөөс явуулах галт тэрэгний тоог чиглэл бүрээр хуваарилан вагоны парктай харьцуулж тогтооно.

Дамжуулах галт тэрэгний төлөвлөгөө биелээгүй тохиолдолд дараах шинжилгээг хийнэ.

- а. Тухайн дэд бүтцийн өртөөдөд байгаа дамжин өнгөрөх вагоны байршил;
- б. Зэргэлдээх хилийн болон уулзвар өртөө галт тэрэг хүлээн авалтанд хязгаарлалт тогтоосон мөн уулзварын өртөөнөөс явуулах галт тэргийг зүтгүүрээр хугацаанд нь хангаагүй;
- в. Ялгалтын өртөөдийн галт тэрэг, задлах, найруулах ажлын чанар;
- г. Найруулсан галт тэрэгний бүрэлдэхүүнд ороогүй болон бэлэн болсон галт тэрэгний бүрэлдэхүүнд орсон вагонуудын харьцаа;
- д. Хөдөлгөөний хэмжээг зүтгүүрээр хангах, вагон урсгал нэмэгдэх үед зүтгүүрийг нэмж хуваарилах, зүтгүүрийн гэмтэл, зүтгүүрийн бригадын хангалт, баталгаат гүйлтийн хугацаа дуусаагүй байхад зүтгүүр, галт тэрэг хоорондын засварт төлөвлөгөөнөөс өмнө орох;
- е. Зүтгүүр вагоны хөдөлгөөний тохируулга;
- ё. Бэлэн болсон галт тэрэгнээс вагон салгах;
- ж. Зам засвар, барилга угсралтын төлөвлөгөөт ба төлөвлөгөөт бус ажил гүйцэтгэхээр “Цонх” олгох болон ажлын явцад гарах саатал, галт тэрэгний хөдөлгөөний хурд хязгаарласан анхаарамж;
- з. Зорчигчийн нэмэгдэл галт тэрэг өнгөрүүлэх үед ачааны зүтгүүрийг зорчигчийн галт тэргэнд явуулах;

12.9. Галт тэрэг урсгалын шинжилгээг тээвэр зохион байгуулалтын нэгж нь хөдөлгөөний хурд, хугацаа, гүйлтийн бодит биелэлтийг галт тэрэгний хөдөлгөөний замналын хурдны нормтой бүхэлд нь, үүнээс хөдөлгөөнд байсан болон сул зогссон хугацааг харьцуулан шинжилнэ. Зөрүүг дэд бүтцийн хэмжээнд болон диспетчерийн тойргоор судлана.

Хэсгээр аялсан галт тэрэгний хөдөлгөөнийг зурмагийн зөрчил гаргасан аж ахуй нэгжийг тодорхойлдог галт тэрэгний хөдөлгөөний зурмагийн гүйцэтгэлийн тайланг үндэслэн 10 хоног, сараар шинжилнэ.

Техникийн гэмтэл, саатлаас галт тэрэг замд саатсан эсвэл өртөөд хүлээн авч чадаагүй тохиолдлыг холбогдох нэгж шинжилнэ.

12.10. Орон нутгийн ачааны зөөвөрлөлтийг дамжуулалтын техникийн үзүүлэлт ба ажлын шуурхай төлөвлөлтийг үндэслэн тээвэр зохион байгуулалтын нэгж шинжилнэ.

Зөөвөрлөх орон нутгийн ачааны хэмжээ нь шинжилгээ хийх үеийн эхэнд дэд бүтцийн хэмжээнд байгаа орон нутгийн ачаатай вагон, өртөөдөөс орон нутгийн харилцаанд ачигдсан вагонууд болон зэргэлдээх дэд бүтцүүдээс тухайн замын өртөөдөд буухаар хүлээн авсан ачаатай вагоны нийлбэрээр тодорхойлогдоно.

Өртөөдөөс орон нутгийн ачаатай галт тэрэг найруулах, зүтгүүрээр хангах, галт тэргийг өртөөд болон хэсгээр өнгөрүүлэх боломж байгаа эсэхийг судлан шинжилнэ.

Орон нутгийн ачаа дамжуулах төлөвлөгөөний биелэлтийг хоногийн ажлын тайлангийн вагон солилцооны болон орон нутгийн ачааны мэдээний өгөгдлийг үндэслэн гаргана.

Зэргэлдээх дэд бүтцэд дамжуулах орон нутгийн вагоны тоо нь тайлант хоногийн эхэнд дэд бүтцийн хэмжээнд байсан орон нутгийн вагон, зэргэлдээх дэд бүтцийн өртөөдөд очихоор ачигдсан вагон болон ачаатайгаар хүлээн авах вагоны нийлбэрээр тодорхойлогдоно.

Дараа нь зэргэлдээх дэд бүтцийн өртөөдөд очих ачилт болон ачаатайгаар хүлээн авах вагоны тоо, галт тэргийг цагт нь найруулах, тэдгээрийг уулзварын өртөө хүртэл явуулах вагон урсгалыг зүтгүүрээр хангах боломж зэргийг шинжилнэ.

Тооцоолох хүчин зүйлд:

а. Зэргэлдээх дэд бүтцийн өртөөдөөс тухайн дэд бүтцийн өртөөдөд буухаар ачигдсан ачаатай вагоны хүлээн авалт ба ачилт буурснаар дамжуулалт багасахаас гадна буулгалтын төлөвлөгөөний биелэлтэд нөлөөлнө.

б. Галт тэргийг аль нэг завсрын өртөөдөд орхих нь вагон урсгалын хөдөлгөөнийг удаашруулахаас гадна ачаа хүргэх хугацаа нэмэгдэнэ.

в. Ялгалтын болон хэсгийн өртөө нь вагоноор хангаж, илүүдэл вагон үүсэх;

12.11. Ачааны ажлын хоногийн болон үечилсэн төлөвлөгөөний биелэлтийг вагоны тоо, ачааны жин, төрөл, төлөвлөгөөг бодит гүйцэтгэлтэй харьцуулан шинжлэж төлөвлөгөөнөөс зөрсөн шалтгааныг тогтооно. Ачилтын нэгдсэн захиалга болон эргэлтээр буцах вагоны тоонд шинжилгээ хийж, хөдлөх бүрэлдэхүүнээр хангаагүй шалтгааныг илрүүлнэ.

Тооцооны хоногт ирсэн хоосон вагоны байдалд хяналт тавина. Тайлант хугацаа дуусахад ачааны ажлын тайланг гаргана. Шинжилгээний дүнг төмөр замын тээврийн байгууллагын болон түүний аж ахуй нэгжийн удирдлага, галт тэрэгний болон орон нутгийн ажил, вагон урсгалыг зохион байгуулах, технологийг өөрчлөх, эдийн засгийн өгөөжийг үнэлэх, галт тэрэгний диспетчерийн болон өртөөний ээлжийн ажилтнуудын урамшуулал зэрэг асуудлыг шийдвэрлэхэд ашиглана.

12.12. Ялгалтын өртөөнөөс найруулж явуулах галт тэрэгний төлөвлөгөөний биелэлтийг дараах байдлаар шинжилнэ.

а. Галт тэргийг явуулахаар төлөвлөсөн ба явуулсан бодит хугацаа, хоногийн эхэнд дэд бүтцийн хэмжээнд байгаа тухайн ялгалтын өртөөнд очихоор галт тэрэгний бүрэлдэхүүнд орсон болон бүрэлдэхүүнд ороогүй ачаатай вагоны тоо;

б. Зэргэлдээх дэд бүтцээс тухайн ялгалтын өртөөнд ирэх вагоны тоо;

в. Хоногийн эхэнд ялгалтын өртөөнд найруулах төлөвлөгөөний чиглэлүүдээр явуулах вагоны тоо;

г. Ашиглалтын депод болон эргэх мөрөнд байгаа зүтгүүрийн тоо;

д. Дэд бүтцийн хэмжээнд өртөөдөд орхигдсон галт тэрэгний тоо;

12.13. Өртөөний ажилд шуурхай (ээлж, хоногийн), үечилсэн болон зорилтот шинжилгээ хийх бөгөөд түүнд дараах асуудлууд хамаарна.

- а. Тоон ба чанарын үзүүлэлтийн бодит биелэлтийн талаарх өгөгдөл;
- б. Төлөвлөгөөний биелэлтийг гүйцэтгэлтэй болон өмнөх үетэй харьцуулж үнэлэх;
- в. Үзүүлэлтүүд биелээгүй шалтгааныг тодруулах;
- г. Вагон цагийн байгаа нөөц ба алдагдлыг технологийн элемент бүрээр илрүүлэх;
- д. Технологийн болон цаг үеийн шинжтэй хөдөлгөөн, зүтгүүр, вагон, дохиолол холбоо, эрчим хүч, дэд бүтцийн нэгжүүдтэй холбоотой мөн түүнчлэн улс хоорондын хилийн өртөөнд хил гааль, хорио цээр, хүн мал эмнэлгийн болон цагаачийн албадтай холбоотой хүндрэлүүд хамаарна.

Ээлжийн ажлын шинжилгээг ажил дууссаны дараа өртөөний дарга эсвэл түүний орлогч хийнэ. Шинжилгээгээр галт тэрэг хүлээн авах, явуулах ээлжийн төлөвлөгөөний биелэлт, ачсан буулгасан, ялгасан вагоны тоо, вагоны сул зогсолт, галт тэрэг найруулах төлөвлөгөө ба галт тэрэгний хөдөлгөөний зурмагийн биелэлт, зурмагын тасалдал ба өртөөнд галт тэрэг хүлээн авч чадаагүй шалтгаан болон бусад тоон ба чанарын үзүүлэлтийн биелэлтийг хэлэлцэж тогтооно.

Техникийн төлөвлөгөө биелээгүй, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлын болон техник аюулгүйн дүрмийн шаардлага хангаагүй шалтгааныг тодруулна. Шинжилгээний дүнгээр ээлжийн ажилд нийтэд нь болон зарим ажилтны үйл ажиллагаанд үнэлэлт өгч илрүүлсэн зөрчлийг арилгах арга хэмжээг төлөвлөнө.

Өртөөний хоногийн ажилд хийх шинжилгээг өртөөний замын хөгжил, ялгах довын болон өртөөний бусад элементүүдийн хүчин чадлын ашиглалтанд гарсан саатал (алдагдал), вагоны сул зогсолт хэтэрсэн, галт тэргийг өртөөнд хүлээн авч чадалгүй зэргэлдээх өртөө, хоорондын замд саатуулсан, зурмагаар товлосон галт тэргийг явуулж чадаагүй эсвэл түүнийг өөрчилсөн шалтгааныг илрүүлэх зорилгоор хийнэ.

Шинжилгээний явцад дараах үзүүлэлтүүдийн биелэлтийг тогтооно.

- а. Ажиллагаагүй ба ажиллагаатай дамжин өнгөрөх вагоны тоо;
- б. Орон нутгийн ба ачааны ажиллагааны тоо;
- в. Ажиллагаагүй ба ажиллагаатай дамжин өнгөрөх вагоны сул зогсолт; (цагаар)
- г. Орон нутгийн вагоны зогсолт, үүнээс ачааны нэг ажиллагаан дахь сул зогсолт; (цагаар)
- д. Ачилт, буулгалт; (вагоноор, тонноор)
- е. Ялгах төхөөрөмжөөр боловсруулсан вагоны тоо;
- ё. Галт тэрэгний зүтгүүрийн сул зогсолт; (минутаар)

Өртөөний хоногийн ажилд хийх шинжилгээнд гүйцэтгэсэн ажлын зурмаг, довын ажлын болон галт тэрэг хүлээн авалт, явуулалтыг бүртгэх дэвтэр мөн түүнчлэн хоногт гаргадаг тайлан, мэдээний өгөгдлийг ашиглана.

Өртөөдийн ажлын дээрх үзүүлэлтүүдийн биелэлтийг;

- а. Сул зогсолтын хугацааг хэтрүүлсэн шалтгааныг албадаар;
- б. Вагоны сул зогсолтын алдагдал ба хэмнэлтийг нэгжүүдээр гаргах; Үүний тулд үйлчлүүлэгч бүрээр ачаа бэлтгээгүй, техник хэрэгсэл, талбайн багтаамж хүрэлцээгүйгээс алдагдсан вагон цагийг тусад нь хөтлөх, боломжгүй бол алдагдлыг нийтэд нь үзүүлэх;

в. Галт тэргийг өртөөнд хүлээн авч чадалгүй зурмаг тасласан галт тэрэг цагийн алдагдлыг буруутай байгууллага бүрээр;

г. Шуурхай шинжилгээний үр дүнг өртөөний болон нэгжийн удирдлага тогтмол авч хэлэлцэн өртөөний ажилд гарсан хүндрэл ба дутагдлыг арилгах, өртөөг тогтвортой ажиллуулах тодорхой арга хэмжээ боловсруулах;

Өртөөний ажилд хийх үечилсэн шинжилгээг ээлжийн ба хоногийн ажилд хийсэн шинжилгээ, өртөөний ажлын гүйцэтгэсэн зурмаг, тайлан, тоо бүртгэлийн өгөгдлийг ашиглан өртөөний ажлыг сайжруулах арга хэмжээ боловсруулах зорилгоор хийнэ.

Үүнд:

а. Галт тэрэг хүлээн авах, явуулах зурмаг ба найруулах төлөвлөгөө, ачааны ажлын биелэлт;

б. Ажиллагаатай ба ажиллагаагүй дамжин өнгөрөх болон орон нутгийн вагоны сул зогсолтын биелэлт; (ачааны нэг ажиллагаан дахь зогсолтыг үйлчлүүлэгч бүрээр)

в. Галт тэрэг хүлээн авалт, явуулалтанд хийгдэх галт тэрэг задлах, найруулах үеийн технологийн хугацааны биелэлт;

г. Техник хэрэгсэл болон сэлгээний зүтгүүрийн ашиглалт;

д. Хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх даалгаврын биелэлт;

е. Галт тэрэгний хөдөлгөөний болон техникийн аюулгүй байдал;

ё. Өртөөний үйл ажиллагаанд удирдлагаас хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт;

ж. Өртөөний ажлын чанар, үр өгөөжийг дээшлүүлэх арга зам зэрэгт бодит үнэлгээг өгөх зорилгоор өртөөний ажилд үйлдвэрлэл, эдийн засгийн дэлгэрэнгүй шинжилгээ хийнэ.

Өртөөний нэвтрүүлэх болон боловсруулах чадварыг нэмэгдүүлэхээр нөөцийг илрүүлэхийн тулд боловсруулсан техник хэрэгслийн ашиглалтыг сайжруулах, өртөөн дэх вагоны сул зогсолтыг багасгах, өртөөний үйл ажиллагааны зохион байгуулалтыг боловсронгуй болгох арга хэмжээний хүрээнд нарийвчилсан зорилтот шинжилгээ хийнэ.

Зорилтот шинжилгээ нь өртөөг нийтэд нь үгүй бол түүний зарим хэсгийн ажилд эсвэл тодорхой асуудалд чиглэгдсэн байж болно.

Үүнд:

а. Галт тэргийг зэргэлдээх өртөөнд эсвэл ойртох хэсэгт саатуулсан шалтгаан;

б. Хүлээн авсан эсвэл дамжуулсан галт тэрэгний тухай мэдээ, мэдээллийн чанар;

в. Ачаа илгээгчийн мэдээлэл;

г. Ирсэн эсвэл явуулах галт тэрэгний найруулах төлөвлөгөөний биелэлт;

д. Вагоны сул зогсолт нэмэгдсэн шалтгаан зэрэг болно.

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВЭРЛЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧДЫН ТЕХНОЛОГИЙН
НЭГДСЭН ГОРИМИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВЭРТ ХЭРЭГЛЭХ
ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

- “Төмөр замын тээврийн тухай” Монгол улсын хууль
- төмөр замын техник ашиглалтын дүрэм;
- төмөр замаар ачаа тээвэрлэх дүрэм;
- төмөр замаар зорчигч, тээш, ачаан тээш тээвэрлэх дүрэм;
- галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмаг зохицуулалтын дүрэм;
- төмөр замын өртөө, зөрлөг шинээр барих, өргөтгөх ажлыг төсөллөх дүрэм;
- төмөр замын доод, дээд бүтэц, инженерийн хиймэл байгууламж, төхөөрөмжийг шинээр барих, шинэчлэх ажлын норм, дүрэм;
- төмөр замын дохиолол, холбооны дүрэм;
- төмөр замын тээврийн салбарт гарсан сүйрэл, осол, аюулгүй байдал алдагдсан шалтгааныг шинжлэн шалгах дүрэм;
- галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын журам;
- төмөр замын өртөөг ангилах түүнд зэрэглэл тогтоох, нээх, хаах журам;
- төмөр замын дэд бүтцийн зураг төсөл боловсруулах, түүнд магадлал хийж дүгнэлт гаргах журам;
- төмөр замын дэд бүтцийн барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах журам;
- төмөр замын дэд бүтцийн хөдөлгөөнийг нээх, хаах, ашиглах, дэд бүтцийн үйлчилгээ үзүүлэх, шинэчлэх, засварлах журам;
- төмөр замын дэд бүтцийг ашиглалтад оруулсан дараа олон улсын болон орон нутгийн харилцаанд нээх, хаах, зарлах журам;
- төмөр замын зурвас газар, хамгаалалтын бүсэд тавигдах шаардлага, аюултай байгууламж байрлуулах зай, огтлолцол, байршил, нөхцөлийг тодорхойлох журам;
- төмөр замын дэд бүтэц эзэмшигч, тээвэрлэгч хоорондын харилцааг зохицуулах журам;
- төмөр замын дэд бүтэц ашиглуулах журам;
- төмөр замын тээвэрлэлт, дэд бүтэц болон хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэгийн ашиглалтын тарифыг тогтоох журам;
- төмөр замын аюултай бүс, аюулгүйн бүсэд төмөр замын болон бусад объект байрлуулах, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах, нэвтрэх журам;
- төмөр замын гарам ашиглах журам;
- төмөр замын тээвэрт хатуу тооцоот багаж ашиглах журам;
- Монгол улсын хилээр хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэгийг нэвтрүүлэх, бүртгэх журам;
- төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэгийг ашиглах, үйлдвэрлэх, засварлах, оношилгоо хийх, эдгээрийн үйлчилгээний тооцоолол, тарифыг тогтоох журам;
- төмөр замын тээврийн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг сорилт, баталгаажуулалтад хамруулахад тавигдах шаардлага, хэмжих хэрэгслийг ашиглах журам;
- төмөр замын тээвэр дэх сүйрэл, осол, аюулгүй байдлыг судалж, бүртгэх журам;
- төмөр замын тээврийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох журам;
- төмөр замын тээвэрлэлттэй холбоотой ажил, үйлчилгээ, бүтээгдэхүүнд гэрчилгээ, тохирлын үнэлгээ, баталгаажуулалтыг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх журам;
- төмөр замын тээврийн байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журам;
- төмөр замын тээвэр зуучлалын үйл ажиллагааны журам;

- аймаг, нийслэл, хотын дотор метро, хөнгөн галт тэрэг болон тэдгээртэй адилтгах төмөр замын бусад хөдлөх бүрэлдэхүүнээр зорчигч тээвэрлэлт хийх, хөдөлгөөнийг нэгдсэн удирдлагаар хангах журам;
- төмөр замын ажилтаны хөдөлмөрийн нөхцөл, сахилгын тусгай журам;
- төмөр замын мэргэжилтэй ажилтан бэлтгэх, сургалт зохион байгуулах, мэргэшүүлэх, мэргэжлийн зэрэг олгох, шалгалт авах журам;
- төмөр замын ажилтан албаны тусгай хувцас хэрэглэх журам;
- төмөр замын барилгын ажлын төсвийн жишиг норм;
- төмөр замын тээврийн хөдлөх бүрэлдэхүүн, машин механизм, техник хэрэгслийг ашиглах төсвийн жишиг үнэлгээ.